# IHC

ИНФЛЯЦИЙН
ХЭЛБЭЛЗЛЭЭС ХАМГААЛСАН
КРИПТОВАЛЮТ

# Хураангуй

Инфляци гэдэг нь аливаа арилжаа буюу мөнгөн тэмдэгтийн үнэ цэн алдагдах эдийн засгийн үзэгдэл юм. Зах зээлд мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх бүрт ийм зүйл тохиолддог. Тухайлбал, зээлдүүлэгчид шинээр хөрөнгө оруулах эсвэл төвлөрсөн системийн нөөцийн төв сан нь дахин шинэ мөнгө хэвлэх зэрэг. Инфляци тодорхой түвшинд зайлшгүй байх ёстой хэмээх ойлголтыг олон жилийн турш бид хүлээн зөвшөөрч ирсэн. Зарим эдийн засагчид бага зэргийн инфляцийн түвшин иргэд, бизнес эрхлэгчдийг мөнгөө хадгалахаас илүүтэй хэрэглэж, гүйлгээнд оруулдаг учир эдийн засаг эрүүлжихэд хэрэгтэй хэмээн тайлбарлаж ирсэн.

Нөгөө талаар, инфляцийн түвшин өндөр байх нь эдийн засагт гамшиг болдог. Инфляци, тэр дундаа зах зээлийн манипуляциас үүссэн тохиолдолд эрүүл зах зээлээс эрүүл бус зах зээлийн түвшинд хэзээ шилжихийг урьдчилан таамаглах тодорхой арга байдаггүй.

**Энэхүү танилцуулгад эдгээр ухагдахууны талаар дэлгэрэнгүй өгүүлж, инфляцийн хор нөлөөнөөс хамгаалах, бага хохиролтой гарах зорилготой бидний төвлөрсөн буюу төвлөрсөн бус шийдэл болох Инфляци Хэджинг Криптовалют (цаашид IHC гэх)-ыг танилцуулна.**

# Ирээдүйд чиглэсэн мэдэгдлүүдийн талаар анхааруулах нь

Уг танилцуулгат багтсан бүх мэдэгдэл, Удирдлагууд, Гүйцэтгэх ажилтнууд эсвэл бидний өмнөөс үүрэг гүйцэтгэж байгаа ажилтнуудын хийсэн ба хийх хэвлэлийн болон аман мэдэгдэл зэрэг нь түүхэн баримт биш бөгөөд "ирээдүйд чиглэсэн мэдэгдэл" болно. “Хүлээлт”, “таамаглал”, “зорих”, “урьдчилан тооцоолох”, “ирээдүй”, “болно”, “магадгүй”, “төлөвлөж байна” гэх утга агуулсан мэдэгдлүүд нь дээр дурдсан “ирээдүйд чиглэсэн мэдэгдэл”-д тооцогдоно. Танилцуулгат бидний зүгээс дурдах орлого, ашиг, төлөвлөсөн өргөтгөл, зах зээл болон салбарын тренд, хандлага, төслийн гол үе шатуудтай холбоотой огноо, гүйцэтгэх хугацаа, бусад сэдэв нь түүхэн баримт биш бөгөөд урьдчилсан таамаглал юм.

Ирээдүйд чиглэсэн мэдэгдэлд агуулсан үр дүн, гүйцэтгэл болон амжилтуудын бодит үр дүн, гүйцэтгэлд нөлөөлж болохуйц мэдэгдэж байгаа болон үл мэдэгдэх эрсдэл, тодорхой бус нөхцөл байдал зэрэг, бусад хүчин зүйлс гарч болзошгүй. Эдгээр эрсдэлийн хүчин зүйлсийг уг Танилцуулгын 99-109-р хуудас дахь “Эрсдэлийн хүчин зүйлс” хэсэгт дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Иймд эл Танилцуулга дахь мэдэгдлүүд нь бидний хяналтаас гадуур, том цар хүрээний тодорхой бус нөхцөл байдлуудаас хамаардаг хүчин зүйлс, таамаглалуудад үндэслэсэн “ирээдүйд чиглэсэн мэдэгдэл”-үүд гэдгийг та бүхэн анхаарна уу.

# Ирээдүйд чиглэсэн мэдэгдлүүдийн талаар анхааруулах нь

Ирээдүйд чиглэсэн Танилцуулгын мэдэгдэл нь таамагласан, тооцоолсон болон дам илэрхийлсэн үр дүн, гүйцэтгэл, амжилтуудын бодит үр дүнд ихээхэн нөлөөлж болзошгүй эрсдэл, тодорхой бус нөхцөл байдал үүсэж болохыг харгалзан үзэж эдгээр мэдэгдэлд хэт их найдлага тавихгүй байхыг танд зөвлөж байна. Компаний үйл ажиллагаатай холбоотой менежментийн баг, зөвлөх, хувь хүн, хуулийн этгээдийн хийсэн мэдэгдэл нь ирээдүйн үр дүн, гүйцэтгэлд бодит байдал дээр бүрэн биелнэ гэсэн баталгаа өгөхгүй болохыг анхаарна уу.

Бидний зүгээс тодорхойлж байгаа эрсдэлийн хүчин зүйлсийн талаар тус Танилцуулга дахь “Эрсдэлийн Хүчин Зүйлс” хэсгээс танилцана уу.

Эдгээр ирээдүйд чиглэсэн мэдэгдлээр илэрхийлсэн үр дүн нь бидэнд тулгарч болзошгүй эрсдэлүүдийн улмаас бодит байдал дээр ихээхэн өөр байж болзошгүй. Бид болон Менежментийн баг ирээдүйд үүсч болох нөхцөл байдал, үйл ажиллагаа, хүчин зүйлсээс хамааран мэдэгдэлд өөрчлөлт оруулах, шинэчлэх хариуцлага хүлээхгүй болно.

# Борлуулалтын хориг

Энэ Танилцуулгаар IHC-ыг худалдаж авахыг уриалаагүй, санал хүсэлт тавиагүй болно. АНУ, Их Британи, Хятад, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг улс оронд ийм төрлийн санал, хүсэлт, урилгыг хууль бус үйлдэлд тооцдог. Уг Танилцуулга болон IHC койны анхлан санал болгох IEO-г тодорхой улс орнуудад түгээхийг холбогдох хууль тогтоомжоор хязгаарлаж болно. Эл мэдээлэлтэй  танилцаж буй аливаа этгээд эдгээр хуулийн хүрээний хязгаарлалтын талаар өөрийн хариуцлагын хүрээнд мэдээлэл авч,  дагаж мөрдөхийг тус компаний удирдлагаас хүргүүлж байна.

# Гарчиг

1. Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо (DeFi) болон Криптовалютын өнөөдрийн дүр төрх
2. Инфляцийн тухай ойлголт
3. Бидний шийдэл
4. Блокчэйн Солилцох Протокол
5. Дефляцийн зарчим
6. Ийлд ферминг ба Арилжааны төвлөрсөн бус тогтолцоо
7. Өнөөгийн түүх ба ойрын ирээдүй
8. Монгол болон дэлхий дахины хөрөнгө оруулалтын хэрэгсэл
9. Техникийн танилцуулга
10. Бидний төлөвлөгөө
11. Бидний токеномик
12. Бидний технологи
13. Манай баг
14. Манай зөвлөхүүд
15. Хуулийн хариуцлага эс үүрэх талаарх мэдэгдэл
16. Токеномикс
17. Ихбит эцсийн өмчлөгчдийн мэдээлэл
18. Ихбит хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
19. Санхүүгийн аудитлагдсан тайлан
20. Технологийн Аудитын Дүгнэлт

# ТӨВЛӨРСӨН БУС САНХҮҮГИЙН ТОГТОЛЦОО (DEFI) БОЛОН КРИПТОВАЛЮТЫН ӨНӨӨДРИЙН ДҮР ТӨРХ

01

## 1-р Хэсэг. Гол агуулга:

### Дэлхийн эдийн засагт тохиолдсон томоохон гамшгуудын нэг Их Хямрал нүүрлэхэд, түүнээс зугтах боломж бараг үгүй байв. Эдийн засгийн систем 19-р зууны эхэн үеэс аажмаар нэгэн цул болсоныг тухайн үед хүмүүс мэдээгүй байжээ.

Дэлхийн томоохон эдийн засгуудын хөрөнгийн зах зээлийн уналтын үр дүн манай гаригийн өнцөг булан бүрт асар хурдан үр нөлөөгөө үзүүлсэн хямрал байв. Америкийн төв бүс нутгийг дайрсан шороон шуурга, ган болсноос үүдсэн “Тоосон Тагш” хэмээх хөдөө аж ахуй, газар тариалангийн хямралаас эхлээд Японы банкны салбарын хямрал гээд Их Хямралд өртөөгүй үлдсэн улс орон үгүй байв. Эдийн засгийн хямрал дэлхий нийтийг хамарсаныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Нөөц баялгийн бууралт, үнийн өсөлтийн тодорхой бус нөхцөл байдал нь эдийн засгийн төвлөрсөн тогтолцооны эрин эхэлснийг харуулсан билээ.



Их Хямралын дараахан удалгүй улс орны удирдагчид эдийн засгаа сэргээх оролдлогуудыг хийж эхэлсэн ч тэд дотоодын бизнесийн салбарын лидерүүдтэй хамтрах, түнш улс орнуудтайгаа худалдааны шинэ гэрээ байгуулах зэрэг сурсан, хэвшсэн хуучин аргуудаа хэрэглэж байсан нь огт үр дүнгээ өгөөгүй.

Их Британийн засгийн газар эдийн засгаа идэвхжүүлэх зорилгоор усан онгоцны үйлдвэрүүдэд зээл санал болгосон ч амжилт олоогүй бөгөөд эдийн засгийг маш хурдан хямраасан хомсдолыг арилгахад хангалттай биш байв. Бусад улс орнууд өлсгөлөн, хавтгайрсан ажилгүйдлээс зугтахын түүс болж айдаст автсандаа “үлгэрийн” гэмээр хийсвэр амлалтууд өгсөн хэт туйлшрагч буюу экстремист засгийн газруудад санал өгөх болсон байна.



Эдийн засгийн уналтын хариуд олон улс орон шинээр мөнгө хэвлэж эхэлсэн. АНУ-ын алтан стандарт нь Испанийн алтан дублон, эртний Ромын денариус ауреус буюу алтан зоосны зарчимд шилжив. Ингэснээр Засгийн газрын зүгээс иргэдийн их хэмжээний алт өмчлөх эрхийг хууль бус болгож, хэвлэгдсэн мөнгөний нэгж бүрийг тодорхой тогтоосон жингийн алтаар баталгаажуулдаг алтан стандартыг бий болгов.

Тухайн үедээ энэ үйлдлээрээ эдийн засгийн тогтолцооны үндэс суурь болох инфляциар тоглож байгаагаа ойлгох хүн цөөхөн байв. Тэд мөнгө хэвлэснээр инфляцийг хурдасгаж, харин нэвтрүүлсэн алтан стандарт нь эдийн засгийг эсрэг урсгалд оруулж, зээлийн чадавхи, эдийн засгийн өсөлтийг сааруулж байв. **Өнөөгийн эмч нар дундад зууны анагаах ухааны судас ханах эмчилгээг үр дүнгүй, болхи эмчилгээ гэж үздэгтэй адил өнөөгийн бид дээрх эдийн засагчдын оролдлогуудыг болхи, хуучны арга байсан болохыг ойлгож эхэлж байна.**



Төвлөрсөн тогтолцоонд мөнгө нэмж хэвлэх нь оновчтой, зөв шийдэл мэт санагдаж магадгүй. Манай удирдагчид богино хугацааны шийдлүүдийг илүүд үзэж, тухайлбал "Мөнгө нэмээд хэвлэж болох юм чинь яагаад үгүй гэж" гэсэн бодолтой хэрэгжүүлдэг. Үүнээс илүү үнэ цэнтэй шийдэл хаана байна? гэдэг асуулт төвлөрсөн тогтолцооноос өөр сонголт эрэлхийлэхэгийг бидэнд тулгаж байна.

Криптовалютыг хөрөнгө оруулалтын багцдаа нэгтгэж байгаа томоохон сангууд болон банкуудын тоо өсөх тусам, жижиг хөрөнгө оруулагчид төвлөрсөн бус санхүүжилтийн (DeFi) ашиг тусыг өргөн хүрээнд мэдэрч мэдэхийн хэрээр бидний амьдарч буй эрин үеийн ач холбогдлыг ойлгох нь чухал болж байна.
Түүхэнд анх удаа хүмүүс уламжлалт эдийн засагт оролцох эсэхээ сонгох боломжтой болж байна. Төвлөрсөн тогтолцооны бүтээсэн цөөн хэдэн бүтээгдэхүүнийг сонгохын оронд санхүүгийн шинэ хэрэгсэл болох цахим мөнгийг анхлан нэвтрүүлж, ашиглах нь төвлөрсөн тогтолцоо болон түүнтэй холбоотой нарийн төвөгтэй үйл ажиллагааны сөрөг нөлөөнүүдээс нэг алхам холдох боломж бүрдэж байна.



Энэхүү боломжийг бүрэн ашиглахын тулд юуны түрүүнд бидэнд ямар сонголтууд байгааг сайн ойлгох нь чухал юм. Том зургаар нь харвал, төвлөрсөн бус санхүүжилт DeFI буюу криптовалют болон блокчэйн технологи нь зөвхөн одоогийн санхүүгийн тогтолцоог сайжруулаад зогсохгүй санхүүгийн цоо шинэ бүтцийг санал болгож байгаа билээ. Хөрөнгө оруулагчид төвлөрсөн тогтолцооны ажиллах зарчим болон төвлөрсөн бус тогтолцооны ялгааг анхаарч ойлгохгүйгээр өөрсдийн фиат буюу мөнгөн дэвсгэртийг криптовалютад хөрвүүлэн арилжаа хийгээд, буцаан уламжлалт мөнгөний нэгжиндээ хувиргаж хэрэглээд байвал энэ шинэ тогтолцооны давуу талуудыг бүрэн ашиглаж чадахгүй болно.

Жишээ болгоод анхны бөгөөд хамгийн сайн танигдсан криптовалют болох биткойныг авч үзье. 2009 онд анх гарсан энэ криптовалют нь онолын хувьд, төвлөрсөн бус тогтолцооны бүх амлалтыг агуулсан бүтээгдэхүүн болсон билээ. Энэ нь ч хүмүүст таалагдсаныг бид биткойны сүүлийн 4 жилийн огцом өсөлтөөс харж болно. Өнөөдөр, биткойны үнэлгээ 800 тэрбумаас 1 их наяд ам.долларын хооронд хэлбэлзэж байгаа нь олон жижиг улс орны эдийн засгийн хэмжээг хол даваад байна.



2021 оны 6-р сард Эл Салвадор улсын засгийн газар биткойныг хүлээн зөвшөөрч албан ёсны төлбөрийн хэрэгсэл болгож буйгаа мэдэгдсэн. Энэ нь DeFi болон криптовалютад  шинэ эринг авчирсан бөгөөд тун удахгүй бусад улс оронд өргөн хүрээнд хүлээн зөвшөөгдөх эхлэлийг тавьсан  нэгэн чухал алхам болов. Зах зээл дээр криптовалютын эрэлт, хэрэгцээ огцом өсч, хурдацтай өөрчлөгдөх нь хэвийн үзэгдэл болж эхэллээ.

2017 онд биткойныг хүмүүс анх өргөн хүрээнд мэдсэнээс хойш түүний үнэ огцом өссөн. Тухайн жилийн 12-р сард биткойн бүх цаг үеийн дээд үнээ даван 19,800 ам.долларт хүрээд 7 хоногийн дараа огцом унан 11,000 ам.доллар болжээ. 2018 оны 1-р сар гэхэд үнэ улам доошилсоор 3,900 ам доллар ч хүрэхгүй болов.

2020 ба 2021 онуудад үнэ нь огцом бөгөөд өршөөлгүй гэж хэлмээр хэлбэлзсэн. 2020 оны 3-р сарын уналт болон 2021 оны 3-р сарын бүх цаг үеийн дээд өсөлт, 2021 оны 5-р сард дахин уналтанд орсон нь хөрөнгө оруулагчдын зүгээс хүлээлтээ дарах нь зүйтэй мэт санагдах болсон. Тэдний шүүмжлэлүүд байгаа оносон мэт санагдаж байсан нь дамжиггүй.



Биткойны үнэ цэнд түүний үнийн дүн буюу хөрөнгө оруулагчдын богино хугацаанд олохыг хүссэн ашгийн хэмжээгээр хязгаарлагдахгүй нэгэн хүчин зүйл байдаг. Энэ нь криптовалютын инфляцид өртдөггүй байдал нь юм. Зөвхөн эл зүйл л хөрөнгө оруулагчдыг өөрийн эрхгүй татдаг. Олон хүн өнгөрсөн 10-аад жилийн турш биткойноор өөрсдийн хөрөнгө, баялгийг бүтээж чадсан. АНУ-ын Холбооны Нөөцийн Банк болон бусад орны засгийн газар зах зээлийн манипуляци ихээр хийж байгаа энэ цаг үед ийнхүү инфляциас хамгаалагдах нь маш чухал.

АНУ-ын Худалдааны Яамнаас гаргасан тооцоог харахад 2021-2023 онд инфляцийн түвшин 1993 оноос хойш буюу сүүлийн 30 жилд тохиогоогүй өндөр түвшинд хүрэхээр байна. Биткойн болон криптовалютаас ч илүү инфляцийн аюулын талаар яаралтай ярилцаж, шийдэмгий арга хэмжээ авах  ёстой сэдэв болоод байна.



Бидний санал болгож байгаа шийдлийг ярилцахаас өмнө инфляцийн талаар аль болох гүнзгий ойлголттой болох нь чухал юм.

# ИНФЛЯЦИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

02

АНУ-ын эдийн засгийн эрх мэдэл, нөлөөг ярилгүйгээр дэлхийн эдийн засгийн тогтолцоо,  инфляцийн талаар тайлбарлах боломжгүй юм. АНУ-ын эдийн засаг дэлхийн нийт баялгийн дөрөвний нэгийг эзэлдэг. Дэлхийн томоохон банкуудын арилжаа америк доллараар хийгдэж байгаа нь АНУ-ын эдийн засагт гарах аливаа өөрчлөлт тухайн улсын хил хязгаараас халин гарч дэлхийн өнцөг булан бүрт өргөн хүрээнд нөлөөлдөг болсныг харуулж байна.

Ийнхүү АНУ-ын эдийн засаг дахь инфляцийн өөрчлөлт дэлхий даяар давалгаалан нөлөөлдөг нь мэдээж  маш том асуудал: АНУ-ын Холбооны Нөөцийн Банк дотоодын эдийн засгийн асуудлаа шийдвэрлэхийн тулд мөнгөн дэвсгэрт нэмж хэвлэх нь инфляцийг өсгөнө.



Дэлхийн эдийн засагт Холбооны Нөөцийн Банк удирдан чиглүүлэх, заримдаа зохион байгуулах Холбооны Нөөцийн Банк дэлхийн эдийн засгийг удирдан чиглүүлэх, заримдаа бүр зохион байгуулах үүрэг гүйцэтгэж ирсэн. Аливаа зээл болон хөрвөх чадвартай холбоотой асуудал гарахад ХНБ оролцож шийдвэрлэдэг.

ХНБ дэлхийн эдийн засагт гарсан аливаа бэрхшээлийг муйхраар шийдвэрлэхэд бэлэн байдгаа удаа дараа харуулсан бөгөөд зарим улс орон, байгууллагуудад нээлттэй зээл өгөхийн тулд шинээр мөнгө хэвлэдэг. Хэрэв дээрх зээлдэгчид дампуурвал эргээд энэ нь дэлхийн эдийн засгийн тогтвортой байдалд шууд нөлөөлөх аюултай.

**Гол асуудал нь, ХНБ мөнгө хэвлэх замаар зээлийн асуудал, хөрвөх чанарын хомсдол болон бусад асуудлыг шийдэж болох авч инфляцийг ингэж хүчээр шийдэж болохгүй. Инфляци нь ийм төрлийн санхүүгийн тогтолцооноос шалтгаалдаг болох нь жам ёсны үзэгдэл юм.**




ХНБ ямар нэгэн зорилгоор мөнгө нэмж хэвлэх нь системд шууд дарамт нэмнэ гэсэн үг. Хэт их дарамт нь инфляцийг огцом өсгөж, бараа материал, үл хөдлөх хөрөнгө зэргийн үнэлгээг унагаадаг.  ХНБ нь хэвлэсэн мөнгөө буцаан татан авах замаар өөрийн үйлдлээ засахыг оролддог боловч хэдий хэмжээнд өөрөө өөрийгөө хянаж, барих дээр тогтсон зөвшилцөл байдаггүй.

Энэ бол мэдээж итгэлцлийн асуудал. Эдийн засгийн тогтолцоо нь ХНБ-ны өөрөө өөрийгөө зохицуулах чадвараас хамааралтай байх нь нэг ёсондоо хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн зах зээлийн манипуляциас шалтгаалж байна гэсэн үг. Энгийнээр тайлбарлахад, ХНБ-ны зүгээс сүүлийн жилүүдэд түлхүү ашиглах болсон бэлэн мөнгөний нийлүүлэлт, тэгд дөхсөн маш бага зээлийн хүү зэрэг нь ирээдүйгээсээ зээлэх оролдлогууд билээ. Инфляци өсөх нь эргэлзээгүй. Гол нь инфляци хэр хурдан өсөх, инфляцийн хурдыг эдийн засгийн тогтолцоо нь тэсч гарч чадах эсэх нь хамгаас чухал асуултууд юм.

Түүхийн туршид хөрөнгө оруулагчид инфляцийн нөлөөнөөс өөрсдийгөө хамгаалахын тулд янз бүрийн хэрэгсэл ашиглаж ирсэн. Энэ үйлдлийг "инфляци хэджинг" хийх буюу инфляцийн хэлбэлзлээс хамгаалах гэж нэрлэдэг бөгөөд энэ нь манай блокчэйнд суурилсан хэрэгслийн нэр билээ.
Инфляцийн хэлбэлзлээс хамгаалах хамгийн түгээмэл хэрэгслүүдийн нэг бол алт байсан бөгөөд 1970-80-аад оны зарим судалгаагаар тухайн үеийн маш өндөр түвшний инфляцийн эсрэг үр дүнгээ өгсөн хэрэгсэл байв. Харамсалтай нь үүнээс хойш алтны инфляцийн хэлбэлзлээс хамгаалах чадвар нь хүлээлтэнд хүрэхгүй болсныг хийгдсэн анализууд харуулсан бөгөөд ам.долларын хөдөлгөөнтэй уялдаа сул болсон байна.



Инфляци бол шинэ ухагдахуун биш билээ. Монгол Их Юань гүрний засгийн газар мөнгө нэмж хэвлэх замаар өсөн нэмэгдэж буй зэвсэгт хүчний төсвөө тэнцвэржүүлж байв. Юань гүрнийг мөхөлд хүргэсэн хүчин зүйл нь инфляци гэж зарим түүхчид үздэг бөгөөд үүний хариуд Мин улс цаасан мөнгийг шууд хориглосон байдаг. Ингэх нь инфляцийн байж болох хамгийн муу үр дагавар хэмээн урьдчилан тооцоолсон хүмүүст боломжийн шийдэл мэт санагдаж ч магадгүй. Хүн бүрийн цаасан мөнгөн дэвсгэртийг алт, мөнгөн зоосоор сольж чадвал бид дараагийн хямралаас урьдчилан сэргийлж магадгүй л юм.



Мэдээж ийм сонголт бидэнд байхгүй. Инфляци гэх үзэгдэл төвлөрсөн эдийн засгийн тогтолцоонд зайлшгүй үүсдэг болохыг түүх бидэнд харуулсан. Мали улсын 14-р зууны түүхэн тэмдэглэлүүдээс харахад Манса Муса Хаан Мекка руу аялах үеэрээ Египетээр дайран өнгөрч тус улсын эдийн засгийг хэдэн жилийн турш хямруулах үйлдэл хийжээ. Тэрээр өгөөмөр зан гарган Египетчүүдэд ихээхэн хэмжээний мөнгө тараасна с бараа бүтээгдэхүүний үнэ униалтанд орж, удаан үргэлжилсэн инфляцийг эхлүүлсэн байна.



## Энд дурдахад, инфляци нь маш тодорхой нөхцөл байдалд эерэг гэж томъёолж болох зүйл юм. Эдийн засгийн аливаа тогтолцоонд инфляци өсөлтөөс давсан тохиолдолд л сөрөг байдаг.

Өсөн нэмэгдэж буй эдийн засгийн эрэлт хэрэгцээг хангахуйц валют байхгүй тохиолдолд зээлдэгчид болон зээлдүүлэгчид өөрсдийн хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан санаачилга, бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг босгох боломжгүйд хүрдэг.

Дэд бүтэц инфляцид бодитойгоор тулгуурладаг боловч уг харилцан хамаарал нь харьцангуй бага байдаг учир эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд төвлөрсөн зохицуулагчдын ашигладаг илүүдлийг дэд бүтэц бий болгодоггүй.

Инфляцийн аюул зөвхөн онолын төдий зүйл биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Инфляци гиперинфляци болж хувирахад юу болдогийг бид бүгд харсан. Дэлхийн 2-р дайны дараа Унгар улсын засгийн газар инфляцийг хуулиар зохицуулах оролдлого хийж иргэддээ татвар ногдуулж эхэлсэн. Саяхны жишээнээс дурьдвал, 1998 онд Зимбабве улсад инфляцийн түвшин 47%-д хүрсэн нь 2007 он гэхэд гиперинфляци болж, тус улсын мөнгөн тэмдэгт хэвлэсэн өртгийнхөө үнээс ч хямд болсоноор ард иргэд амь зогоох хоол хүнсээ ам.доллар зэрэг гадаад валютаар авахаас өөр аргагүй байдалд орсон.




Энэ бүхний эцэст, инфляци ямар хор нөлөөтэй, түүнийг удирдах боломж үгүй болохыг ойлгосны дараа бид инфляциас өөрсдийгөө хамгаалах шинэ арга замыг зайлшгүй эрэлхийлэх шаардлагатай болж байна.

# БИДНИЙ ШИЙДЭЛ

03

**Юуны түрүүнд, бидний зүгээс дараах зүйлийг тодорхой хэлэх нь зүйтэй. Инфляци Хэджинг Криптовалют буюу IHC нь криптовалютыг цоо шинээр дахин бүтээх эсвэл өөрсдийн блокчэйн технологийг боловсруулах оролдлого биш юм.**

Харин бид IHC-ыг уламжлалт, төвлөрсөн эдийн засгийн системээс гадуур ажиллах боломжийг олгодог, Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны үндсэн зарчмуудыг агуулсан санхүүгийн хэрэгсэл гэж харж байна.

Бидний шийдэл бол уламжлалт эдийн засагт нүүрлэсээр байгаа инфляцийн асуудал, мөн криптовалют болон Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо (DeFi)-нд саад болж байгаа ерөнхий асуудлуудын хариу юм. Сүүлийн 10 жилийн хугацаанд блокчэйнүүд улам бүр түгээмэл болж, дутагдал доголдлууд нь илрэхийн хэрээр цар хүрээгээ тэлэх, сайжруулахад бэрхшээлтэй тулгарсаар ирсэн.

**Олон төслүүд өөрсдийн тэлэх чадварын талаар томоохон амлалтуудыг өгч байсан боловч ихэнх нь амлалтандаа хүрч чадахгүй байна.**



Бидний харж байгаагаар Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо (DeFi)-ны боломжийг бүрэн ашиглаж чадсан криптовалют одоогоор байхгүй байна. Инфляци Хэджинг Криптовалют буюу IHC-ыг ирээдүйд бэлтгэгдсэн, хөрөнгө оруулагчдаа урт хугацаанд хадгалж үлдэхийн тулд бид Блокчэйн Солилцол Протокол хэмээх шинэ концепцийг боловсруулсан бөгөөд үүний талаар дараагийн хэсэгт дэлгэрэнгүй танилцуулах болно.

Инфляцийн эсрэг буюу дефляцийн онцлогийн талаар хожим дэлгэрэнгүй танилцуулна.  IHC-ын хамгийн дэвшилтэт онцлогуудын нэг нь шаардлагатай үед шинэ блокчэйн рүү маш хялбар байдлаар шилжих чадвар юм.

Ингэснээр бид эрчим хүчний үр ашиггүй байдал ба байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөгөөрөө ихээхэн шүүмжлэл дагуулдаг биткойны алдаа болон хөгжүүлэгчдэд ухаалаг гэрээг нь ашиглахад улам бүр үнэтэй болоод буй Этириумын алдааг давтахгүй.





Төвлөрсөн бус эдийн засгийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх зорилготой бидний Инфляци Хэджинг Криптовалют (IHC) нь тогтвортой байдал, урт хугацаанд байр сууриа хадгалах чадвараараа хөрөнгө оруулагчдаа татна гэсэн зорилтын илэрхийлэл юм.

## Хөрөнгө оруулагчдад бид богино хугацаанд ашиг олох бус харин өгөөж, хадгаламж байдлаар ашиглаж болох найдвартай хэрэгсэл бий болгохыг зорьж байна. Манай технологи үргэлж IHC-ын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын төлөө ажиллах болно.

Ил тод байдлыг эрхэмлэх үүднээс IHC-ын талаар баримтлах удирдамжуудыг боловсруулсан болно. Бид хүлээн авагч болон илгээгч хоёрын аль алинаас нь шимтгэл тооцох бөгөөд цугларсан шимтгэлийг IHC токенийг эзэмшиж байгаа хэрэглэгчдэд өдөр тутам хуваан тараах зарчмыг хэрэгжүүлнэ. IHC-ын апп нь Блокчэйн хэтэвч болон Байнанс Смарт Чейний (ирээдүйд өөрчлөгдөж болно) төвлөрсөн бус бирж дээр суурилах бөгөөд тус биржээр дамжуулан токен эзэмшигчид койноо солих, зээлэх, зээлийн өгөөж хүртэх зэрэг үйлдлийг хийх боломжтой болно.




Зах зээл дээр анхны 1 их наяд токен шатаж багассаар нийт токен эзэмшигчдийн тоотой тэнцэх хүртэл үргэлжлэх токен шатаалтын үеэс гүйлгээний шимтгэл 0.5%-аас 1% болж багасна.

**Гүйлгээний шимтгэлийг хуваарилан тараах явц тогтмол үргэлжлэх бөгөөд энэ нь токен эзэмшигчдийг IHC-ын экосистемд үргэлж оролцоотой, идэвхтэй байхад хөшүүрэг болно хэмээн үзэж байна.**

Хэдий чинээ их тооны хэрэглэгчидтэй болно төдий чинээ ашиг тусаа өгдөг ихэнх Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны хэрэгслүүдээс IHC дараах гурван онцлогийг үндсэн тогтолцоондоо шингээснээрээ ялгаатай:

Блокчэйн солилцох протокол, дефляцийн зарчим, төвлөрсөн бус байдал эдгээрийн талаар цаашид дэлгэрэнгүй тайлбарлана.

## Уламжлалт мөнгөний нэгж ба Инфляци Хэджинг Криптовалют

Хоёр этгээдийн хооронд цахим болон биетээр хийгдэх ямарваа нэгэн материал солилцоо ихэвчлэн үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдээр дамждаг. Түүхэнд мэдээж ийм арилжаанд гуравдагч этгээд оролцдоггүй байсан. Тэгвэл өнөөдөр санхүүгийн үйлчилгээний салбарт гуравдагч үйлчилгээ үзүүлэгч маш олон байгууллага бий болсон. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад энэ нь маш ашигтай байдаг бөгөөд дэлхий даяарх гүйлгээний гол стандарт болжээ. Блокчэйн технологи нэвтэрснээр хоёр этгээдийн хооронд гүйлгээ хийхэд үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээд шаардлагагүй.

Блокчэйн технологид суурилсан Инфляци Хэджинг Криптовалют нь тасралтгүй гүйлгээ хийх чадвартай санхүүгийн үйлчилгээний экосистемийг нэвтрүүлэхэд оршино.
Манай уугуул буюу нэтив апп нь yield farming/ийлд ферминг буюу токеноо зээлүүлж өгөөж хүртэх, зээл авах үйлчилгээг нэвтрүүлснээр санхүүгийн үйлчилгээний гол төв болно.

# БЛОКЧЭЙН СОЛИЛЦОХ ПРОТОКОЛ

04

# Инфляци Хэджинг Криптовалютын үндсэн онцлогуудын нэг нь Блокчэйн Солилцох Протокол юм.

Энэ онцлох давуу тал нь IHC-ын уян хатан, тэсвэртэй байдлыг хангах бөгөөд хөрөнгө оруулагч Инфляци Хэджинг Криптовалютыг ашигласнаар хөрөнгө оруулалтаа найдвартай, аюулгүй байлгах боломжтой. DeFi ертөнцөд хоцрогдох нь ямар аюултай болохыг бид харсаар байна. Блокчэйнүүд эдийн засгийн үр ашигтай байдал, тэлэх чадварын хувьд саад бэрхшээлүүдтэй тулгарах тусам тэдгээрийг блокчэйн сонгосон хөрөнгө оруулагчид, хөгжүүлэгчид алдагдал хүлээн өөр сонголт руу шилжих эсвэл тухайн төсөл дампуурсныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрч байна.



Энэ бол бидний хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй зүйл юм. Хөрөнгө оруулагчид IHC-ыг сонгосноор оруулсан мөнгө нь тогтвортой, найдвартай байна гэсэн итгэлийг бидэнд өгч байгааг бид ойлгодог. Бид энэхүү итгэлийг алдах юм бол, тэдний амьдралд төвлөрсөн тогтолцооноос үүдсэн асуудлуудыг шийдэх ажлаа бид хийхгүй байна гэсэн үг.

## Ийм ч учраас бид Байнансаас Этириум 2.0, Кардано болон салбартаа тэргүүлэгч бусад блокчэйн руу шилжихэд хялбар болгож байгаа билээ.



Инфляци Хэджинг Криптовалютын үндсэн хөгжүүлэлтийн баг ухаалаг гэрээний хамгийн сүүлийн үеийн, хамгийн дэвшилтэт Блокчэйнуудыг байнга эрэлхийлж, судалж байх болно. Блокчэйн Солилцох Протоколын ачаар бид нэг Блокчэйнээс нөгөө Блокчэйн руу маш хурдан бөгөөд мэдэгдэхгүй шахам шилжих боломжтой юм.

**Бид ухаалаг гэрээний үндсэн Блокчэйн бүрийн үр дүнтэй байдал, өртгийн үр ашигтай байдлын талаар нарийвчилсан тойм, дүн шинжилгээ хийж, энэ үйл явцыг жил бүр дахин эхлүүлж, шинээр гарч ирж буй хамгийн сүүлийн үеийн технологиос хоцрохгүй байх болно.**

Блокчэйн Солилцох Протоколоор бид бүтэн эсвэл хэсэгчилсэн шилжилтүүдийг хийх боломжтой болох юм. Хэрэв тодорхой нэгэн ухаалаг гэрээнд шилжих нь бидэнд ашигтай гэж дүгнэвэл энэ сонголтыг боловсруулан судлах болно. Энэ нь сүүлийн дөрвөн жилд блокчэйнд тулгарч буй тэлэлтийн асуудлыг шийдэх бидний аргачлал юм.

Бид эдгээр асуудлаас бүрэн зайлсхийж чадахгүй байсан ч Инфляци Хэджинг Криптовалютыг тухайн үед хамгийн тохиромжтой ухаалаг гэрээний Блокчэйний давуу талыг ашиглаж хамгийн боломжтой хувилбараар байршуулж чадна.

Нэмж дурдахад, хөгжүүлэлтийн үндсэн багаас гаргах шийдвэрүүд хэзээ ч нэг талыг барихгүй. Ухаалаг гэрээний шинэ блокчэйнд шилжих үед бид токен эзэмшигчдээ татан оролцуулах төлөвлөгөөтэй байна. Хэдийгээр бид бие даан дүн шинжилгээ, анализ хийх боловч шинэ блокчэйнийг бүрэн буюу хэсэгчлэн ашиглаж байгаа эсэхээс үл хамааран олж мэдсэн зүйлээ олон нийтэд нээлттэй болгоно.

**Энэ үйл явц ардчилсан шинж чанартай байх бөгөөд токен эзэмшигчдийг татан оролцуулж, бидний зүгээс гаргаж болзошгүй аливаа алдааг анхаарч, гаргасан дүгнэлтэд шударгаар хариулахыг дэмжих болно.**

Инфляци Хэджинг Криптовалютын урт хугацааны амжилтанд Блокчэйн Солилцох Протокол  хамгаас чухал болохыг дахин хэлэхэд илүүдэхгүй байх. Томоохон төслүүд эгзэгтэй мөчид  Блокчэйнүүдийн сул дутагдалтай байдлаас болж дампуурал, хямралд хүрсэн олон жишээ бий. Тухайлбал, Криптокиттис (Cryptokitties) хэмээх блокчэйн төслийг авч үзье; Энэхүү блокчэйн дээр суурилсан тоглоом нь Этириум сүлжээний нийт урсгалын дөрөвний нэгийг эзэлж эхлэх үед Этириум олборлогчид гүйлгээ тус бүрт ногдуулах шимтгэл төлбөрөө нэмсэн.

Этириум сүлжээн дэх өндөр шимтгэлээс үүдэн Флоу (Flow) Блокчэйн рүү шилжихээ Криптокиттис зарласан боловч, тухайн шилжилт нь хэт удаан байсны улмаас анх бүрдүүлсэн хэрэглэгчдээ алдахад хүрсэн.

Нэг талаас Криптокиттис нь нэг Блокчэйнээс нөгөө рүү шилжих явц удаан байх нь ямар үр дагавар авчирдагийг бидэнд сургамж болгосон нь сайшаалтай. Аливаа төсөл "хэт амжилттай" болох нь Этириум сүлжээн дэх Прүф-оф-уоркоос харж болсон.

Үүнээс хойш Этириумыг үүсгэн байгуулагч Виталик Бутерин технологио прүф-оф-стэйк загварт шинэчлэн шилжүүлж байгаагаа зарлаж түүнийгээ Этириум 2.0 гэж нэрлэсэн. Энэхүү шинэчлэлт нь Криптокиттисийн оргил үед гарсан дутагдлуудад үзүүлэх хариу үйлдлийн нэг хэсэг байв. Гэвч, энэ өөрчлөлт нь ч харьцангуй удаан хийгдсэн билээ.









Инфляци Хэджинг Криптовалютын Блокчэйн Солилцох Протокол нь ухаалаг гэрээний блокчэйнуудад хамгийн түгээмэл тохиолддог дутагдлуудаас хамгаалснаар хөрөнгө оруулагчдын хүсч буй уян хатан чанарыг бий болгоно.

# ДЕФЛЯЦИЙН ЗАРЧИМ

05

Инфляци Хэджинг Криптовалютын хувьд Блокчэйн Солилцох Протоколоос илүү чухал хүчин зүйл нь бидний санаачилсан санхүүгийн хэрэгсэл болох дефляцийн зарчим өнөөгийн уламжлалт эдийн засгийн тогтолцооноос эрс өөр билээ. Энэ нь төвлөрсөн санхүүгийн тогтолцооны тулгамдсан асуудлуудыг шийдэх Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны зоригтой алхам юм.

**Хаалттай хаалганы цаана аливаа зүйл шийдэгддэг хэмээн харанхуй итгэхийн оронд бид Инфляци Хэджинг Криптовалютаар ил тод байдал нотолгоонд суурилсан криптовалютад итгэх үнэмшлийг бий болгохыг зорьж байна.**





Өмнө дурдсанчлан, Инфляци Хэджинг Криптовалют нь нийт зах зээлийн үнэлгээ токен эзэмшигчдийн нийт тоотой тэнцэх хүртэл токен шатаалтыг хийх болно. Шатаалт нь АНУ-ын инфляцийн түвшинг удирдлага болгох ба өөрөөр хэлбэл IHC нь ам.долларын эсрэг ажиллана гэсэн үг юм. Өөрийн хөрөнгөө инфляцийн урсгал, гиперинфляцийн аюулаас хамгаалахыг хүсч буй хэн бүхэнд Инфляци Хэджинг Криптовалютыг эзэмших нь маш зөв сонголт.

Инфляци Хэджинг Криптовалюттай холбоотой тоо, баримтуудыг хүссэн хэн ч хаанаас ч харах  боломж нээлттэй байдал нь алт гэх мэт инфляцийн хэлбэлзлийг таамаглах уламжлалт хэрэгслүүдээс тэс өөр. Та АНУ-ын инфляцийн түвшин хэд дээр байгааг л мэдэж байвал Инфляци Хэджинг Криптовалютын дефляцийн түвшин хэд байгааг бас мэдэх боломжтой.

Дефляциийн ач холбогдлыг цөөхөн хүн мэддэг боловч энэ нь өөрөө маш их зүйлийг агуулж байдаг.   Дефляци үүсэхэд зарцуулалтын эрх мэдэл хэрэглэгчдэд илүү ихээр шилждэг. Нэрлэсэн орлогоо нэмэгдүүлэхгүйгээр тэд илүү олон тооны бараа, үйлчилгээ худалдан авах боломжтой болдог. Тэтгэврийн эсвэл хадгаламжийн дансууд нэрлэсэн үнэлгээг өсгөлгүйгээр эдийн засаг бүхэлдээ томордог. Инфляци Хэджинг Криптовалютын данс бүрт энэ л зарчим тогтмол үйлчилнэ.






Энгийнээр тайлбарлавал, маргааш таны мөнгө дефляцид өртвөл тэр хэмжээгээр таны амьдралын өртөг унаж эхэлнэ. Таны авсан зээлүүдийн хүү ч дефляцийг даган унах нь танд дахин санхүүжилт авахад илүү амар болно. Ингэснээр таны мөнгө өмнөхөөсөө илүү өндөр үнэлгээтэй болж хэрэв та байр худалдаж авах төлөвлөгөөтэй байсан бол хүслээ биелүүлэх боломжтой болно. Таны эзэмшиж байсан валютын нэгж тус бүрийн худалдан авах чадвар нь чангарснаар та шинээр бизнес эхлүүлэх, боловсрол эзэмших, бараа таваар нөөцлөх боломжтой юм.

Энэ өнцгөөс харахад Инфляци Хэджинг Криптовалют нь Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны нэгэн адилаар төвлөрсөн эдийн засгийн тогтолцоог нийтэд нь сөрөн гарч байгаа бүтээгдэхүүн юм. Бид шинэ зүйлийг эхнээс нь зохион бүтээгээгүй гэдгийг дахин дурдах нь зүйтэй.

**Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо (DeFi) нь уламжлалт валют, мөнгөний нэгж болон зах зээлийн манипуляциас үүдэлтэй инфляцийн эсрэг бий болсон зүйл гэдгийг олон хүн мэддэг. Инфляци Хэджинг Криптовалютын инфляцийн эсрэг авч хэрэгжүүлэх шууд аргачлал нь санхүүгийн тогтолцоонд ашиглах зарим хэрэгслүүдээс илүү Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны үндсэн зарчмыг агуулна.**

Юуны өмнө бид дефляцийг хөрөнгө оруулалтын стратегийг төрөлжүүлэх хэрэгсэл гэж үздэг. Инфляци Хэджинг Криптовалют нь өөрсдөдөө болон гэр бүл, ирээдүйдээ хийж байгаа хөрөнгө оруулалт юм.

Бидний зориудаар маш өндөр тогтоосон гүйлгээний шимтгэл нь дефляцийн үүргийг гүйцэтгэх болно. IHC-аар гүйлгээ хийх бүрт тухайн гүйлгээний нийт үнийн дүнгийн 5%-тай тэнцэх шимтгэл авна. Бид цугласан шимтгэлийг токен эзэмшигчдэд хуваан тараана. Үндсэндээ, бид токен эзэмшигчдийг дэжихийн хэрээр токен хэрэглэгчдийг буюу арилжаалагчдыг үргээх зорилготой юм.

Эдгээр эффектийг нэгтгэн үзэхэд токен шатаалт нь бидний тогтоосон түвшин буюу (1 их наядын 50%)-д хүрэх хүртэл үргэлжлэх бөгөөд энэ үйл явц хорь ба түүнээс дээш жил үргэлжилж болзошгүй. Эцсийн зорилго нь АНУ-ын ам.долларт уягддаг санхүүгийн тогтолцооноос ангижирч төвлөрсөн бус санхүүгийн олон хэрэгслүүдийн адил IHC ажиллаж эхэлнэ.

Инфляци Хэджинг Криптовалютын толгой компани болох Их Бит ХХК нь улирал тутамд нээлттэй зах зээлээс буцаан худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлнэ. Энэхүү хөтөлбөр нь IHC токеныг жил бүр шатаах амлалтаа биелүүлэх зорилготой. Хөтөлбөрийг компанийн удирдлагын шийдвэрээр хэрэгжүүлэх бөгөөд буцаан худалдан авах хөрөнгийн хэмжээг тухайн үеийн компанийн санхүүгийн чадавхийн төлөв байдлаас шалтгаалан тодорхойлно.

**Их Бит ХХК нь компани токен зарцуулалт, хөрөнгө оруулалтын стандарт, дүрэм журмыг чанд мөрдөнө.**



# ИЙЛД ФЕРМИНГ БА АРИЛЖААНЫ ТӨВЛӨРСӨН БУС ТОГТОЛЦОО

06

Хэдийгээр Блокчэйн нь төвлөрсөн бус бүртгэл хөтлөлт боловч гүйлгээнүүд нь төвлөрсөн бирж дээр хийгддэг ихэнх криптовалютын гол парадокс буюу логик зөрчилдөөн юм. Ихэнх хүмүүс Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоонд хөрөнгө оруулалт хийж байна гэж боддог боловч үнэн хэрэгтээ тэд Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоонд хөрөнгө оруулсан платформуудад л хөрөнгө оруулж байгаа юм. Учир нь хэрэглэгчдийн өмнөөс токенийг нь хадгалдаг компаниудаар дамжуулан токен худалдаж авч байгаа нь нэг төрлийн төвлөрсөн санхүүгийн системд оролцож байна гэсэг үг.

Аз болоход Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо нь сүүлийн үед жинхэнэ утгаараа хөгжиж байна. Бүх үйл явц ухаалаг гэрээгээр явахад төвлөрсөн систем шаардлагагүй болно. Өнөөг хүртэл хүний оролцоотойгоор зохицуулагддаг байсан үүрэг ухаалаг гэрээгээр гүйцэтгэгдэх болсон. Жишээлбэл, PancakeSwap (төвлөрсөн бус криптовалютын бирж) дээр төвлөрсөн биржид найдалгүй уламжлалт валютаар криптовалют худалдаж авах шаардлагагүйгээр нэг криптовалютыг нөгөө  криптовалютаар арилжаалах боломжтой. PancakeSwap-тай хамтран ажилласнаар Инфляци Хэджинг Криптовалют нь своп (койн сольж арилжаалах) болон ийлд ферминг (койноо зээлүүлэн хэрэглүүлснээр ашиг олох процесс) процессуудыг санал болгох болно.



Своппинг гэдэг нь Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоонд арилжаа хийх хэллэг юм. Энэ процесс нь дундын зуучлагчгүйгээр криптовалютуудыг хооронд нь хөрвүүлж, арилжаалахыг хэлдэг. PancakeSwap шиг төвлөрсөн бус бирж дээр, арилжаа, солилцоо нь хэрэглэгчийн гарт бүрэн байдаг. Өөрийн токенуудыг хэн нэгний эзэмшилд шилжүүлэхгүйгээр өөрийн мэдэлд байнга байлгаж болдог бөгөөд зөвхөн арилжаалах криптовалютаар солих үед эзэмшлээсээ гаргана. Ингэснээр, энэ процесс нь ердөө хоёр талын хооронд л болох тул нэг хүн нэг төрлийн криптовалют эзэмшиж, өөр нэг хүн өөр төрлийн криптовалют эзэмшиж байхдаа тэднийгээ хоорондоо солилцох үйл явц юм.

Ийлд ферминг буюу койноо зээлдүүлэн өгөөж хүртэх процесс ч мөн адил дундын зуучлагчгүйгээр явагдана. Своппинг хийх нь арилжаа хийхтэй дүйцэхтэй адил ийлд ферминг нь банк болон бусад зээлдүүлэгч байгууллагуудын хөрөнгө босгох процесстой төстэй юм. Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоонд ийлд хийснээр та бусдад өөрийн койнуудаа хүүтэйгээр зээлдүүлнэ гэсэн үг. Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны ийлд ферминг нь суурь болсон ухаалаг гэрээний давуу талыг ашиглан өгөөж, ашиг өгдөг бөгөөд PancakeSwap дээр хэдэн зуун мянга, зарим үед сая ам.доллар давсан өгөөж олдог жишээнүүд олон бий.



Инфляци Хэджинг Криптовалютын экосистемд нэг талаас хөрөнгийн бэлэн эх үүсвэр хайж байгаа нөгөө талаас үүнийг санал болгож байгаа хэрэглэгчид бие биентэйгээ хамтран ажиллах боломжтой. Ингэснээр инфляцийн хэлбэлзлээс хамгаалах үүрэг гүйцэтгэхээс гадна Инфляци Хэджинг Криптовалют нь Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцооны зах зээлд хөл тавих гэж байгаа хүмүүсийн хувьд бас нэгэн сонголт хийх боломж олгож байна. Дөнгөж эхэлж байгаа болон туршлагатай хөрөнгө оруулагчдын аль алинд нь тэдний ашигладаг биржэд дасан зохицох чадвартай, бүрэн боловсорсон хэрэгслийг Инфляци Хэджинг Криптовалют санал болгоно.

**Төвлөрсөн бус байдал нь Инфляци Хэджинг Криптовалютын нэмэлт онцлог гэхээсээ илүү үндсэн шинж чанар нь билээ. Инфляцийн урсгалыг сөрж ажилладаг хэрэгсэлд зөвхөн төвлөрсөн бус тогтолцоо л тохиромжтой байх нь ойлгомжтой.**

# ӨНӨӨГИЙН БОЛОН ОЙРЫН ИРЭЭДҮЙН ТҮҮХ

07

АНУ-ын Холбооны Нөөцийн Банк (ХНБ) онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шийдвэртэй арга хэмжээ авахад бэлэн байгаа нь сүүлийн үеийн үйл явцаас тод харагдаж байна. Үүний нэг жишээ нь Ковид19 цар тахлын үе юм. Хөл хорио тогтоосон эхний үеэс хойш АНУ-ын засгийн газар эдийн засгийн үйл ажиллагааны алдагдлаа нөхөхийн тулд томоохон арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн. Худалдан авагчид гэртээ хоригдсоноос мөнгө зарцуулах боломжгүй болсон үед ХНБ эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор ихээхэн хэмжээний мөнгө хэвлэсэн. Зарим судалгааны дүгнэлтээс харахад цар тахлын хугацаанд АНУ-ын Хөдөлмөрийн Зах Зээлийн Статистикийн Товчооноос зарлаж байсан инфляцийн тоон мэдээнүүд алдаатай байсан.

ХНБ-аас бодлогын өөрчлөлт хийхийг хүлээх юм бол энэ хүлээлт талаар болох нь дамжиггүй. Сонирхолтой нь инфляцийн талаарх (болон түүнийг хэрхэн ашиглах талаар) үзэл бодол нь хөгжингүй орнуудад улс төрийн намаас хамааралгүй хэвээр байна. Жой Байден АНУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалаа авсан даруйдаа өмнөх ерөнхийлөгчийн засгийн газрын гишүүдийг албан тушаалаас нь чөлөөлж өөрийн намын гишүүдийг томилсон. Тэрээр энэ ажиллагаанд маш өндөр ач холбогдол өгсөн бөгөөд сарын дотор өмнөх засгаас зөвхөн цөөн тооны туслах болон доод албан тушаалтнууд үлджээ.



Холбооны нөөцийн сангийн дарга Жером Пауэлл л албан тушаалаа хадгалсан байна. Хэдийгээр тэрээр АНУ-ын Ерөнхийлөгч Жой Байдены сонгуулийн өрсөлдөгчийн ивээлд байсан эсрэг намын ерөнхийлөгчийн томилсон хүн байсан боловч Жером Пауэлл ажлаа хадгалж үлдэх нь тодорхой байв. Ковид-19 цар тахлын үеэр түүний авсан арга хэмжээнүүд шинэ ерөнхийлөгчид таалагдсан. Мөнгө шинээр хэвлэж, зээлийн хүүг тэгтэй дөхөхүйц бага байлгаснаар Холбооны Нөөцийн дарга АНУ-ын ямар ч ерөнхийлөгчид таалагдах арга хэмжээ авч байсан юм.



Өнөөгийн төвлөрсөн тогтолцооны мөнгөний бодлогын бодит нүүр царай ийм л байна: шийдвэр гаргагчдад инфляци өсөх нь ойлгомжтой бөгөөд тэдний авч хэлэлцэх асуудал биш юм. Инфляцийг ашиглан санхүүгийн хямралаас гарах боломж гарвал тэд хэзээд тэрхүү боломжийг шүүрэхэд бэлэн. Улс төрчид урт хугацааны асуудлуудаа дараагийн хүндээ үлдээж зөвхөн богино хугацааны асуудлуудыг шийдэхийг илүүд үздэг тул дур мэдэн мөнгө хэвлэсэн ч мөнгөний систем хангалттай тэсвэрлэнэ гэж үздэгээс улбаалж өнөөгийн инфляцийг улам хурдасгаж, хүндрүүлдэг бодлогуудаа өөрчлөх, шинэчлэх оролдого огтхон ч хийдэггүй.

ХНБ-д мөнгө шинээр хэвлэхээс өөр хийх ажил бараг байдаггүй. Хэдэн жилийн өмнө, тус банкны ажил арай илүү байсан нь хэвлэсэн мөнгөө томоохон банк, зээл санхүүгийн байгууллагад хуваарилалт хийдэг байсан. Өнөөдөр бүх зүйл компьютераар хийгддэг болжээ. ХНБ мөнгө хэрэгтэй гэж үзвэл тэр шийдвэрийн дагуу мөнгө илүү их нийлүүгдэнэ гэсэн үг. Хэдхэн товчлуур дарж цахимаар шуудан илгээснээр тэд зээлдэгчдийн халаасыг мөнгөөр дүүргэж чадах бөгөөд үүнийгээ ч хийсээр ирсэн. Оксфорд Экономиксоос гаргасан нэгэн судалгаанаас харахад, цар тахлын үеэр, ХНБ 3.5 их наяд ам.доллар шинээр хэвлэж түүгээрээ засгийн газрын үнэт цаасуудыг худалдан авчээ.

Мөнгийг ингэж шаргуу, ихээр хэвлэх нь цаг хугацааны тэсрэх бөмбөгтэй ижил юм. Хэдийгээр энэ хямралын үед бидэнд итгэж найдах удирдагч байгаа нь уламжлал ёсоор олон нийтийг тайвшруулдаг боловч инфляци хэзээ эхэлж, хэзээ төгсөхийг хэн ч мэдэхгүй эрсдэлтэй тоглоом юм. Их хямралын талаар таамаг дэвшүүлж байсан өмнөх түүхүүдээс харвал инфляцийн үр нөлөөг хамгийн бага хохиролтойгоор даван туулахыг эрмэлзэж буй хэн бүхэнд сэтгэлийн дэм өгдөг, учир нь хямрал ирэхийг хэн ч урьдчилж харах боломжгүй.



Эдийн засгийн өсөлтийг авчрах тохиолдолд л мөнгө хэвлэх нь оновчтой сонголт юм. Коронавирусын халдвар (COVID-19)-ын улмаас аж ахуйн нэгжүүд хөл хорионд орж, барилга байгууламж, дэд бүтцийн зээл олгогдолгүй эдийн засаг зогсонги байдалд орсон. Их хэмжээний мөнгө хурдан нийлүүлэх болон эдийн засгийн бодит өсөлт бага байх нь инфляциас үүдэлтэй хямралыг бий болгодог.




Харвардын эдийн засгийн профессор Альберт Кавалло нь тайлагнасан бодит инфляцийн түвшинг нарийвчлан судалж үзэхийн тулд Харвардын их сургууль, Браун судлаачдын мэдээлллийг ашигласан байна. Тэрээр, Хөдөлмөрийн статистикийн товчооны мэдээлсэн албан ёсны тоонуудтай өөрийн дүгнэлтээ харьцуулан судалгаа хийжээ. Түүний дүгнэснээр, КОВИД-19 цар тахал нь инфляцийн түвшинг мэдэгдэхүйц түргэсгэсэн хэдий ч АНУ-ын засгийн газар албан ёсоор зарласан инфляцийн түвшинг буруу тооцоолсон эсвэл буруу мэдээлсэн гэж үзжээ.

ХНБ КОВИД-19 цар тахал эхлэхээс өмнө зээлийн хүүг тэгтэй дөхөх бага тоонд барьж байсан. Энэ нь Инфляци Хэджинг Криптовалютын дефляцийн зарчмын эсрэг үйл ажиллагаа гэж харж болно.  Зээлийн хүү тэгтэй дөхсөн бага байх нь банк болон зээл, санхүүгийн байгууллагуудад хөрөнгөө хадгалах эргэлтэнд оруулахгүй байх нөхцлийг бүрдүүлдэг. Тэдний зээлдүүлсэн ам.доллар бүр ХНБ-ны нэмж хэвлэсэн мөнгөтэй хамт зах зээлийн эргэлтэнд ордог. Ингэснээр энэ хоёр эх үүсвэр хамтран зах зээлд манипуляци хийж, инфляцийг улам хурдтай өсгөж байна.

Эдийн засагч Дэвид Розенберг зээлийн хүүгийн тэгтэй дөхсөн бага түвшин болон төрийн сангийн зарлагын алдагдлын талаар өөрийн үзэл бодлоо ийнхүү нэгтгэн дүгнэжээ.




"Энэ бол шулуухандаа зах зээлийн манипуляци юм. Нэг хоногийн хугацааны (овернайт) зээлийн өртгийг багасгах нь өөр хэрэг. Их Хямралаас хойш эрдэнэсийн сан, чанартай үнэт цаасуудаар оролдох нь сүүлийн үеийн хэвийн үзэгдэл болсон нь ХНБ-г хугацаатай бондын менежер болж хувирахад нөлөөлсөн. Гэтэл үүнээс болж төв банк эрсдэлийн сан шиг ажиллаж эхэлсэн. Хувийн хэвшлийн корпорациудын чанаргүй зээлүүдийг балансд нэмж оруулж байгаа нь компаниудыг гол зогоох төдий амьд байлгаж, суурь шинжилгээ болон чөлөөт зах зээлийн үнэ тогтоох процессыг үл тоомсорлож нөөцийн буруу хуваарилалтыг бий болгож байна".

ХНБ ийнхүү эрсдэлийн сан шиг ажиллаж эхэлснээр богино хугацаанд олох өгөөж инфляцийн хурдаас түрүүлнэ хэмээн найдах нь асар том эрсдэлийг дагуулж байна гэсэн үг. Эрсдэлийн сангууд нь АНУ-ын Санхүүгийн зохицуулах газар (FINRA) болон ижил төстэй байгууллагуудын дүрэм журам, зохицуулалтаас гадуур ажилладаг нь учиртай, яагаад гэвэл тэдний өндөр түвшний эрсдэл туршлагагүй хөрөнгө оруулагчдад ээлгүй байдаг. ХНБ нь эрсдэлийн сангийн зарчмаар ажиллаж эхэлснээр дэлхий нийтийг бүхэлд нь эрсдэлд оруулж байгаа бөгөөд эдгээр эрсдэлийн талаар дийлэнх нь бүрэн ойлголтгүй байна. Мөнгөний үнэ цэнийг ихээхэн эсвэл бүр мөсөн унагах эрсдэлүүд дотроос хамгийн аюултай нь инфляци билээ.

Өмнө тохилдож байсан гиперинфляцийн хүндхэн жишээнүүдтэй харьцуулахад өнөөгийн инфляцийн түвшин тийм ч санаа зовоох хүчин зүйл хэмээн санагдахгүй байж болох юм. Инфляци өргөн цар хүрээг хамрах хямрал болох түвшинд хүрээгүй мөн инфляцийн үр нөлөө нь ч түр зуурынх байхаар байна.

Гэсэн хэдий ч, хүмүүст санхүүгийн ирээдүйгээ сонгох эрх нь бий. ХНБ эрх ашгаа дэлхийн эдийн засгаас дээгүүр тавьж, эрдэнэсийн сан худалдан авах чадвараа буруу тооцоолсноор  зээлийн хүүг бууруулж чадаагүйн улмаас мөнгө нэмж хэвлэх нь биднийг тэдний шийдвэр, ашиг сонирхолын эрхшээлд хэвээр үлдээсээр байна.



Инфляци Хэджинг Криптовалют нь ХНБ-ны олон арван жилийн турш ноёрхож ирсэн төвлөрсөн санхүүгийн тогтолцооноос гадуур зохицуулагдана. Энэ нь төвлөрсөн санхүүгийн тогтолцоо, хяналтгүй инфляцийн хор уршгийг мэддэг хөрөнгө оруулагчдад зориулсан санхүүгийн хэрэгсэл юм. Бид энэхүү шийдлээ Монголын зах зээлээс эхлэж улмаар дэлхийн зах зээлд нэвтрүүлэхдээ бахархалтай байна.

# МОНГОЛ БА ДЭЛХИЙД ЗОРИУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЭЛ

08

Инфляци Хэджинг Криптовалют нь Монгол улсын зах зээлд эхлээд 1 их наяд койны 100 тэрбумыг анхдагч биржид санал (IEO) болгоно. Инфляци Хэджинг Криптовалютын үүсгэн байгуулагчдын хувьд нийт койны 110 тэрбум койныг зөвлөхүүд, үүсгэн байгуулагч гишүүд, хөгжүүлэлтийн баг хадгалж үлдэнэ. Дотоодын зах зээлээс бид ойролцоогоор 10.5 сая ам.доллар босгоно гэж төлөвлөж байна. Үүний дараагаар бид гадаад зах зээлд гарах хэд хэдэн криптовалютын биржид анхлан санал болгох IEO болон Криптовалют анхлан санал болгох процесс буюу IFO авч хэрэгжүүлнэ. Гадаад зах зээлд гарах IEO дээр бид гол 4 биржийг сонгож байна.

Монгол улсад Инфляци Хэджинг Криптовалютаа эхлүүлж байгаа нь Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоогоор дамжуулан Монгол улсаа санхүүгийн төв бүс болох боломжтой гэж үзэж байна. Тус төсөл амжилттай хэрэгжих, хөгжүүлэх мэдлэг, чадвар, хүсэл эрмэлзэл бидэнд бий. Цаашид бид IHC-ыг дэлхийн бүх улс орны хүмүүст хүргэх төлөвлөгөөтэй байна.

**ХНБ-ны бодлого дэлхийн бүх улс орны эдийн засагт нөлөөлдөг санхүүгийн энэхүү хэрэгслийг мөн адил дэлхий дахинд эрэлттэй байх учиртай.**



Инфляци Хэджинг Криптовалют нь сайтар бодож боловсруулсан, зөв чиглэлтэй Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо, хөрөнгө оруулалтын олон хэрэгслийн нэг болно гэдэгт бид итгэж байна. Сүүлийн жилүүдэд бусад блокчэйн төслүүдийн  мөрөөдөж байгаа шиг криптовалютын зах зээлийг бүхэлд нь байлдан дагуулах бодол бидэнд үгүй. Эсрэгээрээ, бид Инфляци Хэджинг Криптовалютыг төвлөрсөн бус тогтолцооны эдийн засагт урт хугацаандаа тогтвортой, зөв байршуулахыг л зорьж байгаа билээ.



18-р зууны Шотландын эдийн засагч, **“Үндэстнүүдийн Баялаг”** хэмээх алдарт бүтээлийг зохиогч Адам Смит ингэж хэлжээ:

"Бидний оройн хоол махны худалдаачин, шар айраг исгэгч, талх нарийн боов үйлдвэрлэгчийн нинжин сэтгэл дээр бус харин тэдний ашиг сонирхол дээр л суурилж байдаг"

Энэ нь бидний зүгээс хүмүүсийн анхаарлыг өмнө нь татаж байгаагүй эрсдлийн талаар таниулах оролдлого юм. Өдөр бүр зарцуулдаг мөнгөө ямар нэгэн байдлаар криптовалютад хөрөнгө оруулсан хувь хүмүүст бид зэрэгцэн орших өөр нэгэн системд шилжих боломж олгож байгааг дурдмаар байна. Мөнгө хэвлэлт, зээл, арилжаа аль аль нь төвлөрсөн бус байхыг л жинхэнэ утгаар төвлөрсөн бус тогтолцоо гэж хэлнэ.

Энэхүү санаанд суурилан бид Инфляци Хэджинг Криптовалютыг бүтээсэн болно. Бид хэнийг ч эдийн засгийн тухай үндсэн ойлголтуудаа өөрчилж, өөр бусдын төлөө хадгаламжаа золионд гаргахыг уриалаагүй. Хүн бүрт өөрсдийн хадгаламжаа аюулгүй хадгалах, өсгөх боломжтой шинэ хэрэгслийг л санал болгож байгаа билээ.

Тун удахгүй бид энэ цаг үеийг уламжлалт ба шинэ тогтолцооны оглтолцлын цэг байснаар нь дурсаж магадгүй юм. Бид энэ цаг үеийг эргэн хараад төвлөрсөн бус санхүүгийн зах зээл бий болох нь зайлшгүй байсныг, компьютерт код бичиж эхэлсэн цагт буцах зам үгүй болохыг ойлгох байх. Ямартай ч бид Инфляци Хэджинг Криптовалютыг бодит хэрэгцээнд зориулан бүтээсэн. Энэ бол зүгээр нэг блокчэйн биш, ардаа суурьгүй криптовалют ч биш юм. Манай концепцуудын багана болсон эдийн засгийн онолууд нь олон жилийн түүхтэй. Нэрт эдийн засагч Пол Кругман, Милтон Фридман нар инфляци ба түүний нөлөөллийг судалж, тус бүр эдийн засгийн салбарын Нобелийн шагнал хүртжээ.

Энэ бүхний ард байгаа суурь шинжлэх ухаан нь маш тодорхой. ХНБ-г гиперинфляци руу гулсан орохоос хамгаалах ид шидийн хамгаалалт гэж байдаггүй. Үүний зэрэгцээ, хамгийн аюултай нь хэн ч энэ бүхэн хэзээ, яаж болохыг урьдчилан таамаглах боломжгүй. Инфляци Хэджинг Криптовалют нь өнгөрсөн хугацаанд аль хэдийн маш олон удаа бүдэрсэн төвлөрсөн тогтолцооны замбараагүй байдлаас хамгаалах маш чухал хамгаалалт болно.



# ТЕХНИКИЙН ТАНИЛЦУУЛГА

09

IHC-ын техникийн хөгжүүлэлт нь он-чейн (блокчэйн дээрх) ухаалаг гэрээ, офф-чейн (блокчэйнээс гадуур) хяналтын систем ба хэтэвчний үндсэн систем гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.

1. **Он-чейн ухаалаг гэрээ – Solidity дээр бичсэн IHC-ын эх кодууд юм.**
2. **Офф-чейн хяналтын систем – IHC-ын токен менежментийн систем.**
3. **Гар утасны хэтэвч аппликэйшн, хэтэвчний үндсэн систем – IHC-ын токены нэтив/үндсэн хэтэвч.**

# 1. Он-чейн ухаалаг гэрээ

Он-чейн ухаалаг гэрээ - Solidity дээр бичсэн 3 хэсгээс бүрдсэн токен нь IHC-ын үндсэн эх код юм. “ihc_token.sol” – токен – гол хэсэг ба гол тохиргооны хэсэг (config), гүйлгээ (transfer), засаглал (allowance) нь эдгээр функцээс бүрдэнэ. “ihc_yield.sol” токены өгөөж (yield) – эдгээр функц нь шинээр ийлд/зээлэх процесс үүсэх бүрт ухаалаг шинэ гэрээг үүсгэдэг. “ihc_loan.sol” нь барьцааны эх кодыг ашиглан зээл гаргаж, зээлийн хүсэлт болгонд мөн ухаалаг гэрээг шинээр үүсгэдэг. Токены механизмыг доор үзүүлэв.

# Гүйлгээний шимтгэл



# Зээл


Зээлдэгч
Барьцаа
Зээл авах
Зээлийн пүүл
Шинээр зээлийн гэрээ үүсгэх
Барьцаа
Шилжүүлэх дүн
Эргэн төлөлт
Төлбөр
Зээлийн гэрээ
Автоматаар устгах
Хаах
Зээлийн пүүл
Барьцаа
Зээлийн гэрээ
Автоматаар устгах

# Ийлд Ферминг



# Шатаалт


Ийлд фермер
Ухаалаг гэрээ
Шатаах өдрийг тогтоох
Шатаах дүнг тогтоох
Офф-чейн
Хяналтын систем
Шатаах

# 2. Офф-чейн хяналтын систем

Офф-чейн буюу блокчэйнээс гадуурх хяналтын систем нь тогтмол хуваарилагдан тараагдах гүйлгээний бонусууд, шатаах дүнгийн тохиргоо, шатаах огноог тодорхойлох зэргээс бүрдэнэ. Дэлхийн хэмжээний үүлэн технологийн үйлчилгээний байгууллагын хамгийн сүүлийн үеийн үүлэн технологийн архитектурыг ашиглана.



# 3. Хэтэвчний үндсэн систем

Бүх үйлчилгээг нэг дор багтаасан IHC хэтэвч нь хэрэглэгчдэд DEX (төвлөрсөн бус бирж) своп, ийлд ферминг, зээлэх зэрэг үйлчилгээг хүргэнэ. Блокчэйн дээр ажиллах он-чейн хэтэвч нь хэрэглэгчдэд өөр өөр блокчэйний сүлжээг сонгох боломж олгох бөгөөд эхний ээлжинд Этириум ба Байнанс Смарт Чейнийг дэмжих болно. DEX-ийн Liquidity Pool буюу Төвлөрсөн бус санхүүгийн зах зээлд хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор нийлүүлэлт хийх үйл ажиллагаа нь мөн холбогдоно.



# БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

10

Инфляци Хэджинг Криптовалютыг зах зээлд танилцуулахаас эхлээд жилийн турш хэрхэн урагшлахыг доорхи байдлаар задлан харуулая.

## 2021-2022

**2021**

| 8-р сарын 25- -9-р сарын 4 | 9-р сарын 9 2021 | 9-р сар 2021 | 9-р сарын 13 2021 | 9-р сарын 20 2021 |
|---|---|---|---|---|
| Анхдагч биржийн Санал (IEO) | Ethereum wrapped нээлт | Global Marketing нээлт<br>ОУ-ын хамтрагчдыг зарлах | Биржийн арилжаа эхэлнэ | Төвлөрсөн бус биржийн нээлт |
| 100,000,000,000 IHC | Trade.mn<br>Complex.mn<br>DAX.mn<br>CoinHub.mn | | | PancakeSwap **ба** UniSwap |

Инфляци Хэджинг Криптовалютыг зах зээлд танилцуулахаас эхлээд жилийн турш хэрхэн урагшлахыг доорхи байдлаар задлан харуулая.

2021-2022

2021

4-р улирал 2021

Initial Farm Offering

4-р улирал 2021

Томоохон төвлөрсөн Биржүүд дээр гарах

11-р сар 2021

IHC Он-чейн хэтэвчний нээ

iOS App Store
ба
Google Play Store

4-р улирал, 2021- -2-р улирал 2022

IHC хэтэвч дээр боломжууд нэмэгдэх

Зээлэх
Ийлд ферминг
Төвлөрсөн бус бирж (DEX)

# IHC-ЫН ТОКЕНОМИК

11

Манай токеномик буюу токен эдийн засаг хэрхэн ажиллахыг аль болох товч бөгөөд тодорхой, ойлгомжтой тайлбарлая. Бидний төлөвлөгөө нь эхлээд Инфляци Хэджинг Криптовалютыг эх орондоо анхлан танилцуулахад оршино. Үүний дараа бид гадагшаа чиглэсэн ажлуудыг хийх бөгөөд төвлөрсөн бус загварыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж, чөлөөт зах зээлийн зарчимд IHC-ыг даатгана. IHC токеномик буюу токен эдийн засаг нь бидний чиглэл болгосон дефляцийн зарчимтай нийцсэнээр Инфляци Хэджинг Криптовалютын дефляцийг оновчтой шийдэх билээ. Төлөвлөгөөний задаргааг доорхи байрлаар үзүүлэе:

| НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ | | 1,000,000,000,000 |
|---|---|---|
| 1 | IEO-д хуваарилах | 100,000,000,000 |
| | IEO-ийн үнэ | $0.00010526 |
| 2 | IEO-оор босгох хөрөнгө | $10,526,315 |
| 3 | IEO эйрдроп бонусны хуваарилалт | 10,000,000,000 |
| 4 | IFO-д хуваарилах | 100,000,000,000 |
| 5 | Инфляци Хэджинг Экосистемд зориулан хадгалах | 300,000,000,000 |
| 6 | Стратегийн түншлэл, хэрэглээний дасан зохицолд хуваарилах | 80,000,000,000 |
| 7 | Токен шатаалтын протоколын нөөц | 100,000,000,000 |
| 8 | Төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоон дээрх LP-д зориулсан (20 жилийн туршид түгжигдэнэ) | 100,000,000,000 |
| 9 | Үүсгэн байгуулагч,зөвлөхүүд ба багт хуваарилах (1-5 жилийн хугацаатай түгжигдэнэ) | 110,000,000,000 |
| 10 | Стратегийн нөөц | 100,000,000,000 |

# ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

12

# Хөрөнгийн зарцуулалт

| | |
|---|---|
| Маркетинг | 15% |
| Үйл ажиллагаа | 20% |
| Технологи | 40% |
| Хуулийн зардлууд | 5% |
| Нөөц | 10% |
| Хөрвөх хөрөнгө | 10% |



# МАНАЙ БАГ

13

Монголын блокчэйн салбарын хамгийн туршлагатай, нэр хүндтэй блокчэйн технологи хөгжүүлэгчээс гадна төрөл бүрийн салбарын мэргэжилтнүүдээс IHC-ын баг бүрдэнэ. Багийн гишүүд дотор Монгол болон бусад улс орны технологи хөгжил, үйлчилгээний компаниудыг амжилттай хамтран үүсгэн байгуулж байсан туршлагатай энтрепренерүүд багтсан.

**Багийн гишүүдийн олон улсын санхүүгийн зах зээл дээрх туршлагыг нэгтгэвэл салбартаа нийт 20 жилийн туршлага хуримтлуулжээ. IHC-ын зөвлөхүүд Уолл Стрийт болон Монгол улсын технологийн болон санхүүгийн салбарт амжилттай бизнес удирдаж байгаа мэргэжилтнүүдээс бүрддэг.**



**Баярмагнайгийн Гантиг**
Гүйцэтгэх захирал

# Хураангуй

Б.Гантиг нь блокчэйн, криптовалютын эксперт гэдгээрээ Монголд танигдсан мэргэжилтэн юм. Тэрээр Их Бит ХХК ба Криптокүрэнси Монголиа Группыг үүсгэн байгуулалцсан бөгөөд Их Бит ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Их Бит ХХК нь Инфляци Хэджинг Криптовалютын толгой компани бол Криптокүрэнси Монголиа Групп нь блокчэйн технологи ба криптовалютын талаар олон нийтэд мэдээлэл, боловсролын контент түгээдэг нээлттэй групп юм. Б.Гантиг нь Монголын Финтек-Блокчэйны Зөвлөлийн даргаар ажилладаг.

Түүнчлэн, тэрээр VeChain-ний Монгол дахь төлөөлөгч компани болох Силкчэйн Капиталыг хамтран үүсгэн байгуулалцсан болно. Мөн Битрэксийн Мэдээлэл технологи Монголын виртуал хөрөнгийн бирж болох Complex.mn-ний хамтран үүсгэн байгуулагч бөгөөд цөөнх хувьцаа эзэмшигчдийн нэг юм. Б.Гантиг нь 2021 оны 8-р сараас УИХ-тай хамтран Монголын анхны криптовалют, виртуал хөрөнгийн зохицуулалтыг боловсруулах дэд ажлын хэсгийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Gantig Bayarmagnai I Facebook
Gantig Bayarmagnai I Instagram

# Ажлын замнал

**Баярмагнайгийн Гантиг**
Гүйцэтгэх захирал

Б.Гантиг 2009-2017 онд Оюутолгой ХХК-д ложистикийн супервайзер, экспортын үйл ажиллагааны хянагч, гадаад ложистикийн ахлах ажилтан, стратегийн төслүүдийн мэргэжилтнээр ажиллаж байсан. 2017 онд тэрээр Монголд криптовалютын биржийн платформ болох Trade.mn-ний гүйцэтгэх захирлаар томилогдсоноор хоёр сарын хугацаанд 5 сая гаруй ам.долларын орлого хуримтлуулжээ. Монголын анхны криптовалютын бирж өдгөө 170,000 гаруй гишүүнтэй.

2018 онд Битрэкстэй хамтран ажилладаг виртуал хөрөнгийн бирж болох БитМонЭкс ХХК-ийг үүсгэн байгуулжээ. БитМонЭкс нь блокчэйны зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг бөгөөд одоогоор ОУ-ын 10 гаруй төсөлтэй хамтран ажиллаж байна. БитМонЭкс ХХК нь Комплекс Монголиа нэртэй болсон бөгөөд Б.Гантиг нь цөөнхийн эзэмшигч хэвээр байгаа. Мөн 2018 онд блокчэйн салбарын эрчим хүчний парк болох Karvuon төслийг үүсгэн байгуулж, 2020 онд Өмнөд Солонгосын бирж ПроБит дээр IEO зохион байгуулсан. Karvuon одоогоор Монголд ухаалаг сүлжээний блокчэйн платформыг хөгжүүлж байна.

2021 онд Б.Гантиг нь Ард Санхүүгийн Нэгдэлийн охин компани болох Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдсон ба Монголын анхны Крипто ETF буюу Крипто бирж дээр арилжаалагддаг сан билээ. Ард Санхүүгийн Нэгдэл нь ArdCoin (ARDX) криптовалютыг гаргасан ба ArdCoin-ний менежментээр дамжуулан Б.Гантиг уг төслийг UniSwap дээр амжилттай эхлүүлж, Битрэкс Глобал дээр гарах ажлыг удирдсан.

Gantig Bayarmagnai I Facebook
Gantig Bayarmagnai I Instagram

# Хувийн намтар

**Баярмагнайгийн Гантиг**
Гүйцэтгэх захирал

Б.Гантиг нь Монголд зохион байгуулагдсан конференц, арга хэмжээг амжиттай удирдсан бөгөөд нөлөө бүхий илтгэгч юм. 2017-2020 онд тэрээр Монголын нийт 20,000 орчим хүнд криптовалют ба блокчэйны талаар илтгэл лекц тавьсан байна. 2017, 2019 оны Крипто Үндэстэн/Хөрөнгө оруулагч үндэстэн конференцийн ерөнхий хэлэлцүүлгийг удирдаж байсан. Өнөөдөр биткойн ба криптовалютыг идэвхтэй сонирхдог Б.Гантигийн жишиг, зөвлөгөөг дагадаг 50,000 орчим хүн байдаг ба тэрээр 30,000 идэвхтэй гишүүнтэй Монголын хамгийн том криптовалютын группийг удирдан, манлайлж байна.

Б.Гантиг нь Үндэсний Техникийн Дээд Сургуулийг (2010-2014) бизнесийн удирдлагын чиглэлээр бакалавр зэрэгтэй төгссөн. Тэрээр Инфинити Солюшнс ХХК-тай хамтран ОУ-ын бестселлер “Биткойн ба Блокчэйний үндсэн ойлголтууд: криптовалют болон ард нь ажиллуулж байгаа технологийн талаарх удиртгал” номыг орчуулан, хэвлэж, худалдаанд гаргасан.

Тэрээр төвлөрсөн бус тогтолцоо, төвлөрсөн бус санхүүгийн зах зээлийн философид гүн итгэгчдийн нэг юм. Хэдийгээр уламжлалт санхүүгийн салбарын туршлагагүй боловч хэвшмэл, гаца нги санхүүгийн тогтолцооноос гадна байж болох сонголт нь криптовалют гэдэгт итгэдэгээс гадна криптовалютыг олон нийтэд үр өгөөжөө өгдөггүй мөнгөний бодлогыг өөрчлөх том боломж гэж хардаг. Тэрээр өөрийгөө либерал идеалист гэж үздэг бөгөөд амьдралд хаана ч хамгийн чухал зүйл бол эрх чөлөө гэдэгт итгэдэг.

Gantig Bayarmagnai I Facebook
Gantig Bayarmagnai I Instagram



**Бүрэнжаргалын Мөнх-Эрдэнэ**
Технологи хариуцсан захирал

# Хураангуй

Б. Мөнх-Эрдэнэ нь Монголын нэр хүндтэй программист, хөгжүүлэгчдийн нэг бөгөөд Монголын засаглалыг цахимжуулахад хувь нэмэр оруулсан олон төслийг удирдсан туршлагатай. Тэрээр төрийн болон хувийн хэвшлийг технологийн цогц шийдлүүдээр хангадаг тэргүүний компаниудын нэг болох Интерактив ХХК-ийн ТХЗ-ын албан тушаалыг хашиж байсан.

Ажиллах хугацаандаа түүний ахлаж ажилласан онцлох төслүүдэд Татварын Ерөнхий Газрын цахим онлайн систем, төрийн агентлагуудын тайлангийн ил тод байдлыг дэмжих Шилэн Данс систем ба Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем зэрэг орно. Б.Мөнх-Эрдэнэ Интерактив ХХК-аас гараад хамтрагчийн хамтаар Дата Сайнс ХХК-ийг үүсгэн байгуулсан. Тун удалгүй тэрээр Монголын цахим эдийн засагт дэвшилтэт өөрчлөлтүүдийг авчирсан билээ.

# Ажлын замнал

**Бүрэнжаргалын Мөнх-Эрдэнэ**
Технологи хариуцсан захирал

2008 онд сургуулиа төгсөөд ажлын гараагаа Эзнис Эйрвэйз ХХК-ний Мэдээлэл Технологийн мэргэжилтнээр эхэлсэн. 2010 онд тэрээр Мобиком ХХК-д программистаар ажилд орж, код бичиж эхэлсэн.

2012 онд Интерактив ХХК-д иргэний бүртгэлийн системийн программыг бичих ажлын санал авч тус компанийн ТХЗ (CTO) хүртлээ өсөн дэвшиж төрийн олон төслийн ажлыг ахлан удирдсан.

2017 онд тэрээр Махариши Мэдээлэл Технологийн Их Сургуульд суралцах бүрэн тэтгэлгийн санал хүлээн авсан ч хувийн тодорхой шалтгааны улмаас тэрээр тус сургуульд суралцалгүй өөрийн стартап компани болох Дата Сайнс ХХК-ийг хөрөнгө оруулагчийн дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулсан юм. 2015 оны намар, Б.Мөнх-Эрдэнэ криптовалютын ертөнцийг нээж Монголын анхны Этириум олборлох төхөөрөмжийг угсарсан байна.

2017 онд тэрээр хөгжүүлэгч, програмистуудын багийг ахлан Монголын анхны криптовалютын биржийн платформ болох trade.mn-ийг бүтээсэн болно. 2020 онд тэрээр дотоодын зах зээлд зориулсан бичил зээлийн салбарын тэргүүлэгч компани болох Zeel.mn болон бүх платформд хэрэглэж болох цахим төлбөрийн систем буюу Storepay.mn зэрэг төсөл амжилттай  ажилласан юм. 2020 оны сүүлээр Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран, Монголын хамгийн том виртуал хөрөнгийн арилжааны платформ болох DAX.mn-ний back-end-ийн хөгжүүлэлтийг хийсэн бөгөөд тус бирж нь өдгөө 400 мянган идэвхтэй хэрэглэгчтэй болсон байна.



**Отгонбаатарын Мөнхжин**
Санхүү хариуцсан захирал

О.Мөнхжин нь амжилттай энтрепреньер, санхүүгийн зах зээлийн эксперт, үнэт цаасны трейдэр, криптовалютын хөрөнгө оруулагч, венчур капиталист ба анжел хөрөнгө оруулагч юм. Тэрээр МОТ Велт Холдингс Корпорацийг үүсгэн байгуулагч бөгөөд ерөнхийлөгчөөр нь ажилладаг. Хөрөнгө оруулалт, арилжаа амжилттай хийх чадвараараа 25 насандаа Монголын хамгийн залуу ам.долларын саятан болсон юм. Түүний мэргэшсэн салбаруудад компаний санхүү, менежментийн тайлан тооцоо, хөрөнгийн хуваарилалт, портфолиогийн эрсдэл, мөнгөний менежмент ба хөрөнгө оруулалт зэрэг сэдэв ордог.

Б.Мөнхжингийн холдинг компани нь үнэт цаас, криптовалют, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулалтаар мэргэшсэн байдаг. Тэрээр олон нийтийн сүлжээнд 350,000 дагагчтай санхүүгийн зах зээлийн инфлүүнсэр, багш юм.

Munkhjin Otgonbaatar I Linkedin
Munkhjin Otgonbaatar I Facebook
Munkhjin Otgonbaatar (@themunkhjin) I Instagram

# Ажлын замнал

**Отгонбаатарын Мөнхжин**
Санхүү хариуцсан захирал

Б.Мөнхжингийн бизнес, хөрөнгө оруулалтын амжилт эгэл даруу эхлэлтэй. Дунд сургуулиа төгсөөд тэрээр хөрөнгийн зах зээлийн эксперт, трейдэр болох мөрөөдөл өвөртлөн АНУ-ыг зорьсон. 2011 онд тэрээр санхүүгийн зах зээлийн талаар болон арилжаа хэрхэн хийх талаар бие даан суралцаж эхэлсэн байна. 2016 онд тэрээр их сургуульд сурч байхдаа хөрөнгийн болон форекс биржийн зах зээл дээр олон удаа алдаж оносны эцэст амжилттай дэй трейдэр (өдөр тутмын арилжаа хийдэг трейдэр) болж чадсан.

Тэрээр, Вашингтоны Их Сургуулийн Фостерын Бизнесийн Сургуулийг эдийн засгийн ухаанаар мэргэшсэн санхүүгийн мэргэжлээр онц дүнтэй төгссөн. Сургуулиа төгсмөгц нь түүнд Сиаттлд төвтэй 300 тэрбум ам.долларын хөрөнгийн менежментийг хариуцдаг баялгийн менежментийн компани болох Рассэл Инвестментс ажиллах санал тавьснаар тэрээр дериватив болон OTC (биржийн бус зах зээл) свопын шинжээчээр ажлын гараагээ эхэлжээ.

2017 оноос АНУ-д өөрийн баялгийн менежментийн компанийг байгуулж гэрээсээ ажиллаж эхэлсэн. Түүний хөрөнгийн зах зээл дэх хөрөнгө оруулалтууд, баялгийн менежментийн стратегиуд нь зах зээлийн индексээс тогтмол 25%-иар илүү амжилттай хэрэгжиж ирсэн. Сүүлийн 4 жилийн турш түүний хөрөнгө оруулалтын багц дунджаар 45%-ийн өгөөжтэй байна.
Түүний хамгийн амжилттай хийсэн арилжаануудын нэг нь 2020 оны 3-р сард S&P 500-г 35 хувиар унахыг урьдчилан тооцоолсноор тус оны 2-р сард S&P 500 зах зээлийн индексийг шорт-селл хийсэн арилжаа юм. Тэрээр, 2020 оны мөн сард КОВИД-19 цар тахлаас улбаалсан зах зээлийн хямралын үеэр хөрөнгө оруулалт хийснээр 70 хувийн өгөөжтэй арилжаа хийж чадсан байна.

Munkhjin Otgonbaatar I Linkedin
Munkhjin Otgonbaatar I Facebook
Munkhjin Otgonbaatar (@themunkhjin) I Instagram

# Ажлын замнал

**Отгонбаатарын Мөнхжин**
Санхүү хариуцсан захирал

2017 оноос тэрээр криптовалютыг судалж, хөрөнгө оруулалт хийж эхэлсэн. Биткойны 2017 оны сүүлийн өсөлтүүдийг урьдчилан таамаглаж чадсан бөгөөд өөрийн сошиал медиа сувгуудаар уналтанд орохыг нь олон нийтэд анхааруулж байсан. 2019 оны эхээр криптовалютын зах зээлийн доод үнийн түвшинг мөн урьдчилан таамаглаж чадсан бөгөөд биткойнд хөрөнгө оруулж эхэлсэн. Түүний арилжааны стратегийг дагасан олон дагагчид нь ашигтай арилжаа хийж чадсан юм.

2019 онд тэр МОТ Велт Эдукэйшнийг үүсгэн байгуулж хөрөнгийн зах зээлд арилжаа, хөрөнгө оруулалт хэрхэн хийх талаар хүмүүст сургалт зохион байгуулж эхэлжээ. Өөрийн академиар дамжуулан 5,300 гаруй хүнд сургалт, ментор хийсэн бөгөөд тэдгээрээс 2,000 гаруй нь өнөөдөр бүтэн цагаар хөрөнгө оруулалт, арилжаа хийх чиглэлээр амжилттай ажиллаж байна.

2020 онд О.Мөнхжин МОТ Велт Холдингс Корпорацийг Улаанбаатар хотод үүсгэн байгуулсан. МОТ Велт Холдингс Корпораци нь таван охин компанитай: МОТ Велт ХХК, МОТ Велт Майнинг Корпораци, МОТ Капитал Инкорпорэйтэд, МОТ Велт Хөрөнгийн Менежмент ба МОТ Велт Эдукэйшн.

О.Мөнхжин анхан шатнаас ахисан түвшин хүртэлх хөрөнгө оруулагчдад зориулан хөрөнгө оруулалт, арилжааны талаарх мэдээлэл агуулсан 400 хуудас "Форекс, хөрөнгийн зах зээлийн арилжааны сурах бичиг" бичиж худалдаанд гаргасан нь тэр дороо борлуулагджээ. Тэрээр TomYo Edtech, Happy Messy Humans зэргээс эхлээд олон стартапуудад амжилттай хөрөнгө оруулалт хийсэн.

Munkhjin Otgonbaatar I Facebook
Munkhjin Otgonbaatar (@themunkhjin) I Instagram



**Баярсайханы Эрхэмбаяр**
Мэдээлэл Технологи Хариуцсан Захирал

## Хураангуй

Б. Эрхэмбаяр нь Монголдоо нэр хүндтэй трейдэр ба хөрөнгө оруулагч юм. Тэрээр карьерынхаа сүүлийн 13 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээлийн арилжаа, хөрөнгө оруулалтын амжилтаа тэгээс эхлэсэн. Өдгөө тэрээр ХАРУ Группын үүсгэн байгуулагч бөгөөд дийлэнх хувийн эзэмшигч юм. 2012 оноос хойш арилжаа болон хөрөнгө оруулалт хийх сонголт, шийдвэрүүдээ өөрийн сувгуудаар дамжуулан нээлттэй хуваалцсаар ирсэн. Түүний дүн шинжилгээ, арилжааны сонголтыг дагасан олон хүн ашигтай арилжаа хийж чадсан бөгөөд “Е” үсэгтэй энгийн лого нь Монголын санхүүгийн салбарт нэр хүндтэй олонд танигдсан таних тэмдэг болсон.

## Ажлын замнал

Б.Эрхэмбаярын ажил, амжилтын гараа нь эгэл даруу эхлэлтэй. Тэрээр, 2008 онд Мираж Продакшнд саунд инженерээр ажиллаж байхдаа хөрөнгийн зах зээлийн талаар судалж, арилжаа хийж эхэлсэн. Тэрээр ихэнхи цалингаараа арилжаа хийж хөрөнгө оруулалтын багцаа босгож чадсан бөгөөд 3 жилийн дараа “Соло Рекордс” бичлэгийн студиогоо нээсэн. Түүний арилжаа, хөрөнгө оруулалтын амжилтын нууцыг Довын онол (Dow’s theory), Сэрээний аргачлал (Andrew’s pitchfork) зэрэг графикийн зүй тогтол ашигладаг түүний өвөрмөц арилжааны стартегитай холбож тайлбарладаг.

Swing traders I Facebook
Swing Traders I YouTube

**Баярсайханы Эрхэмбаяр**
Мэдээлэл Технологи Хариуцсан Захирал

Swing traders | Facebook
Swing Traders | YouTube

# Ажлын замнал

2015 онд Б.Эрхэмбаяр криптовалютад хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд 2017 оны эцэс хүртэл их өсөлтийн Bull Trend-ийг дагасан. Биткойны $19,000 хүрсэн хамгийн дээд түвшинд тэрээр криптовалютын бүх хөрөнгө оруулалтаа хааж гарсан. 2019 онд криптовалютын доод үнийг мөн олж харч дахин хөрөнгө оруулалт хийсэн. Одоо түүний хөрөнгө оруулалтуудын ашиг 3-аас 4 оронтой хувиар өссөн байна.

2018 оноос хойш Б.Эрхэмбаяр нь ХАРУ Группын үүсгэн байгуулагч, тэргүүнээр ажиллаж байгаа бөгөөд тус Групп нь тавилга үйлдвэрлэгч ХАРУ Мебель ХХК, AIWA Electronics-ийн Монгол дахь дистрибьютор, электрон барааны худалдааны ХАРУ Электроникс ХХК болон санхүүгийн үйлчилгээний Хару Лизинг ХХК зэргээс бүрддэг.

Б.Эрхэмбаяр нь Swing Traders нэрээрээ олон нийтийн сүлжээнд байдаг төрөл бүрийн онлайн группыг ахладаг. Тэрээр өөрийн сувгуудаар дамжуулан үнэгүй онлайн сургалтууд тогтмол хийдэг. Түүний Discord дээрх сервер нь 20,000 гишүүнтэй, YouTube суваг нь 10,300 дагагчтай ба Инстаграм дээр 30,000 дагагчтай байна. Б.Эрхэмбаярын Discord серверийн гишүүд сар тутмын гишүүнчлэлийн хураамж төлдөг бөгөөд гишүүдийн нэгдсэн дансанд цугласан хураамжийг сайн үйлсэд хандивладаг. Эдгээр группээс гадна түүний дүн шинжилгээ, таамаглалуудын ихэнхи нь олон нийтэд онлайн хэлбэрээр нээлттэй тавигддаг.



**Бат-Эрдэнийн Идэр-Од**
Маркетинг Хариуцсан Захирал

# Хураангуй

Б.Идэр-Од нь технологийн салбарын энтрепреньер, олонд танигдсан комедиан юм. Түүнийг Монголчууд комедиан гэдгээр нь сайн мэдэх бөгөөд тэрбээр Монголын анхны стэндап комедиануудын нэг юм. Өөрийн үеийнхний нөлөө бүхий төлөөлөгч, инфлүэнсэрд тооцогддог тэрээр олон нийтийн сүлжээнд сая гаруй дагагчтай. Б.Идэр-Од үүлэн технологид суурилсан дуудлагын төвийн үйлчилгээ үзүүлдэг КоллПро (CallPro) болон хэл сурах гар утасны апп ХиппоКардс (Hippocards)-ын үүсгэн байгуулагчдын нэг юм. Тэрбээр Улаанбаатар хотын төвд байршилтай, боловсролд төвлөрсөн бизнес болох ФАРО группыг мөн хамтран үүсгэн байгуулсан.

# Хувийн намтар

Б.Идэр-Од нь 2011 онд АНУ-ын Канзасын Их Сургуулийг агаарын хөлгийн инженер мэргэжлээр төгссөн. Эх орондоо эргэж ирээд тэрбээр МИАТ компанид онгоцны засвар үйлчилгээний инженерээр 3 жил ажиллаад хувийн бизнесээ хөгжүүлж эхлэжээ.

Монголын анхны стэндап комеди клубын үүсгэн байгуулагчдын нэг Б. Идэр-Од нь 2018 онд ганцаарчилсан тоглолтоо 1,500 хүний өмнө хийсэн ба тус тоглолтын контентын эрхийг Монголын хамгийн олон үзэгчтэй стрийминг платформ болох Ори худалдаж авсан байна.

Ider-Od Bat-Erdene I Facebook
Ideree Podcast I YouTube
Ider-Od Comedian I YouTube
Ider-Od Bat-Erdene (@iderodcomedian) I Instagram

# Ажлын замнал

**Бат-Эрдэнийн Идэр-Од**
Маркетинг Хариуцсан Захирал

2014 онд Б.Идэр-Од үүлэн технологид суурилсан дуудлагын төвийн үйлчилгээ үзүүлдэг КоллПро (CallPro)-г үүсгэн байгуулсан бөгөөд өдгөө тус компани нь Монголын 1,000 гаруй бизнес, албан байгууллагад үйлчилгээгээ хүргэж байна.

Б.Идэр-Од бизнесийн хамтрагч А.Бямбажаргалтай Хиппокардс хэмээх гадаад хэл сурах гар утасны апп-ийг санаачилсанаар тоглоомоор дамжуулан 11 орны хэлийг сурах хичээл, уралдаан, толь бичиг болон бусад холбогдох контентыг хөгжүүлсэн. 2020 оны байдлаар Хиппокардс нь 700,000 таталттай, 100,000 өдөр тутмын идэвхтэй хэрэглэгчтэй бол болсон байна. Тус апп нь одоогоор дотоодод бета хувилбараар байгаа бөгөөд удахгүй олон улсад гаргана.

Б.Идэр-Од А.Бямбажаргалын хамтаар мөн ФАРО группыг үүсгэн байгуулсан. ФАРО Групп нь Сингапурын Менежментийн Хөгжлийн Хүрээлэнгээс эрхэлдэг Олон улсын суурь диплом олгох Ерөнхий боловсролын дараах коллежийн хөтөлбөрүүдийг санал болгодог. Анх хэлний сургуулиар үүсгэн байгуулагдаж байсан ФАРО Групп өдгөө жилд 6,000 оюутанд 30 төрлийн богино хугацааны сургалтын хөтөлбөрийг санал болгож байна. Фаро Фаундэйшн (Faro Foundation) нь олон нийтийн дижитал бичиг үсгийн чадвар сайжруулах сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Ider-Od Bat-Erdene I Facebook
Ideree Podcast I YouTube
Ider-Od Comedian I YouTube
Ider-Od Bat-Erdene (@iderodcomedian) I Instagram

# МАНАЙ ЗӨВЛӨХҮҮД

14



**Марк Эйбсхаус**

Марк Эйбсхаус нь Аугустус Интернэйшнл Мастер Фанд LP (Augustus International Master Fund LP)-ийн ерөнхий партнер юм. Түүний ажлын үндсэн үүрэг бол тус сангийн хөрөнгийн хуваарилалт, багцын эрсдэлийн менежмент, үйл ажиллагаа, удирдлага, маркетинг, харилцагчдын үйлчилгээ, дэлхийн хаанаас ч хамтран ажиллах боломжит трейдэрүүдийг олохтой холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг удирддаг. Ноён Эйбсхаус нь Аугустус Капитал ХХК (өмнө нь АНУ-ын Санхүүгийн салбарын зохицуулах газрын зөвшөөрөлтэй брокер-дийлэр байсан)-ийн залгамжлагч компани болох Аугустус Адвайзорс ХХК-ийн Тэргүүн ба Гүйцэтгэх гишүүн юм.

Аугустус Адвайзорс нь өөрсдийн болон ОУ-ын хөрөнгийн хуваарилалтын талаар зөвлөгөө өгдөг, үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгийг эрсдэлийн сан, хувийн өмчлөлийн хувьцаа, үл хөдлөх хөрөнгө, байгалийн баялаг гэх мэт "альтернатив хөрөнгө оруулалт"-ын янз бүрийн шийдэл гаргаж удирддаг. Тус компани нь Аугустус Сангийн менежментийн компаниудын ерөнхий түнш бөгөөд бүртгэлтэй (бүртгүүлэх шатандаа яваа) хөрөнгө оруулалтын зөвлөх юм.

2015-2019 онд Марк альтернатив хөрөнгө оруулалтад (эрсдэлийн сан) суурилсан финтекийн хөрөнгө оруулалтын платформ болох Хортон Пойнт ХХК-ийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. Одоогийн байдлаар Марк нь дэлхийн үл хөдлөх хөрөнгийн шинэлэг арилжааны бүтээгдэхүүнээр мэргэшсэн Global Index Group фирмийн стратегийн зөвлөхөөр ажиллаж байгаа бөгөөд тус бүтээгдэхүүнийг ашиглан аливаа хөрөнгө оруулагч үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийг удирдаж, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мөчлөгийн уналтаас ашиг олох боломжтой.

**Марк Эйбсхаус**

Тэрээр томоохон байгууллагуудын арилжаалагч, хөрөнгө оруулалтын багцын менежерээр ажиллаж байсан бөгөөд Уолл Стритийн арилжааны худалдах, худалдан авах талын арвин туршлагатай. Ажлын замналынхаа эхний хагаст тэрбээр Salomon Brothers-д АНУ-ын засгийн газрын бондын арилжаалагч, Morgan Stanley-ийн арилжааны ширээний менежер (бүх төрлийн хөрөнгийн деривативаар мэргэшсэн), Lazard Freres Asset Management-ийн дэлхийн портфолиогийн менежерээр ажиллаж байсан байна. Энэ үед тэрбээр биржийн арилжааны олон талбайд удаан ажилласан туршлагатай. 1997 онд Аугустус Капитал ХХК-ийг үүсгэн байгуулахаас өмнө ноён Абесхаус нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, биотехнологийн эрсдэлийн сан болох Aries Fund-ийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд эрсдэлийн менежмент, бизнес хөгжил, маркетинг хариуцдаг байжээ. Тэрээр АНУ-д үр дүнтэй хэрэгжсэн дараах үнэт цаасны  бүртгэлийг бие болгосон: Series 3 (Commodity Features); Series 5 (Interest Rate Options); Series 7 (General Securities Representative); Series 15 (Foreign Currency Options); Series 24 (General Securities Principal); Series 63 (State Blue Sky); Series 65 (Registered Investment Advisor); and Series 79 (Investment Banking).

Пеннсильваний Их Сургуулийн Вартон сургуулийг санхүүгийн мэргэжлээр, Эдийн засгийн бакалаврыг Magna Cum Laude буюу улаан дипломтой (1978), Чикагогийн Их Сургуулийн Бизнесийн Сургуулийг санхүүгийн магисртийн зэргийг Magna Cum Laude буюу улаан дипломтой (1980) дүүргэсэн тэрээр Pi Gamma Mu болон Beta Gamma Sigma Honor Нийгэмлэгүүдийн гишүүн юм. Марк Эйбсхаус нь олон нийтийн болон сайн үйлсийн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Тэрээр компаний шүүхийн өмгөөлөгчтэй гэрлэж хоёр хүүхэдтэй болсон ба мини-дахсхунд нохойтой. Нью-Йоркийн Вестчестер мужид амьдардаг тээрээр спорт сонирхдог бөгөөд хөзөр тоглох дуртай.



**Базарын Габит**

Б.Габит нь Улаанбаатарт төвтэй, олон улсын мэдээллийн технологийн шийдлийн цогц үйлчилгээ үзүүлэгч Инфинити Сольюшнс ХХК-ийн үүсгэн байгуулагч, тэргүүн юм. Тус компани санхүүгийн технологи, бизнесийн шийдэл, мэдээлэл технологийн аутсорсинг үйлчилгээг дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэд хүргэдэг.

Тэрээр Стэнфордын их сургуулийн Менежментийн шинжлэх ухаан, инженерийн тэнхимийн төгсөгч билээ. Б.Габит нь хамтрагчдынхаа хамт хөрөнгө оруулалт амжилттай босгосон бөгөөд Хойд Америк, Азид хэд хэдэн стартап компаниудыг нээсэн байна.

Түүний гол экспертиз буюу мэргэшсэн салбар нь дэлхий хэмжээний энтрепреньерийн бизнес стратеги, програм хангамжийн архитектур, технологи, бүтээгдэхүүний тогтвортой хөгжил юм. Одоогийн байдлаар тэрээр ихэнх цагаа хиймэл оюун ухааны судалгаа, хэрэглээ, мэдээллийн технологийн боловсрол, блокчэйн, NFT, FinTech-ийн хөгжилд зарцуулж байна.



**Асиад Мажид**

Шведийн Зэвсэгт хүчний багш асан Асиад Мажид нь дэлхийд орлогоороо тэргүүлэгч eSport тэмцээний платформ болох Yamzu компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал юм. Yamzu платформд 26 орны геймэрүүд тоглодог.

Олон улсын туршлагатай насан туршийн энтрепреньер Асиад нь Yamzu платформыг нээх, түүний бизнесийн хөгжлийн үе шат бүрийг хөгжүүлэхэд өөрийн бүхий л оюун мэдлэгээ зориулсан. Асиад Лулеа техникийн их сургуульд эдийн засаг, менежментийн чиглэлээр суралцсан. Их сургуулиа төгсөөд Коста Рика улсад таван жил худалдааны байгууллагын бизнес төлөвлөтийг удирдаж Америкийн Форбс, Йоркийн хөрөнгө оруулалтын фирмд ажиллаж байжээ. Тэрээр Шведэд буцаж ирээд тус улсын зэвсэгт хүчинд алба хашсан ба түүний манлайлах чадварыг үнэлэн сургагч багшаар үлдэж ажиллахыг санал болгож байжээ. Асиад Швед, Англи, Испани, Араб хэлээр чөлөөтэй ярьдаг.



**Шонхорын Батхишиг**

Ш.Батхишиг нь үнэт цаасны нөлөө бүхий дүүжин арилжаалагч (swing trader) юм. Тэрээр хөрөнгийн менежмент, арилжааны стратеги, альтернатив хөрөнгө оруулалт, АНУ-ын хөрөнгийн зах зээлд мэргэшсэн мэргэжилтэн юм. Ш.Батхишиг нь Нью Йорк дахь Hold Brothers Capital компанид үнэт цаас арилжаалагч (2013-2014), Нью Маунтэн Капитал ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээчээр (2016 оны 9-р сараас 2018 оны 11-р сар хүртэл) ажиллаж байсан ба "Централ Капитал" ХХК-ийн түнш, үнэт цаасны багцын менежерээр 2018 оны сүүлээс эхлэн ажиллаж байна. Үүнээс гадна, бие даасан бүтэн цагийн трейдэр билээ.

Тэрээр Централ Капитал ХХК-ийн түншүүдтэйгээ хамтран 14 сая ам.долларын санг удирдсанаар сарын дотор сангийн хөрөнгөө 20 сая ам.долларт хүргэсэн бол жилийн дотор түүнийгээ ойролцоогоор 43 хувиар өсгөжээ. Түүний арилжааны багцаас үзвэл тэрээр Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийснээр гурван жилийн дотор гурван сая төгрөгийг 37.8 сая төгрөг болгосноос гадна Форекс, Азийн хувьцаа, пенни хувьцааг эзэмшдэг байна. 2010 онд тэрээр АНУ-ын blue chip хувьцаа арилжаалахад анхаарлаа төвлөрүүлж, найман жилийн дотор дансаа 2.1 сая ам.долларт хүргэжээ.

Ш.Батхишиг нь 2016 онд NYU Stern Business School-ийг санхүүгийн хэрэгсэл, зах зээлд төвлөрсөн бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан.

Batkhishig Shonkhor | LinkedIn



**Стефэн Чен**

Стефэн Чен нь компани болон гэр бүлийн оффисын сүлжээг бий болгосон олон улсад чиглэсэн  бизнес удирдагч юм.

Тэрээр төр болон хувийн хэвшлийн хоорондын түншлэлд зүтгэсэн 20 жилийн арвин туршлагаа дэлхийн түвшний бизнесийн өсөлтийг хурдасгах үйл ажиллагаанд зориулж байна.

Стефэн Чений салбарын экспертүүдийн сүлжээ бий болгох, удирдах түвшний хүний нөөцийг татах чадвар нь онцгой ашиг тус авчирдаг. Тэрээр гэр бүлийн оффист Бизнес хөгжил, хөрөнгө оруулалтын захирлаар ажиллаж байжээ. Тэрээр Oppenheimer-ын Хойд Америкийн салбарт ажиллаж байснаас гадна JPMorgan Chase & Co., Bear Stearns Companies, Inc-ний дэд ерөнхийлөгч байжээ.

Стефэн нь Нью-Йорк хот дахь АНУ-ын Худалдааны Танхим, Хотын Газрын Институт, Нью-Йоркийн Хөрөнгө Оруулалтын Сүлжээ, Бизнес эрхлэлтийг сургалтын сүлжээ (NFTE)-ий гишүүн юм.

Стефэний хүмүүнлэгийн үйлсийг Wall Street Journal, New York Times, Washington Post, Fox News, ABC, NBC зэрэг сувгууд сурвалжлан нийтэлж байжээ. Тэрээр Йел, Браун, Нью-Йорк, Колумбын их сургуульд ярилцлага өгч байсан ба Orphans International-ын дэлхийн шилдэг иргэн, Dragon 100 Fellowship, C.V. Starr Fellowship шагналуудыг тус тус авч байжээ. Марио Калабрезийн "Сохор аз гэж байдаггүй", Вик Венкатраманы "Урам зоригтой бай" гэх номонд түүнийг жишээ болгож байжээ. Стефэн Нью Йоркийн болон Брауны их сургуульд боловсрол эзэмшсэн.



**Цогтбаатарын Энхжавхлан**

“Jay T” (Жэй Тий) гэдгээр олонд танигдсан Цогтбаатарын Энхжавхлан нь McKinsey-ийн Нью-Йорк дахь оффисын харилцагчийн үйлчилгээний менежер буюу “engagement manager”-аар ажиллаж байжээ.

McKinsey-д ажиллаж байхдаа тэрээр Digital McKinsey Practice-ийн гишүүн байсан ба ОУ-ын банк, хөрөнгө оруулалтын менежмент, даатгалын байгууллгатай хамтран ажиллаж, өгөгдөл, аналитик стратеги шинэчлэлт, өсөлтийн боломж, түншлэлийн платформ тодорхойлох, дижитал санхүүгийн үйлчилгээний экосистемийн бүтээн байгуулалт зэрэг стратегийн болон үйл ажиллагааны төрөл бүрийн сэдвээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байж. Жэй Тий өдгөө Хаан Даатгал ХХК-ийн орлогч захирлаар ажиллаж байна.

McKinsey-д ажиллахаасаа өмнө Жэй Пенсильванийн Их Сургуулийн Вартоны Сургуульд санхүү, энтрепреньерийн удирдлага чиглэлээр мэргэшсэн Бизнесийн Удирдлагын Магистрын зэргийг онц дүнтэй хамгаалсан (2016) байна. Тэрээр CFA III түвшинд бэлтгэж байгаа бөгөөд орос, англи хэлээр чөлөөтэй ярьдаг.



**Жош Жонсон**
Түгээлтийн зөвлөх

Жош Жонсон нь анагаах ухаан, финтек ба блокчэйний экосистемийн мэргэжилтэн билээ. Тэрээр Хятадын хамгийн том Ур чадвар хайх цахим платформ буюу https: //www.iyuedan.cn/-д зориулж дижитал валютыг бүтээсэн ба 80 сая хэрэглэгчдийг 10 сая гаруй үйлчилгээ үзүүлэгчтэй холбосон.

Тэрээр мөн United Enterprise-ийн (Pharma SOE Sinopharm E-Commerce-тэй хамтарсан) маркетингийн албаны даргаар ажиллаж байсан ба хятадын бүх мужийн нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан түгээх олон улсын брэндүүдийг тус улсад нутагшуулахад анхааран ажиллаж байсан.



**Саадик Ф. Эл-Амин III**

Доктор Садик Эль-Амин (Анагаахын ШУ-ны доктор) нь ортопедийн алдартай мэс заслын эмч, зохион бүтээгч, энтрепреньер юм. Тэрээр дэлхийд алдартай олимпийн тамирчид, NBA, NFL, MLB-гийн мэргэжлийн спортын оддын эмч бөгөөд тэдний ихэнхи нь төрөл бүрийн спонсорын үйл ажиллагаанд бизнесийн түншээр ажилладаг.

Ортопедийн мэс засалчаар мэргэшсэн тэрээр Эль-Амин Ортопед ба Спортын Анагаах Ухааны Хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал/эзэмшигч бөгөөд одоогоор Fox 5 Play to Win нэвтрүүлгийн зөвлөх эмч, Жоржиа Гвиннет коллежийн сэргээн засах анагаах ухааны профессор, Гвиннет Эмнэлгийн Тархины доргилтын хүрээлэнгийн захирлаар ажилладаг.

Тэрээр АНУ-ын Пенсильвани мужийн Филадельфи дахь Дрекселийн их сургуулийн Анагаах ухааны коллежид анагаах ухааны эмчийн зэрэг (MD), анагаахын шинжлэх ухааны магистр (MMS), молекул ба эсийн биологийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. Мөн Виржиниа мужийн Шарлотсвилл дахь Виржиниагийн Их Сургуулийн Эрүүл мэндийн шинжлэх ухааны төвд ортопедийн мэс заслын сургалтанд хамрагдсан. Тэрээр Нью-Йоркийн мэс заслын тусгай эмнэлэгт мөн спортын анагаах ухааны ортопедийн мэс заслын чиглэлээр судалгааны тэтгэлэгт хамрагдаж, боловсролоо дээшлүүлжээ. Тэнд байхдаа тэрээр Нью-Йорк Никс багийн туслах эмч болон Сент -Жонсон Их Сургуульд Доктор Ансворт Аллен, Доктор Лиза Каллаханы удирдлага дор ажиллаж байжээ

Доктор Эль-Амин нь анагаах ухааны салбарын сэтгүүлд 40 гаруй нийтлэл хэвлүүлж 50 орчим илтгэл тавьсан бөгөөд судалгааны олон тэтгэлгийн санхүүжилт авч байсан байна. Анагаах ухааны салбарын шилдгүүдийг онцолдог Leading Physicians of the World – Дэлхийн тэргүүний эмч нар шагналын 2017 оны “Шилдэг ортопедийн мэс засалч”-аар доктор Эль-Аминыг шалгаруулж байжээ. Түүний клиник Гвиннетийн 2018, 2019, 2020 оны шилдгээр дараалан шалгарсан байна. Тэрээр спорт сонирхогч дөрвөн хөөрхөн охины эцэг юм.

# АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

Инфляци Хэджинг Криптовалютын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудаснаас авна уу. {URL}


BBC. “The USA’s international influence.” 2021.
https://www.bbc.co.uk/bitesize/guides/z6frqp3/revision/2

Brito, Jerry; Castillo, Andrea. “Bitcoin: A Primer for Policymakers.” 2013.
https://www.mercatus.org/system/files/Brito_BitcoinPrimer.pdf

Cheng, Jeffrey; Powell, Tyler; Skidmore, Dave; Wessel, David. “What’s the Fed doing in response to the COVID-19 crisis? What more could it do?” 30 March 2021.
https://www.brookings.edu/research/fed-response-to-covid19/

Chohan, Usman W. “Decentralized Finance (DeFi): An Emergent Alternative Financial Architecture.” 26 January 2021.
https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3791921

Hayward, Andrew. “What is PancakeSwap? How to Use the Binance Smart Chain DEX.” 20 May 2021.
https://decrypt.co/resources/what-is-pancakeswap-how-to-use-the-binance-smart-chain-dex

Johnston, Matthew. “Worst Cases of Hyperinflation in History.” 31 July 2021.
https://www.investopedia.com/articles/personal-finance/122915/worst-hyperinflations-history.asp

McCracken, Michael. “How COVID-19 May Be Affecting Inflation.” 2 February 2021.
https://www.stlouisfed.org/on-the-economy/2021/february/covid19-affecting-inflation

Инфляци Хэджинг Криптовалютын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудаснаас авна уу. {URL}

Pancake Swap. “How to Trade.” June 2021. https://docs.pancakeswap.finance/products/pancakeswap-exchange/trade-guide

Rosenberg, David. “Don’t fight the Fed? Why investors should be wary of market manipulation.” 17 June 2020. https://financialpost.com/investing/investing-pro/david-rosenberg-dont-fight-the-fed-why-investors-should-be-wary-of-market-manipulation

Schrotenboer, Brent. “US is `printing’ money to help save the economy from the COVID-19 crisis, but some wonder how far it can go.” 12 May 2020. https://www.usatoday.com/in-depth/money/2020/05/12/coronavirushow-u-s-printing-dollars-save-economy-during-crisis-fed/3038117001/

Smith, Adam. “The Wealth of Nations.” 3 March 1776. https://www.gutenberg.org/ebooks/3300

Tully, Shawn. “Bitcoin tanks even as inflation jumps.” 12 July 2021. https://fortune.com/2021/07/13/bitcoin-price-down-50-percent-inflation-hedge

World Gold Council. “Beyond CPI: Gold as a strategic inflation hedge.” 15 July 2021. https://www.reuters.com/article/sponsored/beyond-cpi-gold-as-a-strategic-inflation-hedge

# ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА ЭС ҮҮРЭХ ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

# Эрсдэлийн хүчин зүйлс

Ямар ч худалдан авалт өндөр эрсдэлийг дагуулж байдаг. Худалдан авагчид эдгээр эрсдэлийн талаар дараах мэдээллийг худалдан авалт хийхээс өмнө сайтар судалж үзэх хэрэгтэй. Хэрэв дараах эрсдэлийн аль нэг нь үнэхээр тохиолдвол Апп болон токены үнэ цэнэд ихээхэн сөргөөр нөлөөлж болохыг анхаарна уу.

Манай Компаний менежментийн зүгээс чухал гэж үзсэн эрсдэл, тодорхой бус нөхцөл байдлуудыг энд тайлбарласан боловч эдгээрээс өөр эрсдэл, тодорхой бус нөхцөл үүсэхийг үгүйсгэхгүй. Бидний өнөөгийн байдлаар чухал гэж үзээгүй эсвэл таамарлаагүй эрсдэл, тодорхой бус нөхцлүүд нь манай бизнес, Апп болон токены үнэлгээнд сөргөөр нөлөөлөх боломжтой.

## 1. ҮНЭЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛҮҮД

**1.1 Энд тодорхой зааснаас бусад функц, эрх болон онцлогууд ороогүй болно.** Танилцуулгын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд Аппликэйшнд ямар нэгэн ашиглалт, зорилго, шинж чанар, функционал байдал, онцлогийг багтаасан илэрхийлэл эсвэл шууд илэрхийлэгдэх ямар ч эрх, хэрэглээ, зорилго, шинж чанар, функц ороогүй болно.

**1.2 Зах зээлийн бэлэн бус байдал.** IHC-ыг өмнө нь нээлттэй зах зээлд олон нийтэд арилжаалж байгаагүй учир IHC-ын борлуулалт нь идэвхтэй, хөрвөх чадвартай зах зээл үүсгэлгүй үнийн дүн ихээхэн савлагаатай байх магадлал бий.

Хэдийгээр, IHC-ыг арилжаалах хүсэлтээ криптографик токены биржүүдэд гаргасан боловч, IEO (анхдагч биржийн санал)-ын дараа идэвхтэй хэрэглэгчдийн зах зээл бүрдэхгүй, удаан хадгалагдахгүй байж болно. IHC-ын хувьд хөрвөх чадвартай зах зээл үүсгэж чадаагүй тохиолдолд үнийн тогтворгүй байдал бий болж Койн эзэмшигчид койноо зарах болон бусад арилжаа гүйлгээнд орох боломжгүй болох магадлалтай.

**1.3 Хэт их таамаглалтай үнээс үүдэх эрсдэл.** Цахим токен ба койны хоёрдагч зах зээлийн үнэлгээ нь тодорхой бус байдаг бөгөөд өндөр таамаглалтай байдаг. Энэхүү танилцуулгыг гаргах үед IHC нь ямар нэг биет хөрөнгөөр баталгаажаагүй бөгөөд ямар нэг хөрөнгийн эзэмшигч биш болно. Тиймээс, арилжааны үнэ богино хугацаанд ихээр савлах магадлалтай. Токен эзэмшигч өөрийн оруулсан хөрөнгийг бүхэлд нь алдах өндөр эрсдэл байгааг анхаарна уу. Хамгийн муугаар бодоход, эзэмшиж байгаа койнууд нь үнэ цэнгүй болох ч эрсдэл бий.

**1.4 Үнэ цэнгүй болох эрсдэл.** IHC-ын зах зээлийн хөрвөх чадварт ямар нэг баталгаа байхгүй болно. Манай компани нь IHC-ын зах зээлийн үнэлгээ, гүйлгээг шилжүүлэх болон хөрвөх чадвар эсвэл аливаа зах зээл байгаа эсэхийг гуравдагч этгээдээр дамжуулан олж тогтоох үйл явцыг хариуцахгүй, хариуцлага хүлээхгүй болно.

**1.5 Оруулсан мөнгөн дүн буцаан олгогдохгүй.** Борлуулалттай холбоотой хууль тогтоомжид эсвэл хууль ёсны хүчин төгөлдөр баримт бичигт хатуу заасан тохиолдлоос бусад тохиолдолд манай компани ямар нэгэн шалтгаанаар токен эзэмшигчдийн оруулсан мөнгийг буцаан олгох үүрэг хүлээхгүй бөгөөд токен эзэмшигчид мөнгө болон бусад хэлбэрийн олговорын буцаан олголтын нөхөн төлбөр гэж авахгүй болно.

**1.6 Сөрөг сурталчилгааны эрсдэл.** Манай Компани болон Апп-ийн талаар эсвэл IHC-той холбоотой сөрөг сурталчилгаа нь үндэслэлтэй эсэхээс үл хамааран зах зээлийн ойлголт, зах зээлийн үнэд нөлөөлж болзошгүй.

**1.7 Татвараас үүдэлтэй эрсдэл.** Татварын зохицуулалт IHC дээр тодорхой бус байна. Худалдан авагч нь IHC-ыг худалдан авах, хадгалах, шилжүүлэх, ашиглахтай холбоотой татварын талаар зөвлөгөө мэдээллийг өөрийн хариуцлагаар олж авах ёстой. IHC-ыг худалдан авах, хадгалах, шилжүүлэх, ашиглах нь худалдан авагчид татварын сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй бөгөөд үүнд татварын суутгал, шилжүүлгийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, орлогын татвар болон түүнтэй адилтгах татвар, хураамж, шимтгэл, татварын тайлагналын шаардлага зэрэг орж болох бөгөөд боломжит татварын эрсдэлүүд эдгээрээр хязгаарлагдахгүй болно.

## 2. БЛОКЧЭЙН БА ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ЭРСДЭЛҮҮД

**2.1 Блокчэйны удаашралын эрсдэл.** Криптовалют ба холбогдох гүйлгээнд (жишээлбэл, Этириум, Биткойны блокчэйн) ашигладаг ихэнх блокчэйн дээр блок үйлдвэрлэх хугацааг ажлын нотолгоогоор (прууф-оф-уорк) тодорхойлдог ба блок үйлдвэрлэл нь санамсаргүй байдлаар хуваарилагдаж хийгддэг. Жишээ нь: Токен борлуулалтын сүүлийн хэдэн секундэд төлбөр хийгдсэн криптовалют тухайн мөчлөгтөө багтаагүй байж болно. Холбогдох блокчэйн нь худалдан авагчийн гүйлгээг шилжүүлэгчийн төлөвлөсөн хугацаанд шилжүүлж амжаагүй байх тохиолдол үүсдэг бөгөөд төлбөрийн дүн нь хаягласан цахим хэтэвчинд худалдан авагчаас криптовалютыг илгээсэн өдөрт нь орохгүй байх магадлалтай.

**2.2 Блокчэйны хэт ачааллын эрсдэл.** Криптовалютын гүйлгээнд ашигладаг ихэнх блокчэйн (жишээлбэл Этириум, Биткойны блокчэйн) дээр гүйлгээ удаашрах эсвэл алдагдах тохиолдлууд хэт ачааллын улмаас үе үе гардаг. Хувь хүмүүс криптографик токен худалдаж авахдаа давуу тал үүсгэхийн тулд сүлжээг санаатайгаар ачааллуулах тохиолдол мөн гардаг. Ингэснээр блок үйлдвэрлэгчид худалдан авагчийн гүйлгээг хүссэн үед нь хийхгүй байх, эсвэл огт хийхгүй байх ч тохиолдол гарч болзошгүй.

**2.3 Програм хангамжийн сул талуудын эрсдэл.** Ухаалаг гэрээний ойлголт, суурь програм хангамж, програм хангамжийн платформууд (өөрөөр хэлбэл Этириум, Биткойн блокчэйн) нь хөгжлийн эхний шатанд байгаа бөгөөд бүрэн туршигдаж, баталгаажаагүй хэвээр байна. IHC-ыг үүсгэх үйл явц тасалдалгүй, алдаагүй байх болно гэсэн баталгаа байхгүй. Криптовалютаа тэр чигээр нь алдах эрсдэлтэй бөгөөд үүнд програм хангамжийн сул тал, эмзэг байдал эсвэл алдаа агуулсан эрсдэлээс шалтгаалдаг.

**2.4 Шинэ технологийн эрсдэл.** Апп, IHC болон энэхүү танилцуулгад өгүүлсэн бүх хүчин зүйл нь шинэ бөгөөд практикт шалгагдаагүй болно. Апп болон IHC-ыг хийж дуусгах, бүтээх, хэрэгжүүлэх, түгээх боломжгүй болох магадлалтай. IHC-ыг худалдан авагч нь Апп, токены ухаалаг гэрээ эсвэл Апп-тэй холбоотой IHC-ыг ирээдүйд хүлээн авах чадварт бүрэн найдахгүй байхыг анхаарна уу. Аппликэйшнийг дуусгаж, хэрэгжүүлж, хэрэглээнд түгээсэн ч энэ нь зориулалтын дагуу ажиллахгүй байх магадлалтай бөгөөд хүссэн эсвэл хэрэгтэй функцийг агуулаагүй байж магадгүй. Түүнчлэн, технологи хурдацтай өөрчлөгдөж байгаа тул Апп болон IHC хоцрогдож болзошгүй.

## 3. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ

**3.1 Хувийн нууц түлхүүрээ алдах эрсдэл.** IHC-ын токен эзэмшигч өөрийн дижитал хэтэвч эсвэл vault-д токеноо хадгалж болох ба түүнд нэвтрэхийн тулд хувийн түлхүүр эсвэл түлхүүрүүдийн хослол шаардлагатай болдог. Койн эзэмшигчийн дижитал хэтэвчийн хувийн нууц түлхүүрүүд алдагдсан тохиолдолд токен эзэмшигч хэтэвчинд байсан токены үлдэгдэлээ эсвэл гуравдагч этгээдийн блокчэйн дээр үүсгэсэн анхны үлдэгдлүүдээ алдах магадлалтай. Нэмж дурдахад ийм хувийн түлхүүрүүдэд нэвтрэх эрхтэй гуравдагч этгээд, түүний дотор хэтэвч эзэмшигчийн ашигладаг хэтэвч эсвэл хадгалалтын үйлчилгээнд нэвтрэх эрхийг авах замаар токен эзэмшигчийн IHC-ыг буруугаар ашиглах боломжтой болно.

**3.2 Токены аюулгүй байдлын сул тал.** IHC токеныг булаалгах эсвэл/хулгайд алдах эрсдэлтэй. Хакерууд болон бусад хорон санаат бүлэг, байгууллагууд IHC токен эсвэл IHC токеныг бий болгодог токены ухаалаг гэрээнд янз бүрийн арга замаар хөндлөнгөөс оролцохыг оролдож магадгүй ба үүнд вирустэй програмын дайралт, DoS халдлага, зөвшилцөлд суурилсан халдлага, Сибил халдлага, хууран мэхлэх буюу smurfing ба spoofing халдлагууд орох ба эдгээрээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу. Цаашилбал, БайненсСмартЧейн болон Этириум платформ нь нээлттэй эх үүсвэр буюу open-source програм хангамж дээр суурилдаг тул БайненсСмартЧейн болон Этириум ухаалаг гэрээнд IHC токенд сөргөөр нөлөөлөх эсвэл IHC токен алдагдах, IHC токен руу нэвтрэх эсвэл хянах чадвар алдагдахад хүргэж болзошгүй санаатай болон

санамсаргүй алдаа, сул талууд агуулагдах эрсдэлтэй байдаг. Програм хангамжийн ийм алдаа эсвэл сул тал гарсан тохиолдолд сайжруулах ямар ч арга хэмжээ авах боломжгүй бөгөөд IHC токен эзэмшигчид хариу арга хэмжээ авах, буцаан олголт буюу нөхөн төлбөр авах баталгаагүй болно.

**3.3 Токены ухаалаг гэрээний халдлага.** Ухаалаг гэрээг байгуулахад ашигладаг блокчэйн нь олборлолтын довтолгоонд өртөмтгий байдаг ба үүнд давхар зарцуулалтын халдлага, том хэмжээний олборлолтын хүчний довтолгоо, "хувиа хичээсэн" довтолгоо, уралдааны халдлага гэх мэт ордог. Аливаа амжилттай халдлага нь токены ухаалаг гэрээнд эрсдэл учруулж, токен гүйлгээг зүй ёсоор гүйцэтгэх, дараалал үүсгэх, гэрээний тооцооллыг хуваарийн дагуу гүйцэтгэх, дараалалд оруулах зэрэгт эрсдэл учруулдаг.

**3.4 Худалдан авагчийн дансны нээлттэй түлхүүрийн мэдээлэл буруу байх.** Худалдан авагч дансны нээлттэй түлхүүрийн мэдээллийг буруу эсвэл дутуу оруулах нь гуравдагч этгээд БайненсСмартЧейн ба Этириум блокчэйн дээрх токены үлдэгдлээ таних чадваргүй болоход хүргэж болзошгүй. Энэ нь апп дээр суурилсан шинэ блокчэйн дээр анхны үлдэгдэл тохируулах үед ихэвчлэн гардаг.

**3.5 Хэтэвчний үйлчилгээ нийцэхгүй байх эрсдэл.** IHC-ыг худалдан авах, хадгалахад ашигладаг хэтэвч эсвэл хэтэвчийн үйлчилгээ үзүүлэгч нь техникийн хувьд IHC-тэй нийцэх ёстой. Үүнийг баталгаажуулаагүй тохиолдолд худалдан авагч токендоо хандах боломжгүй болоход хүрч болзошгүй юм.

**3.6 Токений борлуулалтаас босгосон хөрөнгийг хулгайлах эрсдэл.** Манай компани токен борлуулалтаас хүлээн авсан мөнгийг найдвартай хадгалахын тулд аюулгүй байдлын шаардлагатай бүх арга хэмжээг авахад бүх хүчин чармайлтаа гаргана. Аюулгүй байдлын ийм арга хэмжээ авсан хэдий ч БайненсСмартЧейн, Этириум эсвэл бусад блокчэйн дээр ямар нэг хэлбэрээр ухаалаг гэрээ (нүүд)-г хакердах, боловсронгуй кибер халдлага, DoS хадлага хийх, вэбсайт дахь алдаа, эмзэг байдал, согог зэргээс болж криптовалютыг хулгайд алдах эрсдэл үүсэхгүй гэх баталгаа байхгүй. Тухайлбал, ийм үйл явдал програмчлал эсвэл эх кодын алдааг урвуулан ашигласнаас үүдэж гарч болзошгүй юм. Ийм тохиолдолд токен борлуулалт дууссан ч гэсэн манай компани цуглуулсан криптовалютыг хүлээн авах боломжгүй байдал үүсч болзошгүй бөгөөд энэ хөрөнгийг Апп хөгжүүлэх болон/эсвэл ирээдүйн бизнесийг эхлүүлэхэд ашиглах боломжгүй байх магадлалтай. Энэ нөхцөлд Апп-ийг эхлүүлэх ажлыг түр эсвэл бүр мөсөн хааж болох ба тараасан IHC нь үнэ цэнгүй болж  арилжааны үнэд ч нөлөөлнө.

**3.7 Эскроу түрийвчтэй холбоотой эрсдэлүүд.** Хүлээн авагч банкны эксроу хэтэвчний хувийн түлхүүрийн аюулгүй байдал алдагдаж, криптовалютыг олгох боломжгүй болох эрсдэлтэй. Эскроу хэтэвч нь аюулгүй байдлыг хангах зориулалттай байдаг. Хувийн гурван (3) түлхүүр эзэмшигчтэй Эскроу хэтэвчийг хамгаалахад бүх хүчин чармайлтаа дайчлана. Ямарваа нэгэн шалтгаанаар, гурван (3) түлхүүрийн хоёр (2) нь алдагдсан, устсан эсвэл ямар нэг байдлаар хэрэглэх боломжгүй болсон тохиолдолд эскроу хэтэвчинд хадгалсан мөнгийг буцааж авах, олгох боломжгүй бөгөөд бүр мөсөн сэргээгдэхгүй байх эрсдэлтэй. Ийм тохиолдолд токены борлуулалт амжилттай болсон ч манай компани босгосон хөрөнгөө хүлээн авах, уг хөрөнгийг Апп хөгжүүлэхэд ашиглах боломжгүй болно. Ийм эрсдэл учирвал, тараасан IHC нь үнэ цэнгүй болох ба энэ нь түүний арилжааны үнэд нөлөөлнө.

## 4. КОМПАНИТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛҮҮД

**4.1 Муу менежменттэй холбоотой эрсдэлүүд.** Компаний засаглал болон койны бодлогыг манай компани хэрэгжүүлэх боловч бизнес хөгжүүлэлтийн явцад үйл ажиллагаа доголдох, удирдлагын чадамжгүй байдал нь Аппликэйшн хөгжүүлэлт ирээдүйн бизнесийн чиглэлд шууд нөлөөлөх боломжтой.

**4.2 Ширүүн өрсөлдөөнт орчны эрсдэл.** Санхүүгийн технологи, криптовалютын салбар дах манай компаний өрсөлдөж буй зах зээл нь өндөр өрсөлдөөнтэй бөгөөд өнгөрсөн жилүүдэд хурдацтай хөгжиж, технологийн шинэ дэвшил, бизнесийн загварын өөрчлөлт болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр хөгжсөөр байна.
Энэхүү байнга өөрчлөгдөж буй орчны улмаас манай компани өөрчлөлтөд дасан зохицоход үйл ажиллагааны бэрхшээлтэй тулгарч болзошгүй бөгөөд компаний тогтвортой байдал, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чадвар, боловсон хүчний бодлого мэргэшсэн, чадварлаг ажилчдыг хөлслөх, зохих сургалтад хамруулах эсэхээс хамаарна. Бизнес хөгжихийн хэрээр компани үйл ажиллагааны дэд бүтцээ өргөжүүлж, дасан зохицох ёстой. Бид өөрсдийгөө амжилттай өрсөлдөж чадна гэсэн баталгааг өгч чадахгүй болно.

**4.3 Дэлхийн зах зээл, эдийн засгийн ерөнхий нөхцөлтэй холбоотой эрсдэл.** Дэлхий даяар үе үе тулгарч буй эдийн засгийн сорилтууд нь мэдээллийн технологийн салбарын өсөлтийг удаашруулахад нөлөөлж магадгүй. Эдийн засгийн сул дорой байдал нь бизнес, үйл ажиллагаа, санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй ба үүнд орлого, үйл ажиллагааны мөнгөн урсгалын бууралт, ирээдүйд өөрийн болон/эсвэл өрийн санхүүжилтийг зах зээлийн боломжийн нөхцөлд хүртэл бууруулах чадваргүй болгодог.

Нэмж дурдахад, эдийн засгийн хямралын үед манай компани арилжаа, аппликэйшний ашиглалтын удаашралын сөрөг үр дагаварыг мэдэрч амжихгүй байж магадгүй юм.

**4.4 Оюуны өмчийн эрхийг хамгаалахгүй байх эрсдэл.** Компаний үйл ажиллагаа нь патент, барааны тэмдэг, патентгүй өмчийн ноу-хау, худалдааны нууцад суурилсан байдаг бөгөөд ноу-хау, худалдааны нууцыг хамгаалахын тулд ажилчид, зөвлөхүүдтэй хийсэн нууцлалын гэрээ зэрэг арилжааны үндэслэлтэй аргуудыг ашигладаг. Гэсэн хэдий ч эдгээр нь бүрэн хамгаалалт болж чадахгүй байх магадлалтай бөгөөд гуравдагч этгээдүүд ноу-хау, худалдааны нууцыг бие даан боловсруулж, манай компаниас илүү сайн үйлдвэрлэлийн арга боловсруулж чадахгүй гэсэн баталгаа бид өгөхгүй.

**4.5 Оюуны өмчийн зөрчлийн эрсдэл.** Өрсөлдөгч бусад аж ахуйн нэгж, хувь хүмүүс манай компаний бүтээгдэхүүн, шийдэлтэй холбоотой оюуны өмчийг эзэмшиж эсвэл өмчлөх эрхтэй байж болзошгүй. Манай компаний бүтээгдэхүүн, шийдэл, суурь технологи нь гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчсөн байж болно. Манай компани бусад компаний зарим бүтээгдэхүүн, технологийг хамарсан оюуны өмчийн эрхийн талаар ойлголтгүй байж болно.

## 5. АПП ХӨГЖҮҮЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛҮҮД

**5.1 Гуравдагч этгээдээс хамааралтай байхтай холбоотой эрсдэл.** Хөгжүүлж дууссаны дараа ч Апп нь хэсэгчлэн болон бүтнээрээ гуравдагч этгээдийн түгээлт, хэрэгжүүлэлт, хөгжүүлэлт, нийлүүлэлт, дэмжлэгээс хамааралтай байсаар байх болно. Гуравдагч этгээд үүргээ зохих ёсоор биелүүлэх, эс бөгөөс хэн нэгний хэрэгцээнд нийцүүлж үүргээ хангана гэсэн баталгаа байхгүй бөгөөд энэ бүхэн нь Аппликэйшнд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

**5.2 Апп-ийн удирдах багаас хамаралтай байдал.** Апп-ийн өрсөлдөх байр суурийг тоорхойлох үүрэгтэй менежментийн удирдах багийн чадвар нь тухайн багийн гишүүн бүрийн ажлын хувь нэмрээс ихээхэн хамаардаг. Менежментийн удирдах багийн гишүүдийн ажлын хувь нэмэр буурах, ажлаасаа гарах эсвэл менежментийн удирдах багт нэмж боловсон хүчин татах, хадгалах чадваргүй болох нь Апп-д ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Тус салбарт цөөн тооны мэргэшсэн хүмүүс байх тул туршлагатай боловсон хүчний төлөө өрсөлдөөн улам ширүүсч байгаа хэдий ч одоогийн удирдах багаа хэвээр нь хадгалж үлдэх нь Апп-ийн хөгжүүлэлтэд ихээхэн нөлөө үзүүлнэ.

**5.3 Апп-ийн янз бүрийн хүчин зүйлээс хамааралтай байдал.** Апп хөгжүүлэлтийг олон нийтийн зүгээс сонирхол татахгүй байх, санхүүжилтгүй болох, арилжааны салбарт амжилт олохгүй байх, гол ажилтнууд төслийг орхих зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй байж болно.

**5.4 Аппликэйшнд гарах өөрчлөлтүүд.** Аппликэйшн нь тогтмол хөгжүүлэлтийн явцад үйл ажиллагаа нь идэвхитэй байдаг ба цаг хугацаа өнгөрөх тусам мэдэгдэхүйц өөрчлөлтүүд гардаг. Хэдийгээр төслийн менежментийн баг энэхүү аппликэйшнийг тус танилцуулгад заасан онцлог шинж чанаруудыг агуулахыг зорьж буй боловч тус онцлог шинж чанар, тодорхойлолтыг ямар ч шалтгаанаар өөрчилж болох бөгөөд ингэснээр Апп нь токен эзэмшигчийн хүлээлтэд нийцэхгүй байх магадлалтай.

**5.5 Шинэ технологи нэвтрүүлэх чадвар.** Блокчэйн технологийн салбар нь технологийн хурдацтай өөрчлөлт, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний сайжруулалт, түгээлтийн шинэ арга байнга нэвтрүүлж байдаг бөгөөд эдгээрийн аль ч хүчин зүйл нь одоогийн бидний шийдлийн эрэлтийг бууруулж эсвэл хоцроож болдог.

**5.6 Бусад аппликэйшнтэй холбоотой эрсдэл.** Аппликэйшний нээлтийг дагаад уг төсөлтэй ямар нэг холбоогүй гуравдагч этгээдийн өөр өөр төслүүд гарч болзошгүй бөгөөд эдгээр төслийн дор Токен нь ямар ч үнэ цэнгүй болох боломжтой.

**5.7 Криптовалютын үнэ цэнийн таагүй хэлбэлзэл үүсэх эрсдэл.** IHC-ын борлуулалтын орлого нь криптовалютаар илэрхийлэгдэх бөгөөд бусад криптограф болон уламжлалт (фиат) валют руу хөрвүүлэгдэх боломжтой байна. Хэрэв криптовалютын үнэ цэн Т окен борлуулах явцад болон дараа нь санаанд хүрэхгүй хэмжээнд хэлбэлзэж байвал төслийн менежментийн баг хөгжүүлэлтийг санхүүжүүлэх боломжгүй, эсвэл Апп-ийг хүссэн хэлбэрээр нь хөгжүүлэх, хадгалах боломжгүй болж магадгүй.

**5.8 Компани эсвэл аппликэйшнийг татан буулгах эрсдэл.** Этириум, Биткойн эсвэл бусад криптограф болон уламжлалт (фиат) валютын ханшийн таагүй хэлбэлзэл, хэрэглэгчдийн хандлага сөрөг байсны улмаас Апп-ийн хэрэглээ унах, бизнесийн хамтын харилцаа холбооны доголдол, эсвэл оюуны өмчийн өмчлөлийн бэрхшээл үүсэх зэрэг шалтгаанаас болон эдгээрээр хязгаарлагдахгүй Аппликэйшн цаашид ажиллах боломжгүй болж компани татан буугдах эрсдэлд орж болзошгүй.

## 6. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ГАРАХ ЭРСДЭЛҮҮД

**6.1 Ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл.** Манай Компани нь холбогдох хувьцаа эзэмшигчид, түүний хяналтанд байдаг эсвэл хувьцаа эзэмшдэг компаниуд болон бусад түншүүдтэй холбогдох этгээдүүдтэй хэлцэл хийж болох бөгөөд цаашид ч үргэлжлүүлэн хийх боломжтой. Манай хамтрагч нарын хооронд ашиг сонирхлын

зөрчил үүсч, улмаар зах зээлийн зарчмын бус арилжаа, гүйлгээг хийх нөхцөл үүсч болзошгүй юм.

**6.2 Компанийн үйл ажиллагааг хүчингүй болгохтой холбоотой эрсдэл.** Манай компани нь бизнесийн хувьд олон төрлийн арга хэмжээ хэрэгжүүлж байгаа боловч хэрэв эдгээр нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлээгүй гэж буруутгагдсан бол бизнесийн үйл ажиллагааны хувьд үйл ажиллагаа цуцлагдах эсвэл тухайн компаний төлөөлөлд хуулийн хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдэж магадгүй.

**6.3 Хөгжиж буй зах зээлээс үүсэх эрсдэл.** Бид хөгжиж буй зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа билээ. Хөгжиж буй зах зээл нь боловсорч хөгжсөн зах зээлүүдтэй харьцуулахад хууль эрх зүй, эдийн засаг, улс төрийн томоохон эрсдэлүүдэд илүү өртдөг. Хөгжиж буй эдийн засаг хурдацтай өөрчлөгддөг бөгөөд энэхүү танилцуулгад тусгагдсан мэдээлэл харьцангүй хурдан хуучрах магадлалтай.

## 7. ТӨР, ЗАСГИЙН ЭРСДЭЛ

**7.1 Хууль эрх зүйн тодорхой бус тогтолцоо.** Криптограф, дижитал хөрөнгө, блокчэйн технологийн зохицуулалтын статус нь олон улс оронд тодорхойгүй эсвэл хараахан тогтоогдоогүй байсаар байна.

Төрийн байгууллагууд ийм технологийг хэрхэн яаж зохицуулахыг таамаглахад хэцүү. Үүнтэй адил төрийн аль нэгэн байгууллагын зүгээс криптограф, дижитал хөрөнгө, блокчэйн технологи, түүний хэрэглээнд нөлөөлөх хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулах эсэх, оруулах бол хэрхэн болон ямар өөрчлөлт оруулахыг таамаглахад хэцүү байдаг. Ийм өөрчлөлт нь IHC-д янз бүрийн байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй ба үүний нэг жишээ нь IHC-ыг бүртгүүлэх шаардлагатай санхүүгийн хэрэгсэл гэж тодорхойлох явдал юм.
Засгийн газраас авах арга хэмжээний улмаас Апп хөгжүүлэлт, цаашдын үйл ажиллагаа нь хууль бус гэж ангилагдсан, эсвэл бизнесийн хувьд Апп-ийг үргэлжлүүлэн ажиллуулах нь зохисгүй, алдагдалтай нөхцөл бүрдсэн тохиолдолд Апп хөгжүүлэлт, түгээлтийг зогсоох эсвэл хуулиар хамарсан бүс нутагт үйл ажиллагаагаа зогсоох зэрэг арга хэмжээг авч болно.

**7.2 Холбогдох лиценз, зөвшөөрөл авч хадгалах эсвэл сунгаж чадахгүй байх эрсдэл.** IEO-г эхлүүлэх өдрийн байдлаар Компаниас үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад шаардагдах тусгай зөвшөөрөл, лицензийн хууль эрх зүйн шаардлага байхгүй боловч ирээдүйд ийм хууль эрх зүйн шаардлагууд үүсэх эрсдэл байгаа бөгөөд эдгээр нь манай компаний үйл ажиллагааны аль ч хэсэгт нөлөөлж болзошгүй. Ийм тохиолдолд, бизнесийн үйл ажиллагаа нь лиценз, зөвшөөрлийн үргэлжлэх хугацаа, түүний нөхцлийг дагаж мөрдөхөөс шалтгаалах болно. Эрх зүйн зохицуулах байгууллагууд

тусгай зөвшөөрөл олгох, сунгах хугацаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн лицензийн нөхцлийг дагаж мөрдөхөд хяналт тавихдаа ихээхэн эрх мэдэлтэй байх нь гарцаагүй. Эдгээр эрх мэдэлтнүүдээс тавьж болох шаардлагууд нь Компани ба компаний холбогдох этгээдийг олон тооны стандартыг дагаж мөрдөх, мэргэшсэн боловсон хүчин элсүүлэх, шаардлагатай техникийн тоног төхөөрөмж, чанарын хяналтын систем ажиллуулах, үйл ажиллагааг хянах, зохих мэдүүлгийг хөтлөх, хүсэлтийн дагуу мэдээлэл ирүүлэхийг шаардах зэрэг орно. Эдгээр шаардлагыг биелүүлж ажиллуулах нь өртөг өндөртэй, цаг хугацаа их орох магадлалтай бөгөөд энэ нь Апп-ийн үйл ажиллагааг эхлүүлэх эсвэл үргэлжлүүлэх хугацааг хойшлуулахад хүргэж болзошгүй. Цаашилбал, хувь хүмүүс болон олон нийт шүүхийн процесст хөндлөнгөөс оролцох, улс төрийн дарамт шахалт үзүүлэх зэргээр тусгай зөвшөөрөл олгох үйл явцад нөлөөлөх, оролцох боломжтой болох юм. Ингэснээр, аливаа нэг талын шаардлагаас улбаалж лиценз олгохгүй, сунгахгүй, эсвэл олгосон, сунгасан бол цаг тухайд нь гүйцэтгээгүй, эсхүл Компаний аль нэг этгээдийн үйл ажиллагаа явуулах, үр ашигтай ажиллах боломж хязгаарлах шаардлага агуулсан байж болно.

**7.3 Төр засгийн үйл ажиллагааны эрсдэл.** Бидний үйл ажиллагаа явуулж буй салбар нь шинэ бөгөөд байцаалт, хууль сахиулах ажиллагаа зэрэг өндөр хяналт, шалгалт хийгдэх нөхцөл бүрдэж болзошгүй. Төрийн байгууллагуудаас манай компаний үйл ажиллагааг шалгаж/эсвэл манай үйл ажиллагааны эсрэг гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй гэсэн баталгаа байхгүй. Ингэснээр бидний бизнес шүүхийн шийдвэр, төлбөр тооцоо, торгууль зэрэгт орох эрсдэлтэй бөгөөд үйл ажиллагаагаа өөрчлөн зохион байгуулах, эсвэл зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоо болиход хүргэж болзошгүй бөгөөд энэ нь бидний нэр хүндэд муугаар нөлөөлж, үйл ажиллагааны зардал нэмэгдэхэд хүргэнэ. Энэ бүхэн нь Апп-ийн хөгжил ба/эсвэл боловсруулалтанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ.

**7.4 Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудын ээдрээтэй байдал ихсэх эрсдэл.** Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, төрийн хяналт шалгалтын дүгнэлтийг дагаж мөрдөхгүй байх, эсхүл бидний үйл ажиллагаанд төрийн зохицуулалт нэмэгдэх нь нийцэл, комплайанстай холбоотой ихээхэн хэмжээний нэмэлт зардал гарах эсвэл хориг арга хэмжээнд орох зэрэг эрсдэлийг дагуулах бөгөөд манай бизнесийн болон Апп-ийн үйл ажиллагааны бодит үр дүнд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Бидний бизнесийн үйл ажиллагаа болон эд хөрөнгө нь одоогийн хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг байнга дагаж мөрдөхтэй холбоотойгоор төрийн байгууллага ба агентлагуудын зохицуулалтаас байнгын хамааралтай байдаг. Зохицуулах эрх бүхий байгууллагууд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын мөрдөлт, орчуулга дээр ихээхэн эрх мэдэлтэй байдаг. Эрх бүхий холбогдох байгуулагуудаас жилийн турш компаний үйл ажиллагаа, эд

хөрөнгөд тогтмол хяналт шалгалт хийх эрхтэй байдаг бөгөөд энэ эрхээ ч тогтмол хэрэгжүүлдэг. Цаашид хийх аливаа шалгалтаар Компани болон түүнтэй холбогдох этгээд хууль, тогтоол, дүрэм журмыг зөрчсөн гэж дүгнэж болох бөгөөд ийм дүгнэлтийг үгүйсгэх, зөрчлийг арилгах боломжгүй байж магадгүй. Компаний төлөөллийн зүгээс хууль тогтоомж, дүрэм журам, төрийн шалгалтын дүгнэлтийг дагаж мөрдөөгүйн улмаас торгууль, шийтгэл хүлээх эсвэл илүү хатуу шийтгэл хүлээх эсвэл тухайн компаний төлөөлөл нь бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох, мөн эрүүгийн болон захиргааны шийтгэл хүлээх эрсдэл дагуулдаг. Ийм аливаа шийдвэр, шаардлага, хориг арга хэмжээ, эсвэл холбогдох үйл ажиллагааны төрийн зохицуулалт нэмэгдэх нь бидний зардлыг өсгөж, манай бизнес болон Апп-д сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

**7.5 Хууль бус, дур мэдэн гүйцэтгэсэн төр засгийн үйл ажиллагаа.** Төрийн эрх бүхий байгууллага, этгээдүүд нь өндөр эрх мэдэлтэй, түүнийгээ зарим тохиолдолд урьдчилж мэдэгдэлгүйгээр болон ямар нэг албан ёсны шийдвэргүйгээр улс төрийн болон бизнесийн ашиг сонирхлын нөлөөллөөр хууль бус үйлдэл гаргах зэрэг эрсдэл байж болно. Түүгээр ч барахгүй Засгийн газар тодорхой нөхцөл байдалд зохицуулалтын болон засгийн газрын хуулиар гэрээний гүйцэтгэлд хөндлөнгөөс оролцох, хүчингүй болгох, цуцлах эрх мэдэлтэй байдаг. Хууль бус, нэг талыг баримталсан, дур мэдэн хийсэн төрийн үйл ажиллагааны өнгөрсөн жишээнүүдийг харахад тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, гэнэтийн татварын хяналт шалгалт оруулах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, иргэний зөрчил тооцох зэрэг байсан. Төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд токен арилжаатай холбоотой нийтлэг гардаг асуудлуудыг шалтаг болгон улс төрийн зорилгоор ашиглаж, шүүхэд нэхэмжлэл гаргах, аливаа гүйлгээг хүчингүй болгосон тохиолдлууд гарч байсан. Ийм орчинд манай өрсөлдөгчид төрөөс давуу эрхийг авч магадгүй бөгөөд энэ нь тэдэнд өрсөлдөөний давуу талыг бий болгох болно.

## 8. УРЬДЧИЛАН ТООЦООЛООГҮЙ ЭРСДЭЛ

Блокчэйн технологи ба криптовалют нь харьцангуй шинэ бөгөөд өөрчлөлт, шинэчлэл ихтэй технологи юм. Дээр дурдсан эрсдэлүүдээс гадна таны худалдан авах, эзэмших, ашиглахтай холбоотой бусад эрсдэл байдаг бөгөөд үүнд бидний таамаглаж чадахгүй эрсдэлүүд ч орно. Ийм эрсдэл нь дээр дурдсан эрсдэлүүдээс урьдчилж хараагүй өөрчлөлт хосолсон хэлбэрээр гарахыг үгүйсгэхгүй.

# ТОКЕНОМИКС

# ТОКЕНОМИКС

Токеномикс гэдэг нь криптовалют эсвэл блокчэйн төслийг эдийн засгийн талаас нь авч үзэх, судлах, дүн шинжилгээ хийх, түүний төрөлх дижитал токеныг загварчлах, түгээхэд онцгой анхаарал хандуулдаг нэр томъёо юм. Энэ нэр томьёо нь токен ба эдийн засаг гэсэн үгсийн нэгдэл юм.

IHC нь АНУ-ын жилийн инфляцийн мэдээлэл, мөн сарын Хэрэглээний Үнийн Индекс-д үндэслэн өөрийгөө шатаадаг.

Анх гаргасан дүн: 1 их наяд

**44%**
Шатаагдсан хэмжээ

**565 Тэрбум**
Нийт нийлүүлэлт

# Токеномиксийн нарийвчилсан жагсаалт

### IHC экосистемийг хангах зорилго

**300 тэрбум 1,2,3 жилийн хугацаанд түгжигдсэн**
Жил бүр АНУ-ын инфляцийн эсрэг шатаах нөөцтэй

Ухаалаг гэрээнд 260.5 тэрбум түгжигдсэн 100%
39.5 тэрбумыг шатаасан

### Үүсгэн байгуулагчид, баг, зөвлөхүүдэд

**110 тэрбум 3 жилийн хугацаанд түгжигдсэн**
Үүсгэн байгуулагчид болон багийн гишүүдэд нөхөн олговор олгохоор нөөцлөгдсөн

3 жилийн турш ухаалаг гэрээгээр түгжигдсэн 100%

### Defi хөрвөх чадварын сан бүрдүүлэх

**100 тэрбум**
Анх DEX дээр хөрвөх чадварыг хангах зорилгоор нөөцөлсөн

Шатаагдсан 100%

### Стратегийн түншлэл, хэрэглээнд нэвтрүүлэхэд

**80 тэрбум**
IHC-ийн хэрэглээг сурталчлах, зах зээлд гаргах зорилгоор нөөцлөгдсөн

1.5 тэрбум тараагдсан 100%
78.5 тэрбум үлдсэн

### Токен шатаах протоколын нөөц

**100 тэрбум**
Сар бүр X-Meta.com-ын худалдан авч, шатаадаг IHC токений хэмжээгээр тохируулагдсан.

90.38 тэрбум шатаагдсан 100%
9.62 тэрбум үлдсэн

### IFO хуваарилалт

**100 тэрбум**
IFO-д зориулан нөөцөлсөн

Шатаагдсан 100%

### Эргэлтэд буй нөөц

**100.5 тэрбум**
2021.08.25-нд IHC токений IEO-г амжилттай гаргаж, 0.00010527 долларын үнээр 100 тэрбум токен гаргасан.

5.27 тэрбум шатаагдсан 100%

### Airdrop хуваарилалт

**10 тэрбум**
IHC эзэмшигчдэд зориулсан airdrop түгээх зорилгоор нөөцлөгдсөн.

4.23 тэрбум тараагдсан 100%
5.76 тэрбум үлдсэн

### Стратегийн нөөц

**100 тэрбум**
Анх компанийн нөөцөд зориулж нөөцөлсөн

Шатаагдсан 100%

# ИХБИТ ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

# Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл

**Үндсэн мэдээлэл**

| Регистрийн дугаар | Оноосон нэр | Бүртгэсэн огноо | Хэлбэр | Төрөл | Хувьцаа эзэмшигч, гишүүний тоо | Хуулийн этгээдийн хаяг |
|---|---|---|---|---|---|---|
| 6740006 | Ихбит | 2021.08.10 | Хязгаарлагдмал хариуцлагатай компани | Ашгийн төлөө | 3 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимп, 19-А, "Шангри-Ла" оффис, 9 давхарт 907 тоот |

**Хувьцаа эзэмшигч, гишүүний мэдээлэл**

| Д/д | Ангилал | Улсын нэр | Эцэг/эх/-ийн нэр | Нэр | Бүртгэсэн огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэн | Монгол Улс | Баярсайхан | Эрхэмбаяр | 2022.02.21 |
| 2 | Иргэн | Монгол Улс | Отгонбаатар | Мөнхжин | 2022.02.21 |
| 3 | Иргэн | Монгол Улс | Баярмагнай | Гантиг | 2022.02.21 |

**Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээдийн мэдээлэл**

| Д/д | Албан тушаал | Улсын нэр | Эцэг/эх/-ийн нэр | Нэр | Бүртгэсэн огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гүйцэтгэх захирал | Монгол Улс | Баярмагнай | Гантиг | 2021.08.10 |

**Үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл**

| Д/д | Төлөв | Үйл ажиллагааны код | Үйл ажиллагааны чиглэл | Бүртгэсэн огноо |
|---|---|---|---|---|
| 1 | Тийм | 62090 | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа | 2021.08.10 |
| 2 | Тийм | 47910 | Онлайн худалдаа | 2021.08.10 |

**Эцсийн өмчлөгч**

| Дугаар | Ангилал | Эцэг/эх/-ийн нэр | Нэр | Бүртгэсэн огноо |
|---|---|---|---|---|
| 1 | Иргэн | Баярмагнай | Гантиг | 2022-02-21 |
| 3 | Иргэн | Отгонбаатар | Мөнхжин | 2022-02-21 |
| 2 | Иргэн | Баярсайхан | Эрхэмбаяр | 2022-02-21 |

# ИХБИТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

## “Ихбит” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

| Талууд | Хувьцаа эзэмшигчийн овог нэр | Регистрийн дугаар | Хувьцаа эзэмшигчийн хаяг | И-мэйл хаяг |
|---|---|---|---|---|
| “А” тал | Баярмагнайн Гантиг | ХБ87010878 | УБХ, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 1-р дөчин мянгат гудамж, 23-26 тоот | gantig@ihcoin.io |
| “Б” тал | Отгонбаатарын Мөнхжин | УУ92061115 | УБХ, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 120 мянгат, 3-9 тоот | mot@ihcoin.io |
| “В” тал | Баярсайханы Эрхэмбаяр | ШЕ85070618 | УБХ, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол, 3-37 тоот | erkhemee@ihcoin.io |

## “Ихбит” ХХК-ийн хувьцаа эзэмшил, хувьцааны тоо ширхэг, хувь хэмжээ:

| Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Нэрлэсэн үнэ | Хувьцааны үнэ | Компанид эзэмших хувь |
|---|---|---|---|---|
| Б.Гантиг | 174 | 100 | 17,400 | 33.15% |
| Б.Эрхэмбаяр | 174 | 100 | 17,400 | 33.15% |
| О.Мөнхжин | 177 | 100 | 17,700 | 33.7% |
| **Нийт** | **525** | **100** | **52,500** | **100%** |

# САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН (Шинэчилсэн)

INTER AUDIT

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Ихбит" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН

"ИНТЕР АУДИТ" ХХК

# АГУУЛГА


I. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. 2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
- АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
- АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
- АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

III. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА


ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## "ИХБИТ" ХХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| КОМПАНИЙН НЭР: | "Ихбит" ХХК |
| РЕГИСТРИЙН ДУГААР: | 6740006 |
| КОМПАНИЙН УДИРДЛАГА: | Б.Гантиг |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа<br>Онлайн худалдаа |
| КОМПАНИЙН ХАЯГ: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Министер Тауэр, 9 давхар, 909 тоот |
| УТАС: | 99052616 |

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ


INTER AUDIT

АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

**Аудитын компанийн хаяг:**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 802 тоот

**Холбогдох:**

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

INTER AUDIT

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 1

"Ихбит" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ИХБИТ" ХХК-ИЙН УДИРДЛАГАД

### ХЯЗГААРЛАЛТТАЙ ДҮГНЭЛТ

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Ихбит" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буйгаар дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан асуудлын санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийг эс тооцвол "Ихбит" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

2022 онд Pancakeswap, Apeswap, Bitmart, Bitglobal, KuCoin, MEXC, Digifinex, LBank, whiteBIT, Gate IO зэрэг биржүүд дээр Компанийн IHC койн листлэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор Компанийн зүгээс эдгээр биржүүд дээрх койны арилжааны нөөцийг хангах зорилгоор нийт 1.9 тэрбум IHC койныг гадны биржүүд рүү төлбөрийн хамт шилжүүлсэн байдаг. Лист хийгдсэн эдгээр биржүүдтэй байгуулсан гэрээнд заасны дагуу IHC койны арилжааны хэмжээг тодорхой хэмжээнд хадгалах үүргийг Компани хүлээдэг. Уг үйл ажиллагаатай холбоотой IHC койны арилжааны хэмжээг тодорхой түвшинд хадгалах зорилгоор гүйцэтгэж буй үйлдлийг нотлохын тулд дээр дурдсан биржүүдэд хийгдсэн бүх арилжааны түүх, үнэ ханшийн мэдээлэл, олз, гарзыг нотлох мэдээллийг тухайн биржүүдээс авч шалгах, аудитлах боломжгүй байгаа тул хязгаарлалтай дүгнэлт гаргав.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

### АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

2022 оноос эхлэн Компанийн үүсгэн байгуулагчдыг холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн гэх шалтгаанаар цагдаагийн байгууллагаас шалгаж, тайлант оны тодорхой хугацаанд түр саатуулсан. Уг хэрэг нь тайлант он дуусгавар болох хүртэл хараахан шийдэгдээгүй бөгөөд мөрдөн байцаалтын шатандаа байна. Уг шалтгааны улмаас IHC токены вайтпэйпэрийн дагуу хийх шатаалт, компани маркетинг болон бусад зорилгоор токен шатаалт хийх, удирдлагуудын зүгээс их хэмжээний токеныг бие даан бусад валлэт хаяг руу шилжүүлэг хийхийг прокурорын байгууллагаас хориглосон байна.

Мөн 2022 оны 09 дүгээр сард Компанийн үүсгэн байгуулагчдын нэг, Төлөөлөх удирдах зөвлөлийн дарга Б.Эрхэмбаяр нь зуурдаар таалал төгссөн. Эдгээр асуудлуудын улмаас Компанийн засаглалын тогтолцоонд томоохон өөрчлөлт орох нөхцөл бүрдсэн ч эрүүгийн хэрэг үүсэж мөрдөн байцаалтын шатанд явж байгаатай холбоотойгоор баримт бичгүүдэд өөрчлөлт орох боломжгүй байна.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

### АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ

Бид Компанийн энэхүү санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн тодруулгын "Дансны өр төлбөр" хэсэгт тодруулсан IHC койныг боловсруулсан гүйцэтгэгч талд өгөх өр төлбөрийн асуудлыг онцлов. Энэхүү онцолсон асуудалтай холбоотойгоор аудиторын дүгнэлтэд өөрчлөгдөөгүй болно.

Компани 2021 онд IHC койныг блокчейн системд хөгжүүлж гаргасан хувь хүнтэй хийсэн гэрээний дагуу 1,000,000 ам.доллар өгөх үүрэг хүлээсэн. Гэрээнд заасны дагуу Компани уг төлбөрийг 2022 оны 09 дүгээр сард төлж дуусгах ёстой боловч аудитын дүгнэлт гарах өдөр гүйцэтгэгч талд өгөх ам.доллароос огт төлөөгүй байгаа нь гэрээний үүргээ биелээгүй, цаашид үүнтэй холбоотой нэмэлт үүрэг, эрх зүйн хариуцлага хүлээх эрсдэлийг үүсгээд байна.

### БУСАД АСУУДАЛ

Удирдлага бусад мэдээллийн талаар хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь аудиторын мэргэжлийн шүүмжийн дагуу санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудитын тайлан болон аудиторын үүрэг, хариуцлагын талаар Компанийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд хамааралтай гэж үзсэн асуудал байна.

### УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

1. Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

2. Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.

3. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

5. Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Хүндэтгэсэн, "ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ
Ч.МӨНХБАЯР
ИНТЕР АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

Тайлангийн огноо: 2025/06/30

INTER AUDIT

# 2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2

"Ихбит" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит



## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТОД | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 323,094,200.00 | 22,021,481.55 |
| Дансны авлага | - | - | - |
| Татвар, НДШ-ийн авлага | 5 | - | 86,724,672.13 |
| Бусад авлага | 6 | 69,985,800.00 | 597,056,580.16 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 7 | 4,042,000,000.00 | 1,078,200,000.01 |
| Урьдчилж төлсөн зардал | 8 | 9,269,026,300.00 | 8,370,947,732.72 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | - | - | - |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **13,704,106,300.00** | **10,154,950,466.57** |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | | |
| Үндсэн хөрөнгө | 9 | 228,355,600.00 | 121,490,271.27 |
| Биет бус хөрөнгө | 10 | 18,181,800.00 | 18,181,818.20 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 11 | 6,854,890,000.00 | 4,414,890,000.00 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **7,101,427,400.00** | **4,554,562,089.47** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **20,805,533,700.00** | **14,709,512,556.04** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | | |
| Дансны өглөг | 12 | 5,162,883,700.00 | 3,969,046,750.85 |
| Цалингийн өглөг | 13 | 2,441,500.00 | - |
| Татварын өр | 14 | 2,162,031,000.00 | 1,312,617,991.62 |
| НДШ-ийн өглөг | 14 | - | 38,568,308.82 |
| Богино хугацаат зээл | - | - | - |
| Хүүгийн өглөг | - | - | - |
| Урьдчилж орсон орлого | 15 | 463,700.00 | 463,679.99 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - | - |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **7,327,819,900.00** | **5,320,696,731.27** |
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | | |
| Хойшлогдсон татварын өр | - | - | - |
| Урт хугацаат зээл | - | - | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **-** | **-** |
| **ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН** | | **7,327,819,900.00** | **5,320,696,731.27** |
| **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | | |
| Өмч: - Хувийн | 16 | 70,000.00 | 52,500.00 |
| Халаасны хувьцаа | 16 | (17,500.00) | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 17 | 516,798,000.00 | (1,447,002,000.00) |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | - | 12,960,863,300.00 | 10,835,765,324.77 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | - | **13,477,713,800.00** | **9,388,815,824.77** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | | **20,805,533,700.00** | **14,709,512,556.04** |

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТОД | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого /цэвэр/ | - | - | - |
| Борлуулалтын өртөг | - | - | - |
| **НИЙТ АШИГ /АЛДАГДАЛ/** | | - | - |
| Хүүгийн орлого | 18 | - | 21,986,301.37 |
| Ногдол ашгийн орлого | - | - | - |
| Бусад орлого | - | - | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 19 | - | 217,881,009.57 |
| Санхүүгийн зардал | - | - | - |
| Бусад зардал | 20 | - | 263,276,615.00 |
| Хөрөнгө оруулалт борлуулсны гарз | - | - | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/ | 21 | - | (9,560,000.00) |
| **Татварын өмнөх ашиг /алдагдал/** | | - | **(468,731,323.20)** |
| Орлогын татварын зардал | - | - | 2,198,630.14 |
| **ТАТВАРЫН ДАРААХ АШИГ /АЛДАГДАЛ/** | | - | (470,929,953.33) |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/ | - | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/** | - | - | **(470,929,953.33)** |
| **БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО** | - | - | **(721,800,000.00)** |
| Хөрөнгө оруулалтын үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - | (721,800,000.00) |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - |
| Бусад олз /гарз/ | - | - | - |
| **НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО** | | - | (1,192,729,953.33) |
| **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/** | | - | - |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ӨМЧ | ХАЛААСНЫ ХУВЬЦАА | ГАДААД ВАЛЮТЫН ХӨРВҮҮЛЭЛТИЙН НӨӨЦ | ЭЗНИЙ ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ | ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ) | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **52,500.00** | **(17,500.00)** | **(558,000,000.00)** | **1,039,815,500.00** | **(12,995,845,700.00)** | **13,477,696,200.00** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 17,500.00 | - | 558,000,000.00 | (523,017,500.00) | (34,982,400.00) | **17,600.00** |
| **ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ** | **70,000.00** | **(17,500.00)** | - | **516,798,000.00** | **12,960,863,300.00** | **13,477,713,800.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | - |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - |
| **2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **70,000.00** | **(17,500.00)** | - | **516,798,000.00** | **12,960,863,300.00** | **13,477,713,800.00** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | (1,242,000,000.00) | (1,654,168,021.90) | **-2,896,168,021.90** |
| **ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ** | **70,000.00** | - | - | **(725,202,000.00)** | **11,306,695,278.10** | **10,581,545,778.10** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | (470,929,953.33) | **(470,929,953.33)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | **0.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | **0.00** |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | (721,800,000.00) | - | **(721,800,000.00)** |
| **2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ** | 70,000.00 | (17,500.00) | - | (1,447,002,000.00) | 10,835,765,324.77 | 9,388,815,824.77 |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | - | **864,081.84** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | - | - |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| Буцаан авсан албан татвар | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | 864,081.84 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА** | - | **2,741,224,304.88** |
| Ажилчдад төлсөн | - | 206,646,516.06 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | - | 44,566,790.11 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | - | |
| Ашиглалтын зардалд төлсөн | - | 4,063,607.36 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | 1,403,000.64 |
| Хүүний төлбөрт төлсөн | - | |
| Татварын байгууллагад төлсөн | - | 1,886,473,356.33 |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | |
| Бусад мөнгөн зарлага | - | 598,071,034.38 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | (2,740,360,223.04) |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | - | **4,093,461,755.78** |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | 2,500,000,000.00 |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | 1,542,020,030.87 |
| Хүлээн авсан хүүний орлого | - | 51,441,724.91 |
| Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | - |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА** | - | **1,652,569,119.52** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | 60,000,000.00 |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | 1,592,569,119.52 |
| Бусад мөнгөн зарлага | - | - |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МГ** | - | 2,440,892,636.26 |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | - | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Төрөл бүрийн хандив | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | - |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА** | - | **536,800.00** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | - | 536,800.00 |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | - |
| Бусад мөнгөн зарлага | - | - |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | (536,800.00) |
| **Валютын ханшийн зөрүү** | - | (1,068,331.69) |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | (301,072,718.46) |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 323,094,200.00 | 323,094,200.00 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 323,094,200.00 | 22,021,481.55 |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3



## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Ихбит" ХХК нь 2021 оны 8 дугаар сарын 10-нд мэдээлэл технологийн үйл ажиллагаа, онлайн худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь 2021 оны 8 дугаар сарын 25-нд Initial Exchange Offering хийх үедээ 100,000,000,000 ширхэг Inflation Hedgin Coin (цаашид "IHC" гэх)-ыг нэг бүрийг нь 30 мөнгөөр гаргасан. Уг койны нийт нийлүүлэлт нь 1,000,000,000,000 ширхэг.

Компанийн албан ёсны бүртгэгдсэн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Министер Тауэр 9 давхар, 909 тоот.

Компани анх 4 хувьцаа эзэмшигчтэй байгуулагдсан ба 2022 оны 02 дугаар сарын 21-нд оруулсан дүрмийн өөрчлөлтийн дагуу 1 хувьцаа эзэмшигч өөрийн хувьцаагаа Компанид шилжүүлсэн. Ингэснээр доор харуулсны дагуу хувьцаа эзэмшлийн бүтэц өөрчлөгдсөн.

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Б.Гантиг | 174 | 33.15% |
| 2 | Б.Эрхэмбаяр | 174 | 33.15% |
| 3 | О.Мөнхжин | 177 | 33.7% |
| Нийт | | 525 | 100% |

Хувьцаагаа шилжүүлсэн өмнөх хувьцаа эзэмшигч болох Б.Идэр-Од-ын нэг бүр нь 100 төгрөгийн үнэ бүхий 25 хувийн 175,000 ширхэг хувьцааг 2022 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 04 тоот тогтоолд үндэслэн Компани худалдан авч халаасалсан.

## 2. ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

Монгол Улсад 2021 оны 12 сард "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай" хууль батлагдаж гарсан бөгөөд 2022 оноос эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн 6.1-д заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид Компани орохгүй. Гэхдээ, уг хууль мөрдөгдөж эхэлснээр Монгол Улсад арилжаалагдаж буй виртуал хөрөнгүүд тус хуульд заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо-нд бүртгүүлсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан виртуал хөрөнгийг арилжаалах үүрэгтэй. Компани ирээдүйд үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулна гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. 2024 оны аудитын тайлан гарахаас өмнө Компанийн тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой анхаарал татахуйц үйл явдлууд тохиолдсон ба шүүх, хяналтын байгууллага дээр үүссэн асуудалтай холбоотойгоор Компани нь 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй. Тайлант онд мөрдөж байгаа хууль эрх зүйн орчинд Компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт ороогүй боловч бизнесийн орчинд салбарын олон улсын нөхцөл байдлаас хамааран крипто хөрөнгийн үнэлгээ, арилжаа бууралттай байсан. Энэ нь Компанийн цаашдын үйл ажиллагааны тасралтгүй байдалд нөлөөлөхүйц байсан.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1.1-д заасан стандарт (Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт)-ыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ" гэж заасан байдаг. Сангийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 41 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлт тогтоох тухай" журмын 3.4.1-д "Нийт хөрөнгийн хэмжээ 0.5 тэрбум төгрөгөөс дээш" байх гэсэн шалгуурыг хангасан тул Компани нь санхүүгийн тайлан, тодруулгаа СТОУС-д нийцүүлэн бэлтгэсэн байна.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС (үргэлжлэл):

Компани анх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг (НББББ)-ээ СТОУС-д нийцүүлэн 2021 оны 11 дүгээр сарын 28-нд баталсан ба 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр "Орлого хүлээн зөвшөөрөлт"-ийн хэсэгтээ нэмэлт өөрчлөлт оруулан, уг өдрөөс шинэчилсэн хувилбараа мөрдөж эхэлсэн.

### ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ:

Хэмжилт нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрч, бүртгэх боломжтой мөнгөн дүнг тодорхойлох үйл явц юм. Үүний тулд хэмжилтийн суурийг тодорхойлно.

Санхүүгийн тайланг толилуулахдаа түүхэн өртөг, тайлант үеийн өртөг, цэвэр боломжит үнэ цэн, өнөөгийн үнэ цэн, бодит үнэ цэн зэрэг хэмжилтийн сууриудыг ашигладаг.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:

Байгууллагын ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. НББОУС 21 Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-нд Санхүүгийн тайланг толилуулж буй валютын толилуулгын валют гэж заасан байдаг. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.2 дахь "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнана" гэж заасны дагуу Компани нь санхүүгийн тайлан, тодруулгаа төгрөгөөр бэлтгэсэн.

Гадаад валютаар илэрхийлсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг. Ингэхдээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг мөрдлөг болгосон.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### СТОУС-ЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ (үргэлжлэл): :

НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт: Материаллаг байдлын тодорхойлолт: Нэмэлт өөрчлөлт нь "Материаллаг"-г шинэ тодорхойлолтыг: "Тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд аливаа мэдээллийг орхигдуулах, эсвэл буруу ташаа, тодорхой бус байдлаар илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн уг тайланг үндэслэн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлж болзошгүй тохиолдолд тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ." гэжээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь "материаллаг"-г санхүүгийн тайлангийн агуулгаар, тухайн мэдээллийн шинж чанар ба/эсвэл хэмжээгээс хамаарна гэдгийг тодорхойлсон. Мэдээллийг буруу ташаа илэрхийлэх нь үндсэн хэрэглэгчдийн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц бол үүнийг материаллаг гэж үзнэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Компанид нөлөөлөхгүй гэж үзэж байна.

2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлал: СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт 2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУСЗ нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс–д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

СТОУС 16–ийн заавры хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хамаарна. Эрт хэрэгжүүлж эхлэхийг зөвшөөрнө.

Компани түрээслүүлэгчийн хувьд зөвхөн нэг л төрлийн түрээсийн гэрээ байгуулсан тул СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно.

### МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

НББОУС 7 Мөнгөн Гүйлгээний Тайлан-д заасны дагуу Компанийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, чек, банк дахь харилцах, хадгаламж, гадаад, дотоод, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж, байгууллагын блокчейн хэтэвчинд байгаа ам.долларын тетер зэрэг санхүүгийн хөрөнгүүд зэрэг үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэл бүхий, тогтсон мөнгөн дүнд хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтуудаас бүрдэж байна. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Тайлант үеийн эцэст гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Монголбанкнаас зарласан хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлдэг ба үүссэн ханшийн зөрүүгийн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

### ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол  Улсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд  тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын  ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

### САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

#### Анхдагч хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхдагч шууд зардлыг бодит үнэ цэнийн хэмжилт дээр нэмж тооцдог. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн анхдагч шууд зардал (гүйлгээний шимтгэл гэх мэт ажил гүйлгээний зардал)-ыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

#### Ангилал

*Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* - Гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах зорилгоор эзэмшиж буй бизнесийн загвар бүхий санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд хамруулна. Гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болно. Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээрх жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд хамаарна. Дансны авлага нь үндсэн үйл ажиллагааны явцад зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон харилцагчаас авах мөнгөн дүн байна. Дансны авлагыг анх СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр-ийн 5.1.3-д заасны дагуу СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-д заасан мэдэгдэхүйц санхүүжилтийн хэлэлцээр агуулаагүй бол ажил гүйлгээ үнээр хэмжинэ.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

*Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах болон мөн арилжих зорилгоор эзэмшиж байгаа бол эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Мөн гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог санхүүгийн хөрөнгө. Түүнчлэн тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр болон тогтсон хугацаа байхгүй дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалтыг энэ ангилалд багтаана.

*Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* - Бодит үнэ цэнд үндэслэн гүйцэтгэлийг нь үнэлж, удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгийг дээр дурдсан 2 аргын шаардлага хангаагүй тохиолдолд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Өөрөөр хэлбэл тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн мэдээлэлд анхаарал хандуулдаг, тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлж, шийдвэр гаргахын тулд уг мэдээллийг ашигладаг, бизнесийн загварын хувьд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба борлуулах зорилгоор ч эзэмшдэггүй бол энэ аргын дагуу тухайн хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт нь тухайн бизнесийн загварын зорилгыг биелүүлэхэд зөвхөн тохиолдлын шинжтэй үйл явдал байдаг.

Өөрөөр хэлбэл, арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан авч, богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай санхүүгийн хөрөнгө хамаарна. Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг энэ ангилалд хамааруулж ангилахгүй.

### САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ (үргэлжлэл)

#### Дараа үеийн хэмжилт

*Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Тайлант үе бүрт үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үр ашигт хүүний түвшнээр тооцсон хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

*Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь санхүүгийн хөрөнгийг хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар толилуулна. Үүнд:

> *Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө* – Тайлант үеийн ашиг, алдагдлын бусад орлого эсвэл бусад зардлаар
>
> *Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө* – үнэ цэнийн өөрчлөлтийг "бусад дэлгэрэнгүй орлого"-оор тус тус толилуулна.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана.

#### Бодит үнэ цэнийн тооцоолол

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг  (олон нийтэд арилжигдсан дериватив болон арилжааны үнэт цаас гэх мэт) тайлант өдрийн арилжаа дуусах үеийн зах зээлийн ханшид үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр нийтлэгдсэн үнийн саналууд байгаа нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бөгөөд хэрэв байгаа бол тэдгээрийг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигладаг. "Идэвхтэй зах зээл дээр үнэлэгдсэн" гэсэн хэллэг нь бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнийн үйлчилгээ эсвэл зохицуулах агентлагаас санал болгож буй үнийг бэлэн бөгөөд тогтмол авах боломжтой гэсэн үг юм. Эдгээр үнэ нь зах зээлийн бодит ба тогтмол гүйлгээг илэрхийлдэг бөгөөд энэ нь хүндрэлтэй борлуулалт биш юм. Үнийг үндсэн зах зээлээс эсвэл үндсэн зах зээл байхгүй тохиолдолд хамгийн ашигтай зах зээлээс авч болно [СТОУС13(16)]. Зах зээлийн үнийг гүйлгээний зардалд тохируулах боломжгүй [СТОУС13(25). Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах түвшнийг хэрэглэнэ. Үүнд:

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

- I түвшин – Идэвхитэй зах зээл дээрх үнэ. Тухайлбал: арилжаа солилцооны зах зээл, дилер, брокер, оролцогчдын хоорондын зах зээл.
- II түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг шууд ба шууд бусаар үзүүлэх мэдээлэл. Тухайлбал: LIBOR ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп.
- III түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлэх зах зээл дээр ажиглагддаг мэдээллийг ашиглах бусад аргачлалууд

#### Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Үүнд:

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- Уг эрхээ бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийн эрсдэл өгөөж бүрэн шилжсэн эсвэл бүх эрсдэл өгөөжийг шилжүүлээгүй боловч захиран зарцуулах эрхийг нь шилжүүлсэн бол.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг худалдан борлуулсан бол бусад дэлгэрэнгүй орлогоор өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэрэгжээгүй бодит үнэ цэнийн хуримтлагдсан дүнг тайлант үеийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

### САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ (үргэлжлэл)

#### Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

*Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан г.м)-тэй холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

*Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө* – Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсны илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй. Бодит үнэ цэнийн хэмжилтийг өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтыг өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

### Ангилал

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*
- *Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

### Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

*Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр* - Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

*Бусад санхүүгийн өр төлбөр* - Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана. Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

## САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР (үргэлжлэл)

### Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

## КРИПТО ВАЛЮТЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Крипто валютын өртөгт худалдан авсан үнэ болон ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Дараа үеийн хэмжилтийг тухайн худалдан авалтын зорилгоос шалтгаалан худалдан авсан улиралд багтаан гаргасан ТУЗ-ын тогтоолд үндэслэн тайлант үеийн эцэст ашиг, алдагдлаарх эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ. Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтыг бусдад шилжүүлсэн буюу крипто валюттай холбоотой дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.

(а) эрсдэл, өгөөжийг бүрэн шилжүүлсэн; эсвэл

(б) бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлээгүй түүнийг гэрээний үндсэн дээр шилжүүлсэн.

### Хөрөнгө оруулалтын зорилгоор худалдан авсан койн

Гадаадын болон дотоодын арилжааны эсвэл хэрэглээний шинж чанартай токен, койны худалдан авалтыг бусад санхүүгийн хөрөнгө хэсэгт тусгаж бүртгэнэ. Койныг бүртгэхдээ бодит үнэ цэнийг ашиглах ба тайлант хугацааны төгсгөлд дараах шалгуурыг хангасан хөрөнгийг бусад дэлгэрэнгүй орлогоор, бусад хөрөнгийг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Худалдан авсан койн нь стратегийн төлөвлөгөөний нэг хэсэг
- 3 буюу түүнээс дээш сарын хугацаанд буцааж зарахгүй нөхцөлтэй
- Тухайн төслөөс мөнгөн бус бусад үр өгөөж хүлээж байгаа

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

### Хоёрдогч зах зээлээс худалдан авсан койн

Эх койныг хоёрдогч зах зээлээс худалдан авсан тохиолдолд бусад койны хөрөнгө оруулалтын адилаар өртгөөр нь анх хүлээн зөвшөөрөх ба бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийн аргаар бүртгэнэ.

## САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ, УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Гадаад болон дотоодын зах зээлээс түүхий эд материал худалдан авахаар төлсөн төлбөр, бусад бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид төлсөн урьдчилгааг нэрлэсэн үнээр нь хэмжиж, урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооны хэсэгт нэрийн данс нээж бүртгэдэг.

Дараа тайлангийн тооцоог цаг алдалгүй хийх шаардлагатай зардлын гүйлгээнд зориулан эрх бүхий ажилтантай хийх ба урьдчилан гарсан төсөвт үндэслэн мөнгийг олгож дараа тайлангийн тооцоо дансанд бүртгэнэ. Тухайн гүйлгээтэй холбоотой тайланг хүчин төгөлдөр дэмжих баримтын (байгууллагын регистр дээр бүртгэгдсэн e-barimt) хамт ажлын 5 (тав) хоногт багтаан тооцоогоо хийх ба хийгээгүй тохиолдолд дараа сард тухайн ажилтны нэр дээр авлагын дансанд бүртгэнэ. Ажилтнаас авах авлага дансанд бүртгэхдээ Санхүү Эрхэлсэн Захирал болон тухайн ажилтанд тус тус бичгээр мэдэгдэл хүргэнэ.

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Компани нь үндсэн үйл ажиллагаанд 1-ээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж буй биет хөрөнгийг үндсэн хөрөнгөд ангилж бүртгэнэ. Үүнд барилга байгууламж, авто машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, дуусаагүй барилга байгууламж, бусад хөрөнгүүд орно. Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрдэнэ. Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд тусгана.

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### ҮНДСЭН ХӨРӨНГӨ (үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцно. Ингэхдээ ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн онцлогоос шалтгаалж дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Авто тээврийн хэрэгсэл - 10 жил
- Тавилга, эд хогшил - 5 жил
- Тоног төхөөрөмж - 2 жил
- Компьютер, дагалдах төхөөрөмж - 2 жил
- Бусад үндсэн хөрөнгө - 2 жил.

## САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

Компанийн нийт өр нь богино болон урт хугацаат өр төлбөрүүдээс бүрдэнэ. Өр төлбөрүүдийг байгууллага, хувь хүмүүст өгөх өглөг, банкны богино хугацаат зээл, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг болон бусад богино хугацаат өглөг, банкны урт хугацаат зээл гэж ангилсан.

Өр төлбөрийг нэрлэсэн үнээр бүртгэж тайлагнана. Тайлант онд компаниас төлөх өр төлбөрүүдэд хөнгөлөлт ба хасагдуулга тооцогдоогүй.

## ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувь нийлүүлэгчдээс компанид анх оруулсан хөрөнгө нь энгийн хувьцаа бөгөөд нэмж оруулсан хөрөнгө байхгүй. Тайлангийн өмнөх үеийн ба тайлант оны хуримтлагдсан ашгийг тооцоологдсон дүнгээр хүлээн зөвшөөрч өөрийн хөрөнгийн бүлэгт тусган үзүүлнэ.

Компани нь халаасны хувьцааны худалдан авалтыг бүртгэх өртгийн аргыг ашиглана. Халаасны хувьцааны худалдан авалтыг худалдан авсан өдрийн өртөг дээр суурилан бүртгэнэ.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## НОГДОЛ АШИГ

Ашгаас хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагчдад хуваарилагдах хэсгийг ногдол ашиг гэнэ. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Компани нь ногдол ашгийг мөнгөөр, хувьцаагаар, эд хөрөнгөөр хуваарилж болно.

Компанийн нь энгийн хувьцааны ногдол ашгийг компанийн ашгийн түвшинд үндэслэн, давуу эрхтэй хувьцааны ногдол ашгийг нэрлэсэн үнийн тодорхой хувиар хуримтлалтай байдлаар хувьцаа эзэмшигчдэд хуваарилна. Тайлант онд ноогдол ашиг зарлаагүй байна.

## ОРЛОГО

Компани нь өөрийн дүрэм болон гэрчилгээнд заасан үйл ажиллагааны орлогыг энэ хэсэгт бүртгэдэг. Ингэхдээ СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-ыг мөрддөг.

Орлогыг аливаа хөнгөлөлт, үнэ цэнийн бууралт, борлуулалттай холбоотой бусад төлбөрийг хассаны дараа хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж үнэлнэ.

Компанийн үзүүлж буй үйлчилгээ нь хоёр гүйцэтгэлийн үүргээс бүрдэх ба тэдгээр нь токен болон түүнд дагалдах хэтэвчний үйлчилгээ юм. Компанийн борлуулалтын гэрээнд тусгагдаагүй боловч гэрээ хийгдэх буюу борлуулалт хийгдэх үед олон нийтэд нээлттэй цацагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө болох Whitepaper-т тусгагдсаны дагуу дээрх гол гүйцэтгэлийн үүргүүд үүссэн болно.

Компанийн үйл ажиллагааны орлогыг хүлээн зөвшөөрөхдөө СТОУС 15-ын дагуу дараах алхмуудын дагуу хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- Худалдан авагчидтай хийсэн гэрээг тодорхойлох;
- Гэрээнд тусгагдсан гүйцэтгэлийн үүргийг тодорхойлох;
- Гүйлгээний үнийг тодорхойлох;
- Гүйлгээний үнийг гэрээний дагуу гүйцэтгэлийн үүрэгт хуваарилах; болон
- Компани тухайн гүйцэтгэлийн үүргийг биелүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрөх.

Орлогыг амласан бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтын эрх шилжсэн тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Компанийн гол орлогын эх үүсвэр нь борлуулсан токен ба түүнийг аюулгүй байдал, арилжааны боломжоор хангасан хэтэвчний борлуулалтын орлого юм.

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогыг Орлогын тайланд нийт борлуулалтын хэсэгт, борлуулалтын хөнгөлөлт, борлуулалтын буцаалт, үнийн бууралтыг нийт борлуулалтын дор сөрөг утгатайгаар, харин үлдсэн үйл ажиллагаанаас гадуур олсон орлогыг Үйл ажиллагааны бус орлого хэсэгт тайлагнаж харуулна.

## БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Үндсэн үйл ажиллагааны орлого олохтой холбоотой шууд зардлуудыг хуримтлуулан уг дансанд бүртгэж толилуулна. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг борлуулсан барааны өртгөөс буцаасан барааны өртгийг хассан дүнгээр тооцож хуримтлуулан бүртгэнэ.

## ОЛЗ, ГАРЗ

Олз, гарз нь үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад хөрөнгүүдийг данснаас хасах үед үүсэж болно. Эдгээрээс гадна ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөхөөр заасан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнээс олз, гарз үүсдэг. Олз, гарзыг холбогдох стандартад заасны дагуу хэмжиж тайлагнах ба шаардлагатай тодруулгуудыг мөн санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт хийнэ.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## ЗАРДАЛ

Компани зардлаа НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга-д заасны дагуу үүргээр нь ангилж тайлагнана. Зардлуудыг борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардал гэж ангилна. Зар сурталчилгаа, сургалттай холбоотой зардлуудыг борлуулалт маркетингийн зардлаар, ажилчдын цалин, ХХОАТ болон НДШ, үйл ажиллагаа явуулахтай холбоотой бусад ерөнхий зардлуудыг ерөнхий ба удирдлагын зардлаар, банк, санхүүгийн байгууллагатай холбоотой зардлыг санхүүгийн зардлаар, эдгээр ангилалд орохгүй зардлуудыг бусад зардлаар толилуулна.

## ТАТВАР

Компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгддөг бүх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль гэх мэт.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## 4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Кассанд байгаа бэлэн мөнгө | - | - |
| Харилцах дансанд байгаа мөнгө MNT | 323,094,200.00 | 22,021,481.55 |
| ДҮН | 323,094,200.00 | 22,021,481.55 |

## 5. ТАТВАР, НДШ –ИЙН АВЛАГА

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| НӨАТ-ын авлага | - | 86,724,672.13 |
| ДҮН | - | 86,724,672.13 |

## 6. БУСАД АВЛАГА

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Ажиллагсдаас авах авлага | 69,985,800.00 | 70,278.79 |
| Бусдад олгосон зээл | - | 550,000,000.00 |
| Хүүгийн авлага | - | 46,986,301.37 |
| ДҮН | 69,985,800.00 | 597,056,580.16 |

***Тайлбар:. Бусад харилцагчдаас авах авлагын дүнд хувь хүмүүсээс авах авлага 550,000.0 мянган төгрөг болон хүүгийн авлага 46,986.3 мянган төгрөгийг бүртгэсэн.***

## 7. БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Тэнгэрлэг Медиа Групп ХК (TNGR) | 4,042,000,000.00 | 1,078,200,000.01 |
| ДҮН | 4,042,000,000.00 | 1,078,200,000.01 |

***Тайлбар: Өмнөх тайлант хугацаанд Тэнгэрлиг Медиа групп ХК-ийн 180.0 мянган ширхэг хувьцааг худалдан авсан. Уг хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх санхүүгийн хөрөнгө гэж үзэн санхүүгийн тайланд тусгасан. Бодит үнэ цэнийн мэдээллийг Монголын Хөрөнгийн биржийн тайлант хугацааны эцсийн өдөр буюу хамгийн сүүлийн гүйлгээ гарсан өдрийн хаалтын ханшаар тооцсон.***

## 8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 9,269,026,300.00 | 8,370,947,732.72 |
| ДҮН | 9,269,026,300.00 | 8,370,947,732.72 |

***Тайлбар: Урьдчилж төлсөн тооцоо дансанд дараагийн тайлант хугацаанд хөрөнгө болох магадлалтай урьдчилгаа төлбөрүүдийг хуримтлуулан бүртгэсэн байна. Ирээдүйн тайлант хугацаанд зар сурталчилгааны зардал, листинг зардал болон үйл ажиллагааны зардал болохоор хүлээгдэж буй дүнг Урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан бүртгэсэн.***

## 9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

| ҮЗҮҮЛЭЛТ | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | НЭМЭГДСЭН | ХАСАГДСАН | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|---|---|
| Тээврийн хэрэгсэл | 132,000,000.85 | - | - | 132,000,000.00 |
| Тавилга, эд хогшил | 31,453,608.56 | - | - | 31,453,608.56 |
| Компьютер бусад хэрэгсэл | 140,201,519.77 | - | - | 140,201,519.77 |
| ДҮН | 303,655,128.18 | - | - | 303,655,128.33 |

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Тээврийн хэрэгсэл | 6,871,232.88 | 33,271,232.88 |
| Тавилга, эд хогшил | 2,401,382.69 | 8,692,104.41 |
| Компьютер бусад хэрэгсэл | 66,026,913.61 | 140,201,519.77 |
| ДҮН | 75,299,529.18 | 182,164,857.06 |

## 10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Компьютерийн программ хангамж | 18,181,800.00 | 18,181,818.20 |
| Хуримтлагдсан хорогдол | - | - |
| ДҮН | 18,181,800.00 | 18,181,818.20 |

## 11. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| “Ихбит испорт си эс гөү” ХХК -д оруулсан хамтын хөрөнгө оруулалт | 294,890,000.00 | 294,890,000.00 |
| “Ай Эйч Си Мобайл гэйминг” ХХК-д оруулсан хамтын хөрөнгө оруулалт | 500,000,000.00 | 500,000,000.00 |
| "Икс мета" ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт | 2,000,000,000.00 | 2,000,000,000.00 |
| "Рүүт лийф" ХХК-д оруулсан хамтын хөрөнгө оруулалт | 1,560,000,000.00 | 1,620,000,000.00 |
| “Ай Эйч Си капитал” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт | 2,500,000,000.00 | - |
| ДҮН | 6,854,890,000.00 | 4,414,890,000.00 |

***Тайлбар: Хамтын хяналттай хөрөнгө оруулалтын эзэмшлийн хувь хэмжээ, хуулийн этгээдийн хэлбэрийг доор хүснэгтэн мэдээлэл харуулна. Өмнөх онд “Ай Эйч Си капитал” ХХК-д оруулсан 2,500,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг буцаан татсан.***

| ҮЗҮҮЛЭЛТ | Хөрөнгө оруулалтын хэлбэр | Эзэмшлийн хувь | 2023.12.31 |
|---|---|---|---|
| “Ихбит испорт си эс гөү” ХХК -д оруулсан хамтын хөрөнгө оруулалт | Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт | 51% | 294,890,000.00 |
| “Ай Эйч Си Мобайл гэйминг” ХХК-д оруулсан хамтын хөрөнгө оруулалт | Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт | 51% | 500,000,000.00 |
| "Икс мета" ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт | Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт | 100% | 2,000,000,000.00 |
| "Рүүт лийф" ХХК-д оруулсан хамтын хөрөнгө оруулалт | Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт | 53% | 1,620,000,000.00 |
| ДҮН | | | 4,414,890,000.00 |

## 12. ДАНСНЫ ӨР ТӨЛБӨР

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Төлөгдөх хугацаандаа байгаа | 5,162,883,700.00 | 3,969,046,750.85 |
| ДҮН | 5,162,883,700.00 | 3,969,046,750.85 |

***Тайлбар: Компанийн үйл ажиллагааг бусад холбоотой талуудын үйл ажиллагаатай уялдаатайгаар зохион байгуулдаг ба дансны өр төлбөрийн дийлэнх хэсгийг бусад талуудад өгөх өр төлбөр эзэлж байна. Бусад талуудад өгөх өр төлбөрт IHC койныг биржүүдэд лист хийх болон бусад шууд хамааралтай зардлуудын төлөгдөөгүй үлдэгдлийг багтаасан болно. Компани 2021 онд IHC койныг блокчейн системд хөгжүүлж гаргасан хувь хүнтэй хийсэн гэрээний дагуу 1,000,000 ам.доллар өгөх үүрэг хүлээсэн. Гэрээнд заасны дагуу Компани уг төлбөрийг 2022 оны 09 дүгээр сард төлж дуусгах ёстой боловч аудитын дүгнэлт гарах өдөр гүйцэтгэгч талд өгөх ам.доллароос огт төлөөгүй байна.***

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## 13. ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Цалингийн өглөг | 2,441,500.00 | - |
| ДҮН | 2,441,500.00 | - |

## 14. ТАТВАР, ХУРААМЖИЙН ӨГЛӨГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| ХХОАТ-ын өр | 2,162,031,000.00 | 149,250,860.53 |
| НӨАТ-ын өр | - | 588,314,513.96 |
| ААНОАТ-ын өр | - | 572,527,685.62 |
| Хойшлогдсон татварын өр | - | 2,524,931.51 |
| НДШ-ийн өглөг | - | 38,568,308.82 |
| ДҮН | 2,162,031,000.00 | 1,351,186,300.44 |

## 15. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Урьдчилж орсон орлого | 463,700.00 | 463,679.99 |
| ДҮН | 463,700.00 | 463,679.99 |

## 16. ӨМЧ

| ҮЗҮҮЛЭЛТ | ЭРГЭЛТЭД БАЙГАА БҮРЭН ТӨЛӨГДСӨН ЭНГИЙН ХУВЬЦАА | | ХАЛААСНЫ ХУВЬЦАА | | ӨМЧИЙН ДҮН (ТӨГРӨГӨӨР) |
|---|---|---|---|---|---|
| | ТОО ШИРХЭГ | ДҮН (ТӨГРӨГӨӨР) | ТОО ШИРХ ЭГ | ДҮН (ТӨГРӨГӨӨР) | |
| Эхний үлдэгдэл | 700 | 70,000.00 | - | - | 70,000.00 |
| Нэмэгдсэн | - | - | - | - | - |
| Хасагдсан | 17.5 | 17,500.00 | - | - | - |
| ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | - | 52,000.00 | - | - | 52,000.00 |

*Тайлбар: Хувьцаа халаасалсан талаар дэлгэрэнгүйг Тодруулга 1-ээс харна уу.*

## 17. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийн нөөц | 516,798,000.00 | (1,447,002,000.00) |
| ДҮН | 516,798,000.00 | (1,447,002,000.00) |

*Тайлбар: Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжих санхүүгийн хөрөнгөөр ангилж бүртгэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн орлогыг илэрхийлнэ.*

## 18. ХҮҮГИЙН ОРЛОГО

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Хүүгийн орлого | - | 21,986,301.37 |
| ДҮН | - | 21,986,301.37 |

*Тайлбар: Хүүгийн орлогод хувь хүнд олгосон зээлийн хүүний авлагыг хуримтлуулан бүртгэсэн.*

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## 19. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Цалингийн зардал | - | 105,776,797.47 |
| НДШ-ийн зардал | - | 13,174,499.68 |
| Түрээсийн зардал | - | 3,558,916.36 |
| Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | - | 12,375,874.61 |
| Харилцаа холбоо, шуудан үйлчилгээний зардал | - | 1,509,090.92 |
| Банкны шимтгэл | - | 215,256.40 |
| Элэгдлийн зардал | - | 25,771,169.08 |
| Томилолтын зардал | - | 55,499,405.05 |
| ДҮН | - | 217,881,009.57 |

## 20. БУСАД ЗАРДАЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Бусад зардал | - | 263,276,615.00 |
| ДҮН | - | 263,276,615.00 |

## 21. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ (ГАРЗ)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| Валютын ханшийн зөрүүний гарз | - | (9,560,000.00) |
| ДҮН | - | (9,560,000.00) |

## 22. ХОЛБООТОЙ ТАЛЫН ТОДРУУЛГА

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээнээс хамаарч гарсан тооцооны үлдэгдлийг харуулбал:

| Урьдчилж төлсөн тооцоо: | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| "Икс мета" ХХК | 2,207,703,200.00 | 1,227,851,710.70 |
| "Ихбит испорт си эс гөү" ХХК | 221,620,424.00 | 497,912,723.00 |
| Дүн | 2,735,615,923.00 | 1,725,764,433.70 |

| Холбоотой талуудад өгөх өр төлбөр: | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|
| "Икс мета" ХХК | 989,911,489.30 | 42,760,000.00 |
| Хувьцаа эзэмшигчид төлөх өр төлбөрийн тооцоо | 1,861,097.82 | 5,043,259.89 |
| Дүн | 991,772,587.12 | 47,803,259.89 |

## 22. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30

## 23. ТАЙЛАГНАЛЫН ДАРАА ҮЕИЙН ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр бэлтгэсэн. Тасалбар болгосноос хойш тайлант хугацааны үлдэгдлийг залруулах үйл явдал гараагүй.

Хараат бус аудиторын тайланг тодруулгын хамтаар монгол хэлээр 2 хувь бэлтгэсэн бөгөөд хуулбарт утгын зөрүү гарвал эх хувийг баримтлах болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.06.30


"ИНТЕР АУДИТ" ХХК

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

# ТЕХНОЛОГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ (Шинэчилсэн)

CERTIK

# Аюулгүй байдлын үнэлгээ

# IHC Токен #2 (шинэчилсэн)

2022 оны 5-р сарын 26



## Агуулга

Товч
Тойм
- Төслийн товч танилцуулга
- Аудитын товч
- Сул талын товч
- Аудитын хамрах хүрээ

Үр дүн
- IHT-01 : ihc_токен.сол-ий төвлөрүүлэлтийн эрсдэл
- IHT-02 : Токены анхны хуваарилалт
- IHT-03 : Дутуу дээд хязгаар
- IHT-04 : Ашиглагдаагүй хувилбарууд
- IHT-05 : Emit event/параметр дамжуулалт байхгүй

Хавсралт
Мэдэгдэл
Тайлбар

*“Эксодас” Орчуулгын товчоо*
*Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол*
*Престиж төв, 302 тоот*
*Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг*

CERTIK Англи – Монгол орчуулга
IHC Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

## Товч танилцуулга

Энэхүү тайланг IHC Токен #2 (шинэчилсэн)-т зориулан, IHC Токен #2 (шинэчилсэн) төслийн эх кодын асуудал, сул талуудыг илрүүлэх, мөн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн програмын санд хамаарахгүй харилцагчийн үүргийг илрүүлэх зорилгоор бэлтгэв. Статик анализ болон гар аргаар шалгах дүгнэлтийн арга техник ашиглан цогц шинжилгээ үйлдэв.

Аудитын үйл ажиллагаа нь дараах асуудалд онцгой анхаарал хандуулан авч үзэв. Үүнд:

- Нийтлэг болон нийтлэг бус халдлагын вектороос хамгаалах ухаалаг гэрээг шалгаж үзэх.
- Салбарын стандарт бөгөөд шилдэг арга туршлагад нийцэж буй эсэхийг нягтлахын тулд кодын
- бааз суурийг үнэлэх

  Гэрээний учир зүй нь үйлчлүүлэгчийн техникийн үзүүлэлт, санаа зорилгод нийцэж буй эсэхийг нягтлах
- Гэрээний бүтэц, хэрэгжилтийг салбартаа тэргүүлэгчдийн гаргасан төсөөтэй ухаалаг гэрээнүүдтэй жишиж харьцуулах.
- Салбарын мэргэжилтнүүдээр кодын бааз суурийг бүхэлд нь мөр мөрөөр нь нэг бүрчлэн хянуулах.

Аюулгүй байдлын үнэлгээний дүнд үндсэн чухлаас эхлээд мэдээллийн чанартай асуудлууд илрэв. Бид эдгээр асуудлуудыг аюулгүй байдлын өндөр түвшний стандартыг хангаж, салбарын жишигт нийцүүлэхийн тулд шийдвэрлэх зохилтой хэмээн зөвлөж байна. Аюулгүй байдлын үүднээс төслийн ирээдүйд илүү сайнаар нөлөөлөх зөвлөмжүүдийг санал болгож байна:

- Эх кодын бүтцийг сайжруулахын тулд ерөнхий кодыг бэхжүүлэх; Ашиглалтын боломжит
- тохиолдлуудыг хамаарахын тулд нэгжийн тестийг хангалттай нэмэх;
- Ялангуяа олон нийтэд баталгаажуулсан гэрээнд бэлэн байдлын функцын тайлбаруудыг нэмэх;
- Протокол хэрэгжиж эхэлмэгц давуу эрхтэй үйл ажиллагааны ил тод байдлыг илүү хангах.

*“Эксодас” Орчуулгын товчоо*
*Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол*
*Престиж төв, 302 тоот*
*Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг*

# Тойм

## Төслийн товч агуулга

| | |
|---|---|
| Төслийн нэр | IHC Токен #2 (шинэчилсэн) |
| Платформ | Ethereum |
| Хэл | Нэгдмэл |
| Кодын бааз суурь | https://github.com/IHC-Token/token-source-code/commit/73dcbf63fcfaf76abe17dd1be6fb239bbd455d0f |

## Аудитын товч

| | |
|---|---|
| Хүргэх огноо | 2022.05.26 |
| Аудитын арга зүй | Статик Анализ, Гар аргаар шалгах |

## Сул талын товч

| Сул талын түвшин | Нийт | Хүлээгдэж буй | Татгалзсан | Зөвшөөрсөн | Хөнгөвчилсөн | Хэсэгчлэн шийдвэрлэсэн | Шийдвэрлэсэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| Онц чухал | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Томоохон | 2 | 0 | 0 | 1 | 1 | 0 | 0 |
| Дунд зэргийн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бага зэргийн | 2 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| Мэдээллийн | 1 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| Хэлэлцүүлэг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

*"Эксодас" Орчуулгын товчоо*
*Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол*
*Престиж төв, 302 тоот*
*Утас: 96009285, Орчуулагч: В.Батцэцэг*

CERTIK
*Англи – Монгол орчуулга*
IHC Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

## Аудитын хамрах хүрээ

| Дугаар | Файл | SHA256 Хяналтын нийлбэр дүн |
|---|---|---|
| IHT | projects/ihc/contracts/ihc_token.sol | cd5eeacc77c3c19ae7a6dc580e5ee051295189142567c8ef0713b532be19781c |

*"Эксодас" Орчуулгын товчоо*
*Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол*
*Престиж төв, 302 тоот*
*Утас: 96009285, Орчуулагч: В.Батцэцэг*

CERTIK
*Англи – Монгол орчуулга*
IHC Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

# Үр дүн




| | |
|---|---|
| Үндсэн чухал | **0** (0.00%) |
| Томоохон | **2** (40.00%) |
| Дунд зэргийн | **0** (0.00%) |
| Бага зэргийн | **2** (40.00%) |
| Мэдээллийн | **1** (20.00%) |
| Хэлэлцүүлэг | **0** (0.00%) |

| Дугаар | Гарчиг | Ангилал | Зэрэглэл | Төлөв |
|---|---|---|---|---|
| **IHT-01** | Ihc_токен.сол-ийн төвлөрүүлэлтийн эрсдэл | **Төвлөрүүлэлт / Давуу эрх** | **Томоохон** | Хөнгөрүүлсэн |
| **IHT-02** | Анхны токен хуваарилалт | **Төвлөрүүлэлт / Давуу эрх** | **Томоохон** | Зөвшөөрсөн |
| IHT-03 | Дээд хязгаар дутуу | Логикийн асуудал | Бага зэргийн | Зөвшөөрсөн |
| IHT-04 | Ашиглаагүй хувилбөр | Логикийн асуудал | Бага зэргийн | Зөвшөөрсөн |
| IHT-05 | Emit Events/параметр дамжуулалт байхгүй | Кодчилолын хэв маяг | Мэдээллийн | Зөвшөөрсөн |

*"Эксодас" Орчуулгын товчоо*
*Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол*
*Престиж төв, 302 тоот*
*Утас: 96009285, Орчуулагч: В.Батцэцэг*

## IHT-01 | Ihc_токен.сол-ын төвлөрүүлэлтийн эрсдэл

| Ангилал | Зэрэглэл | Байршил | Төлөв |
|---|---|---|---|
| Төвлөрүүлэлт / Давуу эрх | Томо охон | projects/ihc/contracts/ihc_token.sol: 316~319, 325~327, 635~640, 645~648, 653~656, 661~664, 669~672, 677~680, 685~688, 694~700, 705~717, 722~725, 730~733, 738~741, 746~749, 754~758 | Хөнгөрүүлсэн |

### Тодорхойлолт

IHC гэрээнд _owner/өмчлөгч нь дор үзүүлсэн графикт үзүүлсэн чиг үүргийг удирдах бүрэн эрхтэй.

_owner/өмчлөгчийн бүртгэл мэдээлэл задарвал хакер үүнийг урвуугаар ашиглаж болзошгүй.













Гэрээнд _owner/өмчлөгч нь дор үзүүлсэн график буй функцуудыг удирдах эрхтэй. _owner/өмчлөгчийн бүртгэл мэдээлэл задарвал хакер үүнийг урвуугаар ашиглаж болзошгүй.




Зөвлөмж

Эрсдэл нь төслийн одоогийн загварыг тодорхойлж, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг сайжруулах, эрх мэдлийг задруулах түвшинг нэмэгдүүлэх чиглэлийг заах буй бөгөөд ихэнх тохиолдолд одоогийн шатанд бүрэн шийдвэрлэх боломжгүй зүйлс юм. Бид үйлчлүүлэгчид хакердуулах эрсдэлээс зайлсхийхийн тулд давуу эрхтэй бүртгэлийн хувийн түлхүүрийг илүү болгоомжтой удирдан зохицуулах зөвлөмж өгч байна. Ерөнхийдөө олон гарын үсэгтэй хэтэвч зэрэг илүү баталгаажуулсан аюулгүй байдлын арга хэрэгсэл бүхий удирдлагын төвлөрлийг задлах буюу жижиг гэрээнд үндэслэсэн бүртгэл ашиглан протокол дахь давуу эрх, үүргийг сайжруулах зөвлөмж өгч байна.

Үүний дагуу, богино хугацаа, урт хугацаанд, мөн байнга өөр өөр түвшинд боломжит эрсдэлийг хөнгөвчлөх үндэслэлтэй зөвлөмжийг энд санал болгов:

## Богино хугацаанд:

Timelock ба Multi sign (⅔, ⅗)-ыг хослуулснаар давуу эрх шаардах үйл ажиллагааг хойшлуулж, удирдлагын нэг цэгт төвлөрсөн алдаа гарахаас сэргийлэн *хөнгөвчилнө*.

- Давуу эрх бүхий үйл ажиллагааг анхааруулах үүднээс Time-lock-ыг 48 цаг зэрэг хугацаагаар зохих хэмжээнд хойшлуулах; БА
- Хувийн түлхүүр алдагдах зэрэг нэг цэгийн алдаа гарахаас сэргийлэхийн тулд давуу эрх эзэмшигчдэд олон гарын үсэгтэй хэтэвч оноох;
  БА
- timelock гэрээ ба multi-signers-ийн хаягийн мэдээллийг олон нийтийн хэрэглэгчидтэй хуваалцах хэрэгсэл/блогийн холбоос.

## Урт хугацаанд:

Timelock ба DAO-ыг хослуулснаар давуу эрхийн төвлөрлийг сааруулах, ил тод байлгах арга хэмжээ аван *хөнгөвчлөх*.

- Давуу эрх бүхий үйл ажиллагааг анхааруулах үүднээс Time-lock-ыг 48 цаг зэрэг хугацаагаар зохих хэмжээнд хойшлуулах;БА
- Ил тод байдал, хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх DAO/засаглал/санал өгөх модулийг нэвтрүүлэх.БА
- timelock гэрээ ба multi-signers-ийн хаяг, DAO-ийн мэдээллийг олон нийтийн хэрэглэгчидтэй хуваалцах хэрэгсэл/блогийн холбоос.

## Байнгын:

Өмчлөлийг цуцлах буюу функцийг алга болгохыг *бүрэн шийдвэрлэсэн* гэж үзэж болно.

- Өмчлөлийг цуцлах болон давуу эрхийг буцааж олгохгүй байх.
  БУЮУ
- Эрсдэлтэй функц,чиг үүргийг арилгах.

## Хөнгөвчлөх

Multisig мэдээлэл: https://medium.com/@cto_13966/ihc-multisig-technology-152ad806d0b8
Multisig хаяг: https://bscscan.com/address/0x3c1fb9cf3419c570df34a267c3b7e7eb0ab156ee#code

*"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг*



# IHT-02 | Анхны токен хуваарилалт

| Ангилал | Зэрэглэл | Байршил | Төлөв |
|---|---|---|---|
| **Төвлөрүүлэлт / Давуу эрх** | ● **Томоохон** | projects/ihc/contracts/ihc_token.sol: 371 | ⓘ Зөвшөөрсөн |

## Тодорхойлолт

IHC-ийн токенуудыг бүгдийг гэрээг хэрэгжүүлж эхлэхдээ гэрээ хэрэгжүүлэгч рүү илгээдэг. Хэрэгжүүлэгч нь бүлгийн нийтийн зөвшилцөл зөвшөөрлийг авалгүйгээр IHC токеныг түгээж болох тул энэ нь төвлөрүүлэлтийн эрсдэл болно.

## Зөвлөмж

Бид токены анхны түгээлтийн үйл явцад багийн үйл ажиллагаа ил тод байхыг зөвлөж буй бөгөөд баг нь хувийн түлхүүрийн нэвтрэх эрхийг хязгаарлахын тулд зохих бүх арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзэж байна.

*"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг*



# IHT-03 | Дээд хязгаар байхгүй

| Ангилал | Зэрэглэл | Байршил | Төлөв |
|---|---|---|---|
| Логикийн асуудал | ● Бага | projects/ihc/contracts/ihc_token.sol: 645~648 | ⓘ Зөвшөөрсөн |

## Тодорхойлолт

tx хураамжийн хувийн дээд хязгаар байхгүй бөгөөд энэ нь 100% буюу 100%-иас ч илүү байж болох.

## Зөвлөмж

tx хураамжийн зохих дээд хязгаар тогтоохыг зөвлөж байна.

*"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг*

## IHT-04 | Ашиглагдаагүй хувилбарууд

| Ангилал | Зэрэглэл | Байршил | Төлөв |
|---|---|---|---|
| Логикийн асуудал | ● Бага | projects/ihc/contracts/ihc_token.sol: 360~364 | ⓘ Зөвшөөрсөн |

### Тодорхойлолт

Холбоос бүхий хувилбарууд нь хэд хэдэн утгад оноогдсон бөгөөд өмчлөгч өөрчлөх боломжтой болович гэрээнд хаана ч ашиглагдахгүй байна.

### Зөвлөмж

Бид багийг энэ талаар илүү сайжруулалт хийхийг зөвлөж байна.





## IHT-05 | Emit Events/параметр дамжуулалт байхгүй

| Ангилал | Зэрэглэл | Байршил | Төлөв |
|---|---|---|---|
| Кодчилолын хэв маяг | ● Мэдээллийн | projects/ihc/contracts/ihc_token.sol: 325~327, 635~640, 645~648, 653~656, 661~664, 669~672, 677~680, 685~688, 694~700, 705~717, 722~725, 730~733, 738~741, 746~749, 754~758 | ⓘ Зөвшөөрсөн |

### Тодорхойлолт

Төвлөрүүлэлтийн үүргээр хянаж буй давуу эрх шаардлагатай чиг үүрэгт ямагт emit events /параметр дамжуулалт байх нь зүйтэй.

### Зөвлөмж

Төвлөрүүлэлтийн үүргээр хянаж буй давуу эрх шаардлагатай чиг үүрэгт emit events /параметр дамжуулалт байх нь зүйтэй.





# Хавсралт

## Албан ёсны баталгаажуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл

### Техникийн тодорхойлолт

ERC-20 интерфейс хэрэгжүүлдэг төслийн бүх Нэгдмэл ухаалаг гэрээнүүд нь дүн шинжилгээний хүрээнд хамаарч байна. тухайн гэрээ бүр бүх боломжит гэрээний шинж чанарыг тусгасан математикчилсан загварт нэгтгэсэн. Үүнээс үүдэх бүх баталгаажуулалтын үр дүн нь тэр загварт суурилсан ба тэрхүү загварыг тусгайлан теорем баталгаажуулагч, илэрхийллийн загвар шалгагчдын автомат дүн шинжилгээнд нээлттэй байхаар зохиосон. Энэхүү загвар нь ухаалаг гэрээний бүх боломжит шинж чанарыг төлөөлөхөөс гадна гэрээний эхлэл, харилцан үйлчлэлийн хэв маягийг албан ёсоор хэрэгжүүлэх баталгаажуулалтын хэрэгслийг өөртөө нэгтгэсэн байдаг. Тухайлбал, бид олон нийтийн буюу гадны функцийг тодорхой бусаар сонгож, гүйцэтгэлийг нь загварчилдаг баталгаажуулалтын хэрэгслийг ашигладаг. Гэрээний төлөвийг функцийг дуудахаас өмнө дурын байдлаар (жишээлбэл дурын утгаар) эхлүүлдэг. Иймээс математикчилсан загвар нь гинжин хэлхээний аливаа бодит хэрэгжүүлэлтэд гэрээнд хүрч болох төлөвийн орон зайг давуулан багцаалдаг. Ингэснээр баталгаажуулалтын бүх үр дүн нь хэрэгжүүлэлт хийгдсэний дараа гэрээний шинж чанарт дурын төлөвөөр шилжин хүрдэг. Загварыг угсарч дуусмагц манай дүн шинжилгээний хэрэгсэл гэрээнүүдийн бүх гүйцэтгэл нь ухаалаг гэрээний зөвшөөрөгдсөн, зохих бүх шинж чанарыг агуулсан, урьдчилсан тодорхойлсон цогц техникийн үзүүлэлтүүдийг агуулсан болохыг батлахыг оролдоно. Энэхүү аудитын шинжилгээний хүрээнд бид Хамрах хүрээ хэмээх хэсэгт заасан функцуудын үйл ажиллагааг хамарсан 38 зүйлийн техник үзүүлэлтүүдийг ашигласан.

### Таамаглал ба хялбарчлал

Албан ёсны баталгаажуулалтын үед дараах таамаглал ба хялбарчлалыг ашиглав:

- Арилжааны хураамжийг тооцоолоогүй, жишээлбэл гүйцэтгэл арилжааны хураамж байхгүйн улмаас цагаасаа өмнө зогсохгүй гэж таамагласан.
- Эдгээр функцуудыг дуудахаас өмнө гэрээний төлөвийн хувилбарыг дурын байдлаар эхлүүлсэн. Ингэснээр гэрээний тогтмол чанарыг анхааралгүй орхисноор хуурамч эерэг төлөвт хүргэж болзошгүй. Гэвч энэ нь аюулгүй давуулан багцаалдах үйлдэл юм.
- Баталгаажуулалтын хэрэгсэл нь хязгааргүй бүхэл тооны ойлголтыг өгдөг. Хиймэл оюун ухааны арифметикийг суурь тооны төрлийн хоёрт тооноос үүсэх нийцлийн ангиллын үйл ажиллагаагаар загварчилдаг. Энэ нь өгөгдлийн хүрээнээс давсан буюу дутсан өгөгдлийн шинж чанарыг бүрэн илэрхийлдэг.

### Шинж чанарын тодорхойлолтын томъёолол

Энэхүү хэсэгт аудитын шинжилгээний хүрээнд хамарсан 38 албан ёсны техникийн үзүүлэлтийн дэлгэрэнгүйг харуулсан. Бүх шинж чанаруудыг шугаман цагийн логикоор (LTL) илэрхийлсэн. Ингэхдээ бид бүх олон нийтийн ба гадны функцуудыг дуудах, хариулах үйдлүүдийг тус тусдаа цагийн алхмууд гэж үзсэн. Иймээс бидний дүн шинжилгээ нь гэрээний олон нийтийн ба гадны функцуудэд нэвтрэх, гарах үеийн төлөв байдлыг тайлбарлав.

"цаг үргэлж" ( `[]` гэж бичдэг) болон "эцэст нь" (`<>` гэж бичдэг) хэмээх модулийн операторууд ба зөвхөн хоёр боломжит утга бүхий Boolean холбоосуудаас гадна, бид анхдагч баталгааны хүчин төгөлдөр байдлыг тайлбарлах дараах өгүүлэхүүнүүдийг ашиглав. Эдгээрийг салангид цагийн алхам хийгдэх бүрт гэрээний төлөвт үнэлсэн болно:

* started(f, [cond])

`cond.` томъёоллыг хангаж буй төлөв байдалд гэрээний функцийг дуудаж буйг илэрхийлнэ.

* willSucceed(f, [cond])

`cond.` томъёоллыг хангаж буй төлөв байдалд f гэрээний функцийг дуудаж буйг илэрхийлэх ба зөвхөн эргэж буцахгүй гүйцэтгэлийг авч үздэг.

* finished(f, [cond])

`cond.` томъёоллыг хангаж буй төлөв байдалд гэрээний f функцаас эргэж ирж буй гүйцэтгэлийг заана. Энд cond томъёолол нь гэрээний төлөвийн хувилбаруудыг зааж болох ба функцт нэвтрэхээс өмнөх утгыг зааж болно ( old функцийг ашиглах)

* reverted (f, [cond]) Энэ нь гэрээний f функц нь cond томъёоллыг хангаж буй гэрээний онцгой төлөв байдлын улмаас тасалдсаныг харуулна.

Энэхүү аудитын шинжилгээнд гүйцэтгэсэн баталгаажуулалт нь үйл явцын дуудах үйлдлийн урьдач болон дараах нөхцлөөр хязгаарлагдсан. Ашигласан загвар нь гэрээний олон нийтийн ба гадны интерфейсийн дурын байдлаар сонгосон функцийг дуудах хэрэгслээс бүрдсэн. Бүх томъёог функцийг дуудахад хариу үзүүлэх w.r.t. алхмын дагуу дүн шинжилгээ хийсэн.

## ERC-20 функцийн шинж чанарууд `transfer(to, amount)`

### erc20-transfer-correct-amount

transfer(recipient, amount)-ын буцалтгүй дуудалт нь msg.sender хаягийн үлдэгдэл дүнгээс amount дүнг хассан true утгыг буцааж, мөн ижил утгыг recipient хаягийн үлдэгдэл дүн дээр нэмэх үүрэгтэй.

```
[](willSucceed(transfer(to, value), to != msg.sender)
    ==> <> (finished(transfer(to, value),
                   return == true
                   ==> balance[msg.sender] == old(balance[msg.sender]) - value
                       && balance[to] == old(balance[to]) + value)))
```

### erc20-transfer-correct-amount-self



CERTIK Англи – Монгол орчуулга
HC Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

`transfer(recipient, amount)` -ын үл буцах дуудалт нь `true` -ыг эргүүлэн дуудаж, `recipient` дахь хаяг нь `msg.sender`-ийн хаягтай дүйцэж байх ба (жишээ нь автомат шилжүүлэг) `msg.sender` хаягийн үлдэгдлийг өөрчлөхгүй.

```
[](willSucceed(transfer(to, value), to == msg.sender)
   ==> <> (finished(transfer(to, value),
                  return == true
                  ==> balance[to] == old(balance[to]))))
```

## ERC-20 функцийн шинж чанарууд `transferFrom(from, to, amount)`

### erc20-transferfrom-revert-from-zero

`from` параметрт өгөгдсөн хаягийн утга нь тэг хаяг байвал `transferFrom(from, dest, amount)` -ын дуудлага амжилтгүй болох төлөвтэй.

```
[](started(transferFrom(from, to, value), from == 0)
   ==> <> (reverted(transferFrom) || finished(transferFrom, return == false)))
```

### erc20-transferfrom-revert-to-zero

`dest` параметрт өгөгдсөн хаягийн утга нь тэг хаяг байвал `transferFrom(from, dest, amount)` -ын дуудлага амжилтгүй болох төлөвтэй.

```
[](started(transferFrom(from, to, value), to == 0)
   ==> <> (reverted(transferFrom) || finished(transferFrom, return == false)))
```

### erc20-transferfrom-fail-exceed-balance

from хаягийн үлдэгдэл дүнгээс давсан amount утга бүхий transferFrom(from, dest, amount)-ын аливаа дуудлага амжилтгүй болох төлөвтэй.

```
[](started(transferFrom(from, to, value), value > balance[from])
   ==> <> (reverted(transferFrom) || finished(transferFrom, return == false)))
```

### erc20-transferfrom-correct-allowance

"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг

CERTIK Англи – Монгол орчуулга
HC Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

`true` буцаан дуудах `transferFrom(from, to, amount)` ын үл буцах дуудалт нь msg.sender -ын хаягийн олгосон дүнг from хаягт amount үнийн дүнгээр бууруулдаг. Үүнд хоёр онцгой тохиолдлыг авч үзнэ. Үүнд:

1. `type(uint256).max` -тай тэнцэх олгосон дүнг онцгой байдал гэж үзэх ба энэ шалгалтад тэнцэх зорилгоор бууруулах шаардлагагүй хязгааргүй олголт гэж үзнэ.
2. Хэрэв шилжүүлсэн токен эзэмшигч `transferFrom` -ыг цуцалвал (жишээлбэл `msg.sender` дахь хаяг нь `from` дахь хаягтай дүйцэж байвал) бидэнд олгосон дүнгийн шинэчилсэн мэдээлэл шаардлагагүй.

```
[](willSucceed(transferFrom(from, to, value))
   ==> <> finished(transferFrom(from, to, value),
                 return == true
                 ==> ((allowances[from][msg.sender] == old(allowances[from]
[msg.sender]) - value)
                      || (allowances[from][msg.sender] == old(allowances[from]
[msg.sender])
                         && (from == msg.sender
                            || old(allowances[from][msg.sender]) ==
```

## Ангиллыг олох

### Төвлөрүүлэлт / Давуу эрх

Төвлөрүүлэлт / Давуу эрхийн үр дүн нь илээр өмчилж эзэмших буюу тусгай нэвтрэх эрхийг санг дахин хуваарилах механизмтай хослуулах зэргээр эрх мэдлийг үл төвлөрүүлэхийн эсрэг логик буюу хэрэгжүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлнэ.

### Логикийн асуудал

Логикийн асуудлын үр дүн нь block.timestamp хэрхэн ажиллах тухай алдаатай тэмдэглэл зэрэг холбоос бүхий кодын логикийн алдааны тухай дэлгэрэнгүй өгүүлнэ .

### Кодчилолын хэв маяг

Кодчилолын хэв маягийн үр дүн нь ихэвчлэн үүсгэсэн байт-кодод нөлөөлөхгүй бөгөөд харни кодын бааз суурийг хэрхэн илүү тогтвортой, улмаар амархан засварлах боломжтой болгох тухайд саналаа хэлдэг.

## Хяналтын дүнг тооцоолол арга зүй

"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг

"Аудитын хамрах хүрээ" хэсэг дэх "Хяналтын дүн" талбарыг SHA-256 (256 бит нийт хэмжээ бүхий Secure Hash алгоритм 2)-аар тооцоолох ба жагсаалтад буй эх сан дахь файл тус бүрт тусгай үүрэг бүхий байна.

Үр дүн нь арван зургаатаар кодчилогдох бөгөөд зорилтот файлд чиглэсэн Linux "sha256sum" командын үр дүнтэй ижил байна.



CERTIK
Англи – Монгол орчуулга
ІНС Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

# Мэдэгдэл

Энэхүү тайлан нь Үйлчилгээний Гэрээнд заасан нөхцөл болзлууд буюу Гэрээтэй холбогдуулан танд танилцуулсан ("Үйлчлүүлэгч" буюу "Компани") үйлчилгээний хамрах хүрээ, нөхцөл болзлуудын дагуу хийгдсэн (үүнд үйлчилгээний тодорхойлолт, нууцлал, мэдэгдэл, хариуцлагын хязгаарлалт багтах ба эдгээрээр үл хязгаарлагдана). Гэрээнд заасан Үйлчилгээтэй холбогдуулан гаргасан энэхүү тайланг Компани зөвхөн Гэрээний нөхцөл болзлуудын дагуу зөвшөөрөгдсөн хүрээнд ашиглана.

Тус тайланг CertiK-аас тухай бүр урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр аливаа этгээд аливаа зорилгоор дамжуулж, задруулж, шилжүүлж болохгүй бөгөөд хуулбарыг Компаниас бусад этгээдэд илгээж болохгүй.

Энэхүү тайланг аливаа тухайлсан төсөл буюу багийг "баталсан" буюу "үл зөвшөөрсөн" гэж үзэхгүй. Энэхүү тайлан нь  CertiK-тай аюулгүй байдлын үнэлгээ хийлгэх гэрээ байгуулсан аливаа баг буюу төслийн бүтээсэн "бүтээгдэхүүн" буюу "өмч хөрөнгө"-ийн үнэ цэн, үнэлгээг илэрхийлсэн гэж тооцогдохгүй. Тус тайлан нь дүн шинжилгээ хийсэн технологийн вирусээс бүрэн ангид байх шинж чанарын аливаа баталгаа нотолгоо болохгүй буюу технологи өмчлөгчид, бизнес, бизнесийн загвар буюу хууль эрхзүйн нийцлийн илэрхийлэл болохгүй.

Энэ тайланг аливаа төсөлд оролцох буюу хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад ашиглах зориулалтгүй. Энэхүү тайлан нь хөрөнгө оруулалтын ямар ч зөвлөгөө өгөхгүй буюу аливаа төрлийн хөрөнгө оруулалтын зөвлөгөөний хөшүүрэг болгож ашиглахгүй. Тус тайлан нь манай үйлчлүүлэгчид өөрсдийн кодын чанарыг сайжруулахын зэрэгцээ криптограф ик токен, блокчэйн технологийн өндөр эрсдэлийг бууруулахад нь туслах зорилго бүхий өргөн хүрээний үнэлгээний үйл явцыг илэрхийлнэ.

Блокчэйн технологи ба криптограф ик өмч хөрөнгүүд нь байнгын маш өндөр түвшний эрсдэл дагуулдаг. CertiK-ийн зүгээс баримтлах байр суурь бол компани, хувь хүн тус бүр өөрсдийн нягтлан шалгах үүргийг хүлээж, байнгын аюулгүй байдлыг хариуцвал зохино.
CertiK-ийн зорилго нь шинэ тутам бөгөөд үргэлж шинэчлэгдэж буй технологийг ашиглахтай холбогдуулан халдлагын чиглэл, хувилбарын өндөр түвшинг бууруулахад туслах бөгөөд дүн шинжилгээ хийхээр зөвшөөрсөн технологийн чиг үүрэг буюу аюулгүй байдалд ямарваа байдлаар баталгаа олгохгүй.

CertiK-ийн үзүүлсэн энэхүү үнэлгээний үйлчилгээ нь үргэлж сайжран хөгжсөөр байдаг. Та үйлчилгээ, тайлан, материалд нэвтрэх ба/буюу ашиглах эрхийн эрсдэлийг ашиглалтын хугацаанд дангаар хүлээхээр зөвшөөрсөн болно. Криптограф ик токен нь шинэ тутам гарсан технологи бөгөөд техникийн өндөр эрсдэл, тодорхгүй байдлыг дагуулдаг. Үнэлгээний тайланд хуурмаг эерэг үр дүн, хуурмаг сөрөг үр дүн болон бусад тооцоолоогүй үр дүн орсон байж болно. Үйлчилгээ нь гуравдагч этгээдийн олон давхаргаас хамаарч, нэвтэрч болно.

"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг

CERTIK
Англи – Монгол орчуулга
ІНС Токен #2 (шинэчилсэн) Аюулгүй байдлын үнэлгээ

БҮХ ҮЙЛЧИЛГЭЭ, ШОШГО, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, АЖЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БУСАД МАТЕРИАЛУУД БУЮУ ЭДГЭЭРИЙГ АШИГЛАСНААС ҮҮДСЭН ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД НЬ ТУХАЙН ҮЕИЙН НӨХЦӨЛД ХАМААРАХ БӨГӨӨД АЛИВАА АЛДАА, СОГОГТ ЯМАРВАА БАТАЛГАА ӨГӨХГҮЙ. ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ХАМРАХ ДЭЭД ХҮРЭЭНД CERTIK НЬ ҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БУЮУ БУСАД МАТЕРИАЛТАЙ ХАМАА БҮХИЙ АЛИВАА ИЛ, ДАЛД, ХУУЛЬ ЁСНЫ БУЮУ БУСАД БАТАЛГААНААС ТАТГАЛЗАЖ БАЙНА. ДЭЭРХ МЭДЭГДЛИЙГ ЭС ХЯЗГААРЛАН, CERTIK НЬ АРИЛЖАА, ХЭРЭГЛЭЭ, ХУДАЛДААНЫ ЯВЦАД ҮҮСЭХ БҮХ БАТАЛГАА, ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ДАЛД БАТАЛГАА, ТОДОРХОЙ ЗОРИЛГОД НИЙЦЭХ, ЭЗЭМШИХ ЭРХ БА ҮЛ ЗӨРЧИХ БАТАЛГААНААС ТУСГАЙЛАН  ТАТГАЛЗАЖ БАЙНА. ДЭЭРХИЙГ ҮЛ ХЯЗГААРЛАН, CERTIK НЬ ҮЙЛЧИЛГЭЭ, ШОШГО, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, АЖЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БУЮУ БУСАД МАТЕРИАЛУУД, ТЭДГЭЭРИЙГ АШИГЛАСНААС ҮҮДЭХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮР ДҮН НЬ ХЭРЭГЛЭГЧ БУЮУ БУСАД ЭТГЭЭДИЙН ШААРДЛАГАД НИЙЦЭХ, ЗОРЬСОН ҮР ДҮНД ХҮРЭХ, АЛИВАА ПРОГРАМ ХАНГАМЖ, СИСТЕМ, БУСАД ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ НИЙЦЭЖ ТОХИРОХ БУЮУ АЮУЛГҮЙ? ҮНЭН ЗӨВ, БҮРЭН ЦОГЦ, ХОРТОЙ КОД АГУУЛААГҮЙ, АЛДАА МАДАГГҮЙ ГЭСЭН ЯМАР Ч БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛНО. ДЭЭРХИЙГ ҮЛ ХЯЗГААРЛАН, CERTIK НЬ ТУХАЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЬ ХЭРЭЛЭГЧИЙН ШААРДЛАГАД НИЙЦЭЖ, БУСАД ПРОГРАМ ХАНГАМЖ, АППЛИКЭЙШН, СИСТЕМ БУЮУ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ЗОХИЦОН АЖИЛЛАЖ, СААТАЛГҮЙ АЖИЛЛАЖ, ГҮЙЦЭТГЭЛ БУЮУ НАЙДВАРТАЙ БАЙДЛЫН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, АЛДААГҮЙ БАЙХ БУЮУ АЛДААГ ЗАСАЖ БОЛНО ГЭСЭН ЯМАР Ч МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА ГАРГААГҮЙ, ҮҮРЭГ ХҮЛЭЭГЭЭГҮЙ БОЛНО.

ДЭЭРХИЙГ ҮЛ ХЯЗГААРЛАН, CERTIK БУЮУ ТҮҮНИЙ АЛИВАА ТӨЛӨӨЛӨГЧ НЬ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН ОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ, АГУУЛГЫН ҮНЭН ЗӨВ, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ, ХҮЧИНТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ЯМАРВАА МЭДЭГДЭЛ8 БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛНО. CERTIK НЬ ДАРААХ ЗҮЙЛСТ АЛИВАА ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ. ҮҮНД (I) КОНТЕНТЫГ АШИГЛАСНААС ҮҮДЭН ГАРГСАН АЛИВАА ГЭМТЭЛ, ХОХИРОЛ БУЮУ КОНТЕНТЫН АЛДАА, МАДАГ, ЗӨРҮҮ, ЭСВЭЛ (II) ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БУЮУ БУСАД МАТЕРИАЛЫГ АШИГЛАСАН,  НЭВТЭРСНЭЭС ҮҮДЭН ХУВЬ ХҮНД ГЭМТЭЛ УЧИРСАН, ӨМЧ ХӨРӨНГӨ ГЭМТСЭН ТОХИОЛДОЛ.

ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН БҮХ МАТЕРИАЛЫГ ТУХАЙН НӨХЦЛӨӨР ОЛГОХ БА АЛИВАА БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ БУЮУ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ХАМААРАХ МАТЕРИАЛЫГ ЗӨВХӨН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БА ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШИГЧ БУЮУ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН МАТЕРИАЛЫГ ТҮГЭЭГЧ ХООРОНД ГЭЖ ҮЗНЭ.

ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ЭНД ЗААСАН БУСАД МАТЕРИАЛЫГ ЗӨВХӨН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ӨГСӨН БӨГӨӨД ГЭРЭЭНД ЗААГААГҮЙ БУСАД ЗОРИЛГООР АЛИВАА БУСАД ЭТГЭЭДЭД ДААЛГАЖ

"Эксодас" Орчуулгын товчоо
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Престиж төв, 302 тоот
Утас: 96009285, Орчуулагч: Б.Батцэцэг

БОЛОХГҮЙ, ХУУЛБАРЫГ CERTIK-ЭС ТУХАЙ БҮР УРЬДЧИЛАН ЗӨВШӨӨРӨЛ АВАЛГҮЙГЭЭР БУСАД ЭТГЭЭДЭД ХҮРГҮҮЛЖ БОЛОХГҮЙ.

АЛИВАА ГУРАВДАГЧ ЭТГЭЭД БУЮУ ТЭДГЭЭРИЙГ ТӨЛӨӨЛӨГЧ ЭТГЭЭДИЙГ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОН ДАГАЛДАХ МАТЕРИАЛЫН ГУРАВДАГЧ ЭТГЭЭД БУЮУ ЭРХ ХҮЛЭЭН АВАГЧ ГЭЖ ҮЗЭХГҮЙ БӨГӨӨД ГУРАВДАГЧ ЭТГЭЭД НЬ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОН ДАГАЛДАХ МАТЕРИАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН CERTIK-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЯМАРВАА ЭРХГҮЙ БАЙНА.

ЭНЭ ГЭРЭЭНД ЗААСАН CERTIK-ИЙН БАТАЛГАА, МЭДЭГДЛҮҮД НЬ ЗӨВХӨН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТУСЫН ТУЛД ҮЙЛЧИЛНЭ. ИЙМЭЭС ЯМАРВАА ГУРАВДАГЧ ЭТГЭЭД БУЮУ ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛӨГЧ НЬ ЭДГЭЭР БАТАЛГАА МЭДЭГДЛИЙН ГУРАВДАГЧ ЭТГЭЭД, ЭРХ ХҮЛЭЭН АВАГЧ ГЭЖ ТООЦОГДОХГҮЙ БА ГУРАВДАГЧ ЭТГЭЭД НЬ ЭДГЭЭР БАТАЛГАА, МЭДЭГДЛҮҮД БУЮУ ТҮҮНЭЭС ҮҮДЭН ГАРАХ АЛИВАА АСУУДАЛ, ЭНЭ ГЭРЭЭНИЙ НӨХӨН ТӨЛБӨРТЭЙ ХАМААТАЙ АЛИВАА АСУУДАЛД CERTIK-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЯМАРВАА ЭРХГҮЙ БАЙНА.

АЛИВАА ЭРГЭЛЗЭЭГ ҮГҮЙСГЭХ ҮҮДНЭЭС ТОДРУУЛАХАД ТУС ҮЙЛЧИЛГЭЭ, АЛИВАА ХОЛБОГДОХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, МАТЕРИАЛУУДЫГ САНХҮҮ, ТАТВАР, ХУУЛЬ ЭРХЗҮЙ, ДҮРЭМ ЖУРМЫН БУЮУ БУСАД ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГООР АШИГЛАХГҮЙ.





## Тайлбар

Иел болон Колумбын их сургуулиудаас үндэслэн Компьютерын шинжлэх ухааны салбарт 2017 онд байгуулагдсан CertiK нь ухаалаг гэрээ, блокчэйнд үндэслэсэн протоколын аюулгүй байдал, үнэн зөвийг баталгаажуулах үйлчилгээ үзүүлдэг блокчэйний аюулгүй байдлын тэргүүлэх компани юм. Бид дэлхийн түвшинд өрсөлдөхүйц техникийн мэргэжилтнүүдийн үйлчилгээ, өөрсдийн шинэлэг технологийг ашигласнаар тэргүүн зэргийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэн үйлчлүүлэгчийнхээ амжилтыг дэмжихийн зэрэгцээ блокчэйний бүх талбарт баталж болох итгэлийг бүтээх өөрсдийн алсын харааг биелүүлдэг.

CERTIK

IHC INFLATION HEDGING COIN

**БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Олимпийн гудамж, 19-А, “Шангри-Ла”
оффис, 9 давхарт 907 тоот.

Утас: 99052616

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

IHC INFLATION HEDGING COIN